



# Аврагчийн арга бариллаар заах нь

Сайн мэдээний багш бүрийн буюу эцэг эх, албан ёсоор дуудагдсан багш, гэрийн болон айлчлагч багш, Христийн дагалдагч бүрийн зорилго бол Бурханы хүүхдүүдэд Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлэн, Түүнтэй илүү адилхан болоход туслахын тулд сайн мэдээний цэвэр сургаалыг Сүнсээр заах явдал юм.



# Аврагчийн арга барилгаар заах нь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс

ХЭВЛЭВ

Юта муж, Солт Лэйк хот

© 2016 by Intellectual Reserve, Inc.  
Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 10/15.  
Орчуулгын зөвшөөрөл: 10/15.  
*Teaching in the Savior's Way*-ын орчуулга  
Mongolian  
13301 363

## Гарчиг

---

### Оршил

Удиртгал	2
Багшийн зөвлөлийн хурал	3
Аврагчийн арга барилаар заах нь	4

### 1-р хэсэг: Зааж байгаа хүмүүсээ хайрла

Зааж байгаа хүмүүсээ хайрла	6
Хичээлд биш, хүмүүст анхаарлаа төвлөрүүл	7
Хичээлдээ ирэхгүй байгаа хүмүүст хүрч ажилла	8

### 2-р хэсэг: Сүнсээр заа

Сүнсээр заа	10
Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ	12
Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдар	13
Сүнсийг урьдаг орчинг үүсгэ	15
Гэнэт гарч ирсэн заах боломжийг ашигла	16
Төлөвлөгөө гарга	17

### 3-р хэсэг: Сургаалыг заа

Сургаалыг заа	20
Сургаалыг заахад дуу хөгжим, түүх, уран зураг ашигла	22
Хэцүү асуултуудад итгэлээр хариул	23
Хүүхдүүдэд заа	25
Өсвөр үеийнхэнд заа	27

### 4-р хэсэг: Хичээнгүйлэн суралцахад урь

Хичээнгүйлэн суралцахад урь	29
Сүнслэгээр өдөөгдсөн асуулт тавь	31
Сүнслэгээр өдөөгдсөн ярилцлагыг хөтлөн явуул	33
Суралцагчдыг үйлдэхэд урь	35
Гэр орондоо сайн мэдээнээс суралцахыг дэмж	36

### Хавсралт

Христтэй адил багш болон сайжрах нь: Хувийн үнэлгээ	37
Шинэ багш нарыг чиглүүлэх нь: Санваарын болон туслах бүлгийн удирдагчдын үүрэг хариуцлага	38

## Удиртгал

Энэ эх сурвалж дээр дүрсэлсэн зарчмууд нь сайн мэдээний бүх багшид Аврагчийн арга барилаар заахад туслах болно. Энэхүү эх сурвалж бол зөвхөн Сүмийн дуудлага нь заах боломжийг олгосон хүмүүст зориулагдсан болно. Үүнд: Хүүхдийн хэсэг, Ням гараг, Халамжийн нийгэмлэг, Залуу эмэгтэйчүүд, Аароны болон Мелкизедек санваарын чуулгууд мөн санваарын болон туслах бүлгийн удирдагчид орно. Энд өгүүлсэн зарчмууд нь эцэг эх, багш, туслах бүлгийн удирдагчдад гэр орондоо заахад мөн адил тусална.

Багш нар Аврагчийн арга барилаар хэрхэн илүү үр дүнтэй зааж болоход суралцах зорилгоор энэ эх сурвалжийг бие даан судалж болно. Түүнчлэн, тэд энэ эх сурвалжийг гэр бүлийн үдэш, ерөнхийлөгчийн зөвлөлийн болон тойрог эсвэл гадасны зөвлөлийн хурал, сар бүрийн багшийн зөвлөлийн хурал дээр ярилцлагыг удирдан явуулахдаа ашиглаж болно.

Багшийн зөвлөлийн хурлын талаар “Багшийн зөвлөлийн хурал” хэсэгт өгүүлсэн байгаа. Тойргийн зөвлөл нь Ням гаргийн ангийн удирдах

зөвлөлийн тусламжтайгаар эдгээр хуралд хяналт тавьдаг. Ням гаргийн ангийн удирдах зөвлөлийн гишүүн гол төлөв хурлыг удирдан явуулна. Энд байгаа материалыг багшийн зөвлөлийн хурлын суурь болгон ашиглах ёстой.

*Тайлбар:* Энэ эх сурвалж дээрх тойрог, гадсанд өгч буй зөвлөгөө салбар, дүүрэг, номлолд мөн адил хамаатай болно.



## Багшийн зөвлөлийн хурал

Тойрог болгон сар бүр багшийн зөвлөлийн хурлыг хийж байх ёстой бөгөөд уг хуралд багш нар Христтэй адил заах зарчмуудын талаар хамтран зөвлөлдөх боломжтой.

### ЭНЭ ХУРЛЫГ ХЭЗЭЭ ХИЙХ ВЭ?

Багшийн зөвлөлийн хурлыг ням гаргийн гурван цагийн хуваарийн дундуур хийх нь зүйтэй.

■ Ням гаргийн ангийн багш нар Санваарын чуулга, Халамжийн нийгэмлэг, Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн хичээлийн үеэр цугларах нь зүйтэй.

■ Санваарын чуулга, Халамжийн нийгэмлэг, Залуу эмэгтэйчүүдийн ангийн багш нар Ням гаргийн хичээлийн үеэр цугларна.

■ Хүүхдийн хэсгийн багш нар Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн удирдлаган дор, дээр дурдагдсан цуглаануудын аль нэгнийх нь дундуур цугларна. (*Тайлбар:* Шаардлагатай бол Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл Хүүхдийн хэсгийн багш нарт багшийн зөвлөлийн хуралд суух боломжийг олгохын тулд туслах багш нарыг томилон, ангиудыг нийлүүлж эсвэл өөр хэлбэрээр зохион байгуулж болно.)

### ХУРАЛД ХЭН СУУХ ВЭ?

Тойргийн чуулгад эсвэл туслах бүлэгт заадаг бүх хүнээс гадна эдгээр багшийг хариуцдаг хамгийн багадаа нэг санваарын эсвэл туслах бүлгийн удирдагч суух ёстой. Шаардлага гарвал оролцогчид зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээнд тохируулан бүлгүүдэд хуваагдаж болно. Жишээлбэл, зарим тохиолдолд өсвөр үеийнхний эсвэл хүүхдийн багш нар өсвөр үеийнхэн ба хүүхдүүдтэй холбоотой асуудлыг хэлэлцэхээр тусдаа уулзах нь тустай байж болно.

### ЭДГЭЭР ХУРЛЫГ ХЭН УДИРДДАГ ВЭ?

Тойргийн зөвлөл нь Ням гаргийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн тусламжтайгаар багшийн зөвлөлийн хурлын явцад хяналт тавьдаг. Ихэнхдээ Ням гаргийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн хурлын ярилцлагыг удирдан явуулах үүрэгтэй. Зарим тохиолдолд бусад гишүүн хурлыг удирдахаар томилогдож болно.

### БАГШИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ЮУ ХИЙДЭГ ВЭ?

(*Тайлбар:* Эдгээр зааварчилгаа нь ярилцлагыг удирдаж буй хүнд зориулагдсан болно.) Нээлтийн залбирлын дараа багшийн зөвлөлийн хурал дараах загварыг дагах ёстой:

■ *Хамтдаа хуваалцан, зөвлөлд.* Багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцан, тэдэнд заахтай холбоотой асуудлууд тавихад мөн асуудлыг шийдвэрлэхээр бодол санаагаа хуваалцахад урь. Хурлын энэ хэсэгт өмнөх хурлаар үзсэн зарчмуудыг дахин авч үзэж болно.

■ *Хамтдаа суралц.* Багш нарыг энэ эх сурвалжид танилцуулсан зарчмуудыг авч хэлэлцэхэд урь. Тойргийн зөвлөлөөс өөр удирдамж өгөөгүй бол зарчмуудыг ямар ч дарааллаар авч үзэж болох бөгөөд хуралд оролцогчид дараагийн хуралд авч хэлэлцэх зарчмаа сонгоно. Багшийн зөвлөлийн нэг хурлаар зарчмын бүх хэсгийг авч үзэх шаардлагагүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэг зарчмыг хэд хэдэн хурлаар авч хэлэлцэж болно.

■ *Дадлага хий мөн урь.* Зохимжтой гэж үзвэл, ярилцсан зарчмаараа дадлага хийхэд багш нарт тусал. Тэднийг зарчмыг хичээлдээ хэрхэн хэрэгжүүлж болох талаар хүлээн авсан аливаа мэдрэмжээ бичиж тэмдэглэн, тэдгээрийн дагуу үйлдэхэд урь. Үүнд гэр орондоо заахад гаргасан хичээл зүтгэл орно. Тэднийг дараагийн хурлаар ярилцах зарчмаа судалж эхлэхэд урь.

Багшийн зөвлөлийн хурал аль болох ярилцаж байгаа зарчмынхаа дагуу хийгдэх ёстой.



## Аврагчийн арга барилаар заах нь

Та Аврагчийн заах арга барилын талаар бодоход санаанд тань юу орж ирж байна вэ? Та Түүнийг тэнгисийн эрэг дээр олон түмэнд зааж, худгийн хажууд нэгэн эмэгтэйтэй ярилцаж эсвэл нялх хүүхдийг адисалж байгаагаар төсөөлж чадах уу? Та Түүний талаар судраас уншиж байхдаа бусдад зааж, тусалж буй арга замынх нь талаар юу олж харсан бэ? Аврагчийн арга барилаар заах гэдэг нь таны хувьд юу гэсэн утгатай вэ?

### АВРАГЧИЙН ЗААХ АРГА БАРИЛ

Есүс Христ “Би бол зам” (Иохан 14:6) гэж тунхагласан байдаг. Та Аврагчийн амьдрал ба заах боломжуудынхаа талаар тунгаан бодвол, амжилттай багш болох арга зам бол Түүнтэй илүү адилхан болох гэдгийг олж мэдэх болно. Аврагчийн заах арга барил нь Түүний хэн байснаас мөн Түүний өөртөө авч явдаг байсан “Сүнсний хүч”-нээс (Лук 4:14) ирсэн юм. Аврагчийн адил амьдрах нь Түүнтэй адил заах түлхүүр юм.

Тэгэхлээр Тэр хэрхэн амьдарч байсан бэ?

Аврагч хайраар дүүрэн байсан. Аврагч гэмшиж буй нүгэлтэнд урам зориг өгч, шавь нартаа зааж, фарисайчуудыг зэмлэж байхдаа ч хийж байсан бүх зүйл нь хайрын илэрхийлэл байсан юм. Хүмүүсийг мөн тэдний хэрэгцээг хайрласан энэхүү хайр, энэрэл нь Түүнийг тухайн хүмүүсийн хувьд ач холбогдолтой арга замаар заахад хүргэсэн байв. Аврагчийг зааж байхад загасчлах, хүүхэд төрүүлэх, хонио бэлчээх зэрэг амьдралын бодит туршлагууд сүнслэг хичээл болон хувирдаг байв.

Аврагч Эцэгийнхээ хүслийг эрэлхийлэн, дагаж, Эцэгийнхээ сургаалыг заасан байдаг. Есүс хар багаасаа “Эцэгийнхээ гэрт байх ёстой” гэдгээ мэддэг мөн “үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлд[эхийг]”

эрэлхийлдэг байсан. “Миний сургаал бол Минийх биш, харин Намайг Илгээгчийнх” хэмээн Тэрээр хэлсэн байдаг (Лук 2:49; Иохан 8:29; 7:16).

Аврагч Өөрийн ариун тохинууллыг хийхдээ, Бурханы хүүхдүүдийг Түүнд эргүүлэн авчрах үүргээ бүрэн ухамсарласан байсан. Тиймээс Есүс дагалдагчдааа зүгээр л мэдээлэл өгөөд зогсохгүй, тэдэнд итгэлийг нь хүчирхэгжүүлэх, өсөж хөгжихөд нь туслах үүрэг хариуцлагуудыг хүлээлгэн өгсөн юм. Тэр тэдэнд найдан, тэднийг бэлтгэж, бусдад зааж, адисалж, үйлчлүүлэхийн тулд бүх дэлхий рүү илгээсэн юм (Матай10:1, 5–8-ыг үзнэ үү).

Аврагч судруудад хайртай байсан бөгөөд тэдгээрийг Өөрийн тохиуулалд зааж, гэрчлэхдээ ашигладаг байсан. Тэрээр хүмүүст асуултынхаа хариултыг олохын тулд судруудаас эрж хайхыг заасан. Түүнийг Бурханы үгийг хүч чадлаар заахад, хүмүүс судрууд үнэн болохыг мэдэж авсан юм (Лук 24:32-ыг үзнэ үү).

Аврагч заасан зүйлийнхээ дагуу амьдардаг байсан. Тэрээр бүх зүйлд төгс үлгэр дуурайл байсан. Тэрээр дагалдагчидтайгаа хамт залбирснаар тэдэнд хэрхэн залбирахыг заасан (Лук 11:1–4-ийг үзнэ үү). Тэр тэднийг хайрлаж, үйлчилсэн шиг тэд ч бас бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр заасан. Түүний сайн мэдээний дагуу хэрхэн амьдрахыг

Тэр Өөрийн амьдралаар харуулсан юм. Тэрээр ихэвчлэн албаны орчинд заадаг байсан ч, хүмүүсийн гэр оронд, хувийн болон албан бус яриа хөөрөөний хажуугаар бас үргэлж заадаг байсан (Матай 4:23; Марк 14:3–9-ийг үзнэ үү).

Та Аврагчийн арга барилын талаар өөр олон зүйлийг олж мэдэж авах боломжтой. Гэвч үнэхээр Түүний арга барилаар заах хүч чадал зөвхөн Түүний талаар суралцаж, Түүнийг дагах үед ирнэ гэдэгт та итгэлтэй байж болно. Аврагчийн арга барилаар заах урилга нь “Ирж, Намайг дага” (Лук 18:22) хэмээх Түүний урилгын нэн чухал хэсэг юм.

### ТА АВРАГЧИЙН АРГА БАРИЛААР ЗААЖ ЧАДНА

Та бол Есүс Христийн шавь юм. Шавь байхад багшлах, адислах, бусдыг өргөн дэмжих зэрэг үйлдлүүд ордог учраас та багш билээ. Та хэсэг хугацаанд багшлах албан ёсны дуудлага хүлээн авч болох ч, бусдад заах үүрэг хариуцлага, ялангуяа та эцэг эх бол энэ нь үргэлж тантай хамт байх болно. Зарим үед заах үүрэг хариуцлага хэмжээлшгүй их мэт санагддаг. Магадгүй та хангалттай сайн мэдэхгүй гэдэгтээ мөн багшлах туршлага нимгэн эсвэл зүгээр л би “багш байх хүн” биш хэмээн санаа зовж байж магадгүй. Гэхдээ таныг хэн гэдгийг төгс мэддэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн үнэнч дагалдагчийнхаа

### ВИДЕО БИЧЛЭГ ДЭЭРХ ЖИШЭЭ

“Teaching the Gospel in the Savior’s Way” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.







хувьд таныг бусдад юу өгч чадахыг мэдэж байгаа тул таныг заа хэмээн дуудсан. Тэр таныг орхихгүй.

Танд Түүний арга замаар заахад туслах хүч чадал, дэмжлэг туслалцааны олон эх сурвалжаас заримыг доор өгсөн байгаа болно.

*Ариун Сүнсний хүч.* Таныг сайн мэдээний дагуу зохистой амьдрахыг хичээх тусам Ариун Сүнс Бурханы хүслийг танд илчлэх болно. Тэр бусдад суралцахад нь хэрхэн туслахтай холбоотой бодол санаа, сэтгэгдэл, бүтээлч санааг танд өгөх болно. Тэр танд сайн мэдээний аль зарчим дээр анхаарлаа төвлөрүүлэхийг олж мэдэхэд тань туслах болно. Тэр бас таны зааж байгаа хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч, тэднийг өөрчлөхөд сүнслэгээр өдөөх болно. Ариун Сүнс нь танд “Бурханаас ирсэн багш” байхад тусална. Яагаад гэвэл Сүнс нь жинхэнэ багш учраас мөн Сүнс тангтай хамт байх үед та Бурханы хүч чадлаар зааж, хөрвөлтийн гайхамшигийг авчрахад туслах юм (Иохан 3:2; мөн 2 Нифай 33:1-ийг үзнэ үү).

*Таны дуудлагын болон онцгойлон өгсөн адислалын амлалт.* Таны дуудлага хүнээс биш харин Их Эзэнээс ирдэг бөгөөд ерөнхийлөгч Томас С.Монсоны амласнаар, “Их Эзэн дуудсан нэгнээ тохирохоор

болго[дог].”<sup>1</sup> Түүнээс гадна, та санваарын түлхүүр атгадаг хүмүүсийн удирдлаган дор дуудагдсан болохоор амжилттай багш болоход тань хэрэгтэй хувийн илчлэлтүүдийг хүлээн авах эрхтэй. Та эрэлхийлэн, итгэлтэй хэвээр үлдэж, зохистой байхыг хичээх тусам эдгээр адислалыг хүлээн авах болно.

*Залбирлын хүч.* Бидний Тэнгэрлэг Эцэг бидэнд үргэлж нээлттэй байдаг. Та Түүнтэй залбирлаар дамжуулан шууд ярилцах боломжтой. “Миний нэрээр . . . асуугтун, . . . Ариун Сүнс та нарт байх болно” (С ба Г 18:18; мөн С ба Г 42:14-ийг үзнэ үү) хэмээн Аврагч хэлсэн байдаг.

*Таны хайр, авьяас чадвар, туршлага.* Та Бурханы хүүхдүүдийг өөрт байгаа бусдыг хайрлах хайр, Түүний өгсөн бэлэг ба амьдралынхаа туршлага дээр тулгуурлан адисалж чадна. Та итгэл дүүрэн үйлчилж, Бурханы тусламжийг эрэлхийлэхийн хэрээр Тэрээр танд дуудлагаа хичээнгүйлэн биелүүлэхэд тусална. Мөн Аврагчийн арга барилаар сайн мэдээг заах хүч чадал тань өсөн нэмэгдэх болно.

*Бурханы үгийн хүч.* Судрууд дээрх үнэнүүд болон хожмын үеийн бошиглогчдын үгс нь зүрх сэтгэлийг өөрчилж, итгэлийг өсгөн нэмэгдүүлэх хүчтэй. Та болон таны зааж

байгаа хүмүүс “Бурханы үгийн нөлөөлөх хүчийг сори[вол]” энэ нь “шударга . . . түүнийг хийхэд хүмүүсийг удирдахад үгийг номлох нь их нөлөө[тэй]” (Алма 31:5) болохыг олж мэдэх болно.

*Бусдыг хайрладаг удирдагчид.* Санваарын болон туслах бүлгийн удирдагчид таныг амжилтад хүрэхэд туслахыг хүсэж байгаа. Та сайн багш болохыг хичээж, зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээг тунгаан бодож байхдаа тэднээс зөвлөгөө ав.

*Таны зааж байгаа хүмүүсийн хувь нэмэр.* Танай анги дахь хүн бүр сайн мэдээний дагуу амьдрахтай холбоотой гэрчлэл, бодол санаа, туршлагын эх сурвалж болно. Гэднийг нэг нэгэнтэйгээ хуваалцаж, бие биеэ өргөн дэмжихэд урь.

Бурхан таныг дуудсан бөгөөд таныг тохирохоор болгоно гэдгийг үргэлж санаж яв. Сайн мэдээг заах нь Түүний авралын агуу ажлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд “бид Их Эзэний ажлыг гүйцэтгэх үед Их Эзэний тусалцааг авах эрхтэй юм.”<sup>2</sup>

1. Томас С.Монсон, “Duty Calls,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 44.

2. Томас С.Монсон, “Сурах, хийх, байх,” *Ensign*, 2008 оны 11-р сар, 52 эсвэл 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 74-75.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нарыг энэ эх сурвалж дээрх “Христтэй адил багш болон сайжрах нь” нэртэй үнэлгээг бөглөхөд урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Зааж байгаа хүмүүсээ хайрла

(Гарын авлага 2: Сүмийг удирдах нь [2010]), 5.5.4)

Аврагч дэлхий дээрх тохинууллынхаа турш Эцэгээ болон биднийг хайрлахаар өдөөгдсөн байв. Бид Христийн жинхэнэ дагалдагчид байхаар хичээх үедээ Ариун Сүнсний хүчээр дамжуулан ийм хайраар дүүргэгдэх боломжтой (Иохан 13:34–35; Моронай 7:48; 8:26-г үзнэ үү). Бид зүрх сэтгэлдээ Христийнхтэй адил хайрыг агуулснаар Христийн тухай мэдэж мөн Түүнд ирэхэд нь бусдад туслах боломжтой бүхий л арга замыг эрэлхийлэх болно. Хайр нь бидний заах шалтгаан, урам зориг байх болно.

### ЗААЖ БАЙГАА ХҮМҮҮСИЙНХЭЭ ТӨЛӨӨ НЭРИЙГ НЬ ХЭЛЖ ЗАЛБИР

Аврагч “Гэсэн ч итгэл чинь сульдахгүйн тулд Би чиний төлөө залбирсан” (Лук 22:32) хэмээн Петрт хэлсэн.

Хэн нэгний төлөө залбирахад таны сэтгэл ямар болдог вэ? Өөрөөр хэлбэл, залбирал тухайн хүний талаарх таны мэдрэмжинд хэрхэн нөлөөлдөг вэ? Аврагчийн үлгэр жишээг даган, зааж байгаа хүмүүсээс тань хамгийн их гачигдалтай байгаа хүмүүсийн төлөө нэрийг нь хэлж залбир. Тэдний тодорхой хэрэгцээг олж мэдэн, ойлгохын төлөө залбирч мөн Тэнгэрлэг Эцэгээс хэрэгцээнд нь нийцэх зүйлсийг олж мэдэхэд “тэдний зүрх сэтгэлийг бэлтгэхийг” (Алма 16:16) хүс.

**Тунгаан бодох асуулт.** Би зааж байгаа хүмүүсийнхээ төлөө залбирч байхдаа юу мэдэрдэг вэ?

**Судрын жишээ.** Алмагийн зорамчуудын төлөө залбирсан залбирал бусдыг хайрлах талаар надад юу зааж байна вэ? (Алма 31:24–36-г үзнэ үү).

### БУСДЫГ БУРХАНЫ МЭЛМИЙГЭЭР ХАР

Бурхан хүний зүрх сэтгэлийг хардаг учраас Түүний олж хардаг зүйл бидний гаднаас нь хардаг зүйлээс өөр байдаг (1 Самуел 16:7-г үзнэ үү). Та

зааж байгаа хүмүүсээ Бурханы адил харж сурахыг хичээснээр, тэдний тэнгэрлэг үнэ цэнийг олж харахаас гадна тэдэнд өөрийн хүчин чадлыг бүрэн нээхэд туслахын тулд юу хийж болохыг Сүнс танд зааж өгөх болно.

**Тунгаан бодох асуултууд.** Эцэг эх, багш эсвэл бусад зөвлөхийн хайр, итгэл найдвар миний амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ? Миний хайр заахыг хичээж байгаа хүмүүсийг маань хэрхэн өөрчилж чадах вэ?

**Судрын жишээ.** Лук 19:1–10-т цэдэглэгдсэнээр, Аврагч Закхай гэгч хүнийг бусдын хардгаас өөрөөр харсан. Бурхан биднийг хэрхэн хардаг болохыг харуулсан судрын өөр ямар ямар жишээ байдаг вэ?

### ХАЙРАА ИЛЭРХИЙЛЭХ ЭНГИЙН ХИЙГЭЭД ТОХИРОМЖТОЙ АРГЫГ ОЛ

Нөхцөл байдлаас шалтгаалан, зааж байгаа хүмүүсээ чин сэтгэлээсээ сайшаан магтах, амьдралд нь юу болж байгааг сонирхох, тэднийг анхааралтай сонсох, хичээлд татан оролцуулах, тэдэнд үйлчлэх эсвэл тэдэнтэй уулзахдаа энгийн, халуун дулаанаар мэндлэх зэрэг нь хайраа илэрхийлэх арга зам байж болно. Хүмүүст хэрхэн хандах нь тэдэнд заахтай адил чухал зүйл юм.

Зарим үед бид хичээлээ танилцуулахад анхаарлаа хэт хандуулах нь зааж байгаа хүмүүстээ хайраа илэрхийлэхэд саад болдог. Хэрэв танд иймэрхүү зүйл тохиолдвол хамгийн чухал зүйл дээр хэрхэн анхаарлаа хандуулж болох талаар бодож үз. Жишээлбэл, та хичээл эхлэхээс өмнө ангийн гишүүдийг ангид орж ирэхэд нь угтан авах цаг гаргахын тулд ангийнхаа эсвэл туслах бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө нэг гишүүнээс ангийг хичээлд бэлдэж, аудио болон видео бичлэгийн төхөөрөмжийг ашиглахад бэлэн болгохыг хүсэж болно. Түүнээс гадна өрөөг хичээлд бэлтгэхэд ангийн гишүүдтэй хамтран ажиллах нь тэдэнтэй хичээл эхлэхээс өмнө харилцах сайхан боломж гэдгийг та олж мэднэ.

**Тунгаан бодох асуултууд.** Намайг зааж байгаа хүмүүсээ хайрладаг гэдгийг тэд мэддэг үү? Би тэдэнд хайртай гэдгээ хэрхэн нотлон харуулсан бэ? Та хичээлд оролцохгүй байгаа хүнд хүрч ажиллахын тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч зааж байсан хүмүүсээ хэрхэн хайрлаж байсан бэ? (Иохан 13:3–16; 3 Нифай 17-г үзнэ үү). Би зааж байхдаа Түүний үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?

▶ Мөн “Love Those You Teach” видео бичлэгийг үзнэ үү (LDS.org).

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэднээс заахтай холбоотой зүйл асуу.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Урь.** Зааж байгаа хүмүүсээ хайрлах талаар өрнөсөн ярилцлагаас үүдэн, хийхээр сүнсээр нөлөөлөгдсөн зүйлсийнхээ талаар тунгаан бодохыг багш нараас хүс. Хайр халамж хэрэгтэй гэр бүлийн гишүүн, найз нөхөд эсвэл ангийн тань гишүүн болох хэн нэгний

нэр санаанд тань орж ирж болох юм. Тэд эдгээр сүнсний нөлөөллийн дагуу хэрхэн үйлдэж болох вэ?

**Бэлд.** Хамтдаа дараагийн хурлын сэдвийг сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Хичээлд биш, хүмүүст анхаарлаа төвлөрүүл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс “Сайн мэдээний багш нар нь бидний үйлчилдэг Аврагчтай адил, зааж байгаа хүмүүстээ анхаарлаа бүрэн хандуулдаг” хэмээн хэлсэн. “Тэдний анхаарал хоньдын хэрэгцээнд буюу суралцагчдын сайн сайханд бүрэн төвлөрөх болно. Сайн мэдээний багш өөр дээрээ анхаарлыг төвлөрүүлдэггүй. Энэ зарчмыг ойлгодог хүн ойлголт нь суралцагчаас биш, багшийн үзэл бодлоос гарч байгаа мэт харагдуулахгүйн тул дуудлагаа ‘хичээл зааж эсвэл танилцуулж байна’ гэж үздэггүй. Сайн мэдээний багш суралцагчдынхаа хэрэгцээнд анхаарлаа хандуулснаар, хэзээ ч тэдний замд саад болж эсвэл өөрийгөө сайшаан магтаж, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьж, хичээлийг саармагжуулан, Эзэний талаарх тэдний үзэл бодлыг гуйвуулахгүй.”<sup>1</sup>

### ЗААЖ БАЙГАА ХҮМҮҮСЭЭ ОЙЛГОХЫГ ЭРЭЛХИЙЛ.

Сайн мэдээ бүх хүнд зориулагдсан ч ямар ч хоёр хүн үүнийг яг адилхан хүлээн авдаггүй. Зааж байгаа хүмүүсийнхээ ар гэрийн амьдрал, авьяас чадвар, хэрэгцээг ойлгоход танд туслах арга замыг ол. Суралцагчдаас асуун, тэднийг анхааралтай сонсож, өөр өөр нөхцөл байдалд тэд юу ярьж, хийж байгааг ажигла. Хэрэв та өсвөр үеийнхэнд эсвэл хүүхдүүдэд заадаг бол эцэг эхийнх нь бодол ямар байгааг асуу. Юуны өмнө зөвхөн Сүнсний өгч чадах ойлголтыг хүлээн авахын тулд залбир. Та зааж байгаа хүмүүсээ хэдий чинээ сайн ойлгоно, сайн мэдээ тэдний хувийн амьдралд хэрхэн хамаатай болохыг төдий чинээ сайн олж харахад тэдэнд тусалж чадна.

**Тунгаан бодох асуултууд.** Би зааж байгаа хүмүүсийнхээ дундаас хэнийг илүү сайн ойлгох хэрэгтэй вэ? Би түүнийг илүү сайн ойлгохын тулд юуг илүү сайн хийж болох вэ?

**Судрын жишээ.** Иохан 21:1–17 нь Аврагчийн Петрийг ойлгон, хэрэгтэй зүйлийг нь зааж өгсөн арга замын талаар юу зааж байна вэ?

▶ Мөн “Know and Love Us” видео бичлэгийг үзнэ үү (LDS.org).

### ХҮМҮҮСИЙН ТУХАЙ БОДОЖ, ХИЧЭЭЛДЭЭ БЭЛД

Заримдаа багш нар хичээлдээ бэлдэж байхдаа, яг одоо зааж байгаа суралцагчдад өмнө нь зааж байсан хичээл эсвэл ашиглаж байсан үйл ажиллагаа хэрхэн хамаатай болохыг авч үзэлгүй, дахин ашиглахыг хүсдэг. Энэхүү хандлага ихэвчлэн ангийн гишүүдийн онцгой хэрэгцээг харгалзан үздэггүй. Та бэлдэж байхдаа, зааж байгаа хүмүүсийнхээ талаарх өөрийн ойлголтоор төлөвлөгөөгөө гарга. Та өөр өөр суралцагчдад хүрэхийн тулд дуу хөгжим ашиглах, даалгаврыг урьдчилан бэлдэх эсвэл спорт гэх мэт ангийн гишүүний сонирхдог ямар нэг зүйлийн тухай ижил төстэй зүйл хуваалцаж болно. Христэй адил багш нар аливаа загвар эсвэл арга барилд баригддаггүй бөгөөд Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн, Түүнтэй илүү адил болоход хүмүүст туслахын тулд бүхнээ зориулдаг.

**Тунгаан бодох асуулт.** Би зааж төлөвлөгөөгөө ангид буй хэн нэгний онцгой хэрэгцээнд нийцүүлэн хэрхэн өөрчилж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагчийн заах арга барил Түүний зааж байсан хүмүүсийн тодорхой хэрэгцээнд хэрхэн

нийцэж байсан бэ? (Жишээг Марк 10:17–22-оос үзнэ үү).

### БҮХ ЗҮЙЛИЙГ АМЖИЖ ЗААХ ГЭЖ БҮҮ ХИЧЭЭ

Хичээл бүрд авч үзэх хэрэгтэй олон зүйл байдаг ч хэн нэгний зүрх сэтгэлд хүрэхийн тулд хичээлийн нэг цагт бүх зүйлийг амжиж заах шаардлагагүй бөгөөд ихэвчлэн нэг юм уу хоёр гол санааг заах нь хангалттай байдаг. Та суралцагчдынхаа хэрэгцээний талаар тунгаан бодвол, Сүнс аль зарчим, түүх эсвэл судар тэдний хувьд утга учиртай болохыг олж тогтооход тань тусална. Түүнээс гадна Сүнс нь хичээлийн явцад ангийн гишүүдэд яг одоо илүү чухал гэсэн зарчмуудыг ярилцахын тулд төлөвлөгөөгөө өөрчлөх мөн зарим санааг орхих мэдрэмжийг танд төрүүлж болно.

**Тунгаан бодох асуулт.** Тэдний суралцаж байгаа нь хичээлээ зааж дуусгахаас илүү чухал гэдгийг зааж буй хүмүүстээ би хэрхэн харуулах вэ?

**Судрын жишээ.** Би Сургаал ба Гэрээ 98:11–12 дээр дурдсан загвараас зааж сургах талаар юу олж мэдсэн бэ? (Мөн С ба Г 78:17–19-ийг үзнэ үү.)

1. Даллин Х.Өүкс, “Gospel Teaching,” *Ensign*, 1999 оны 11-р сар, 79.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь. Хуваалцахыг хүссэн бүх хүнд боломж олгоход анхаар. Энэ нь хичээлийн бүх материалыг амжиж заахаас илүү чухал юм.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Нэг багшаас ангийн өмнө гарч ирэхийг хүс. Бусад багшийг уг хүний сонирхдог зүйл, авьяас чадварынх нь талаар олж мэдэхэд туслах зүйлсийг асуухад урь. Дараа нь энэ мэдээлэл ангийн өмнө гарч ирсэн

хүний заах арга барилд хэрхэн нөлөөлж болох талаар багш нартай ярилц. Энэ үйл ажиллагааг хичээлийн бэлтгэл, заах арга барилдаа хэрхэн хэрэгжүүлж болгох талаар багш нараас асуу.

**Бэлтгэ.** Хамтдаа дараагийн хурлын сэдвийг сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Хичээлдээ ирэхгүй байгаа хүмүүст хүрч ажилла

Аврагч олон хүнд хандан байнга ярьдаг байсан ч хувь хүнд, тэр дундаа мартагдсан, орхигдсон, шоовдорлогдсон, үл ойлгогдсон хүмүүст анхаарлаа илүү их хандуулдаг байсан. Аврагчийн сургаалт зүйрлэлд гардаг хоньчин алдагдсан нэг хониныхоо араас ерэн есөн хонио бэлчээрт орхин явдгийн адил (Лук 15:4-ийг үзнэ үү) та ч мөн адил хичээлдээ ирэхгүй байгаа хүмүүст хүрч ажиллаж чадна. Таны ангийн гишүүдэд заах, тэднийг дэмжих, Христэд ирэхэд нь тэдэнд туслах боломж зөвхөн ангийнханд болон хичээлд ирдэг суралцагчдын хүрээнд хязгаарлагдах ёсгүй.

### ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ БАЙ

Идэвх султай гишүүдэд хүрч ажиллах нь зөвхөн гэрийн болон айлчлагч багш, санваарын болон туслах бүлгийн удирдагчийн үүрэг хариуцлага байгаад зогсохгүй, багш нар ч мөн адил энэ ажилд туслах боломжтой. Заах нь зөвхөн ням гарагт хичээл заахаас хавьгүй илүү их зүйл шаарддаг. Үүнд хайраар үйлчлэх, бусдад сайн мэдээний адислалуудыг хүлээн авахад туслах зэрэг нь ордог ба энэхүү тусламж ихэвчлэн идэвх султай ангийн гишүүнд хэрэгтэй зүйл байдаг. Бид хэцүү нөхцөлд байгаа хүмүүст хамтдаа хүрч ажиллах хэрэгтэй бөгөөд багшийн хувьд тэдэнд туслах онцгой боломж танд олгогдсон билээ.

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй голын усанд түрэгдэн, аюултай хүрхрээ рүү явж байгаа, залуу эрэгтэйчүүд дүүрэн суулгасан завины тухай нэгэн түүхийг өгүүлсэн байдаг. Эрэг дээр зогсох нэгэн залуу аюултай нөхцөл байдал үүсэж байгааг олж хараад, залуучуудад завиа эргүүл хэмээн хашгирсан боловч хүрхрээ харагдахгүй байсан учраас тэд түүний үгийг үл ойшоов. Тэр дахин анхааруулж хашгирахад, тэд мөн л сэрэмжлүүлгийг тоосонгүй өнгөрөв. Удсан ч үгүй тэд голын ширүүн

урсгалд оржээ. Тэд завиа эргүүлэх гэж эцэж цөхөртлөө оролдсон боловч аль хэдийн оройтсон байж. Ерөнхийлөгч Маккэй “Голын эрэг дээрээс: ‘Хөөе, залуусаа! Өмнө нь чинь аюул байна шүү!’ гэж хашгирах нь нэг хэрэг. Харин голын урсгал руу явж ороод, болж өгвөл тэр залуустай хамт завинд сууж, нөхөрсөг байдлаар мөн ухуулан ойлгуулснаар, . . . завийг ширүүн урсгалаас эргүүлэх нь тэс ондоо зүйл юм. . . . Бүгдээрээ хүмүүсийн амьдрал дунд орж, тэдэнд тусалцаж байя.”<sup>1</sup>

**Тунгаан бодох асуултууд.** Заадаг хүмүүсийн маань хэнд нь хэцүү эсвэл хэн нь хичээлдээ ирэхгүй байна вэ? Би түүнд хүрч туслахын тулд юу хийж чадах вэ? Ангийн бусад гишүүн хэрхэн үүнд тусалж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч хүмүүст хүрч тусалсан талаар уншиж байхад (жишээг Лук 8:43–48; Иохан 4:6–30-ийг үзнэ үү) заадаг хүмүүстээ хүрч туслах талаар Сүнс надад юу заасан бэ?

### СҮНСНИЙ ӨДӨӨЛТИЙГ ЭРЭЛХИЙЛ

Та ангийнхаа гишүүдийн хувийн хэрэгцээний талаар сүнслэг өдөөлт эрэлхийлж байхдаа, хэцүү нөхцөлд

байгаа эсвэл хичээлдээ тогтмол ирж суудаггүй (удирдагчид тань хэнд илүү анхаарал хандуулах хэрэгтэйг олж мэдэхэд тусална) хүмүүсээ мартахгүй байх хэрэгтэй. Хувь хүн олон учир шалтгаанаас болж Сүмийн үйл ажиллагаанд оролцохоо больдог бөгөөд уг шалтгааны ихэнхийг нь олж илрүүлэхэд хэцүү. Гэхдээ Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ мэддэг бөгөөд хайрладаг. Хэрэв та чадах бүхнээ хийсэн бол Тэрээр танд сайн мэдээний дагуу амьдарч чадахгүй байгаа ангийнхаа гишүүдэд хүрч тусан, тэднийг эргэн ирэхэд урих хамгийн оновчтой арга замыг олж мэдэхэд тань туслах болно.

**Тунгаан бодох асуултууд.** Би заахаар томилогдсон бүх хүнийхээ нэрийг мэдэх үү? Би хэцүү нөхцөлд байгаа хүмүүсийнхээ төлөө залбирдаг уу? Би тэдний хэрэгцээг хэрхэн илүү сайн мэдэж болох вэ?

**Судрын жишээ.** Би Иохан 10:14–15, 27–29-өөс зааж байгаа хүмүүсийнхээ талаар Аврагч юу гэж боддог байсан талаар юу сурч мэдэж болох вэ?

### ГЭР БҮЛҮҮДИЙГ ДЭМЖ

Ихэвчлэн сайн, муу аль ч байдлаар хүмүүст хамгийн хүчтэй нөлөөлж чадах хүмүүс бол тэдний гэр орныхон байдаг. Сайн мэдээний дагуу

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Нэг нэгэнтэйгээ хуваалцан, хамтдаа зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс

олон санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах хэрэггүй.

**Дадлага хий.** Багш нарыг ангидаа ирэхгүй байгаа хүмүүст хүрч тусалж

байсан арга замынхаа талаарх санаагаа бие биетэйгээ (жижигхэн бүлэг болж эсвэл хамтдаа) хуваалцахад урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

амьдардаг амьдралын гол цөм нь гэр орон байдаг учраас хэрэв та ангийн тань гишүүдийг дэмждэг эхнэр нөхөр, үр хүүхэд, хамаатан садантай нь хамтран ажиллах юм бол тэднийг хүчирхэгжүүлэхэд гаргах хичээл зүтгэл тань юу юунаас илүү үр дүнтэй байх болно. Жишээлбэл, та залуу хүнд эсвэл хүүхдэд туслахын тулд эх эцэгтэй нь ярилцвал, тэд хүүхдэд нь юу хэрэгтэйг мөн хэрхэн тусалж болох талаар ойлгоход танд тусална.

**Тунгаан бодох асуулт.** Би заадаг хүмүүсийнхээ гэр бүлийнхний зүгээс гаргаж байгаа хичээл зүтгэлийг дэмжихийн тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Би Инос 1:1–3; Мозая 27:14; болон Алма 36:17-оос итгэлтэй гэр бүлийн гишүүд асуудалтай байгаа хүмүүст хэрхэн тусалж чадах талаар юу сурч болох вэ?

#### ХАЙРААР УРЬ

Христийнхтэй адил хайрын чин сэтгэлийн илрэл нь сайн мэдээний тал дээр асуудалтай байгаа ангийн гишүүдийн зүрх сэтгэлийг зөөлрүүлэх агуу их хүчтэй. Ихэнх тохиолдолд эдгээр хүн бусдад хэрэгтэй гэдгээ мөн хүмүүс тэдэнд хайртай болохыг мэдэх хэрэгтэй байдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Боломжтой үйлчлэл хийхийг тэднээс хүсэх нь дахин идэвхтэй болоход нь тэдэнд хэрэгтэй хөшүүрэг байж болно” хэмээн заасан.<sup>2</sup> Энэ нь туршлагаасаа эсвэл судрын талаарх өөрийн сэтгэгдлийг хуваалцах байдлаар дараагийн хичээлд оролцохыг


хүсэх гэх мэт энгийн хүсэлт байж болно. Та ангийн бусад гишүүнээс энэ хүмүүсийн гэрт зочлох, тэднийг ангидаа урих, хэрэгтэй бол унаагаар үйлчлэх зэрэг арга замаар санаа тавьдаг болохоо үзүүлэхийг хүсэж болох юм.

**Тунгаан бодох асуултууд.** Би бусдад үйлчлэх урилгыг хүлээн авснаар сүнслэг байдлаараа хэрхэн хүчирхэгжсэн бэ? Би ангийнхаа гишүүнээс ямар нэгэн байдлаар үйлчлэхийг хүссэнээр түүнийг сүнслэг байдлаар өсөж хөгжихөд тусалж чадах уу?

**Судрын жишээ.** Үйлчлэх урилга нь Амюлект сайн мэдээний талаарх итгэл үнэмшлээ өөрчлөхөд хэрхэн тусалсан бэ? (Алма 10:1–11-ийг үзнэ үү).

#### ТЭВЧЭЭРТЭЙ МӨН ТУУШТАЙ БАЙ.

Аврагчийн сургаалт зүйрлэлд гардаг хоньчин өөрийн алдагдсан хоньдыг “олтлоо” хайсан байдаг (Лук 15:4). Хүн бүр таны гаргаж буй хичээл зүтгэлд шууд хариулахгүй. Гэхдээ Аврагч: “учир нь тийм нэгэнд та нар үргэлжлүүлэн тохинуулах болно; учир нь, тэд эргэж ирээд . . . мөн би тэднийг эдгээх ажгуу” хэмээн биднээс хэзээ ч бууж өгөхгүй байхыг хүссэн байдаг (3 Нифай 18:32). Их Эзэний цаг хугацаанд итгэн, хичээлд ирэхгүй байгаа хүмүүст хайртай гэдгээ мөн тэднийг санаж байгаагаа харуулах тохиромжтой арга замыг үргэлжлүүлэн хай. Та өөрийн биеэр очиж уулзах, утсаар



ярих, зурвас бичих юм уу өөр бусад аргыг хэрэглэж болно. Хайраар хүрч үйлчлэхийн тулд тэвчээртэй, тууштай хүчин чармайлт гаргасны тань урт удаан хугацааны үр нөлөө ямар болохыг гайхах үе танд ирнэ.

**Тунгаан бодох асуултууд.** Аврагч миний сул тал, надад тулгарч байгаа асуудлуудад хэрхэн тэвчээртэй хандаж байсан бэ? Би заадаг хүмүүстэйгээ хамт Түүний үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?

**Судрын жишээ.** Би Лук 15:8–10; Алма 37:7–8; Сургаал ба Гэрээ 64:33-аас тэвчээр, тууштай байдлын талаар юу олж мэдсэн бэ?

1. Дэвид О.Маккэй, Conference Report, 1968 оны 10-р сар, 7-8.

2. Томас С.Монсон, “Бусдыг ирээдүйд ямар хүмүүс болсон байхаар нь харж сур,” *Ensign*, 2012 оны 11-р сар, 68-71 эсвэл 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 141.

#### ВИДЕО БИЧЛЭГ ДЭЭРХ ЖИШЭЭ

Чуулгынхаа цуглаанд ирэхгүй байсан залуу эрэгтэйд хүрч ажилласан удирдагчийн сүнслэг жишээг өгүүлсэн Хозе дэ Соуза Маркизийн түүхийг үзүүлэхийн тулд ахлагч Мэрвин Б.Арнолдын Ерөнхий чуулган дээр хэлсэн “Strengthen Thy Brethren” (LDS.org) үгийн эхний хэдэн минутын хэсгийг үзүүл. (Мөн “Strengthen Thy Brethren,” *Ensign*, эсвэл *Liahona*, 2004 оны 5-р сар, 46–48-ийг үзнэ үү)



## Сүнсээр заа

(Гарын авлага 2: Сүмийг удирдах нь [2010], 5.5.4)

Аврагч: “Ариун сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26) хэмээн шавь нартаа амласан байдаг. Бид зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлэн, бусдад Түүнтэй илүү адил болоход нь туслах сайн мэдээг заах эцсийн зорилгоо биелүүлж чадна. Ариун Сүнс үнэнийг мөн Христийн тухай гэрчилдэг бөгөөд зүрх сэтгэлийг өөрчилдөг. Ямар ч багш хэчнээн ур чадвартай, туршлагатай байсан ч Сүнсийг орлох нь үгүй. Гэхдээ бид Бурханы хүүхдүүдэд Сүнсээр суралцахад нь туслах Түүний мутар дахь зэмсэг болж чадна. Үүнийг хийхийн тулд бид Сүнсний нөлөөг амьдралдаа урин, заадаг хүмүүсээ мөн адил хийхэд урамшуулан дэмждэг байх ёстой.

### ЗААЖ БАЙХДАА СҮНСИЙГ УРЬ

Сайн мэдээний багшийн асуудаг бүх асуулт, уншдаг бүх судар, явуулдаг бүх үйл ажиллагааны эцсийн зорилго бол Сүнсийг урьж, бүх хүнийг Христэд ирэхэд урих явдал юм. Та Ариун Сүнсний нөлөөг урихын тулд чадах бүхнээ хий. Их Эзэн “Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно” (С ба Г 42:14) хэмээн амласан байдаг. Түүнээс гадна ариун дуу хөгжим, судар, хожмын үеийн бошиглогчдын үгс, хайр ба гэрчлэлээ илэрхийлэх, нам гүм орчинд тунгаан бодох агшин зэрэг нь бүгд Сүнсний оршихуйг урьж чадна. Жишээлбэл, та хичээл эхлэхээс өмнө оршил хөгжмийг намуухан тавьж болно.

**Тунгаан бодох асуултууд.** Сүнснийг чухам юу миний амьдрал, гэр орон, ангид авчирч байна вэ? Ямар зүйл Түүнийг холдуулж байна вэ? Би сайн мэдээнээс суралцаж байхдаа Сүнснийг урьж авчрахад нь ангийн гишүүддээ хэрхэн тусалж чадах вэ?

**Судрын жишээ.** Би Иохан 14:26; Хиламан 5:29–30; Сургаал ба Гэрээ 11:12–13-аас Ариун Сүнсний талаар

юу олж мэдсэн бэ? Энэ зарчим Аврагчтай илүү адил заахад надад хэрхэн тусалж чадах вэ?

### СҮНСНИЙ ДАРУУХАН ЗЭМСЭГ БАЙ

Заримдаа багш нарт тэдний мэдлэг, арга барил, зан ааш зааж буй хүмүүст нь сүнслэгээр нөлөөлдөг гэж буруу ташаа бодол төрж болно. Иймэрхүү хандлага ангийн гишүүдэд заан, тэдний зүрх сэтгэлийг өөрчлөхөөр Ариун Сүнснийг урин авчрахад саад болдог. Багшийн хувьд таны зорилго бол гайхалтай хичээл заах биш харин бусдад жинхэнэ багш нь болох Ариун Сүнсний нөлөөг хүлээн авахад туслах явдал юм.

**Тунгаан бодох асуулт.** Би зааж байхдаа Ариун Сүнснийг өөртэйгөө бүрэн хамт байлгахын тулд ямар ямар өөрчлөлт хийх ёстой вэ? (жишээг С ба Г 112:10-аас үзнэ үү). Хувийн үнэлгээний дасгалыг энэ эх сурвалж дээрх “Христ шиг багш болон сайжрах нь” хэсгээс үзнэ үү.

**Судрын жишээ.** Алма болон Мозаягийн хөвгүүд хэрхэн “Бурханы мутарт зэмсэг” болсон талаар унших

үед Сүнс надад юу заасан бэ? (Мозая 27:32–37; Алма 17:1–12; 26; 29)

### УЯН ХАТАН БАЙ

Хамгийн сайн заах боломжууд нь хэн нэгэн туршлагаасаа хуваалцах үед болон утга учир бүхий ярилцлага руу хөтөлсөн асуулт тавих үед гэх мэт гэнэт гарч ирдэг. Иймэрхүү тохиолдолд цаг гарга. Хичээлээ төлөвлөж мөн зааж байхдаа аль алинд нь сүнслэг өдөөлтийг сонсож, хэрэв шаардлагатай бол төлөвлөгөөгөө өөрчлөн, хүлээн авсан мэдрэмжээ дагахад бэлэн бай. Хэрэв та сүнслэг байдлаараа бэлтгэгдсэн бол Их Эзэний хэлснээр “юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт” (С ба Г 100:6) өгөгдөх болно. Сүнсний өдөөлтийг дагах нь зарим заах материалыг авч үзэхээс чухал гэдгийг бүү март.

**Тунгаан бодох асуултууд.** Сүнс намайг багшийн хувьд удирдаж байгааг би хэзээ мэдэрч байсан бэ? Би Түүний удирдамжийг илүү ойр ойрхон хүлээн авахын тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Би 3 Нифай 17:1–9-ийг уншиж байхдаа зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээнд тохируулсан Аврагчийн үлгэр жишээнээс юу мэдэж авсан бэ?

### ГЭРЧЛЭЛЭЭ ОЙР ОЙРХОН ХУВААЛЦ

Сүнслэг үнэний талаарх таны энгийн, чин сэтгэлийн гэрчлэл зааж буй хүмүүст тань хүчтэй нөлөөлж чадна. Гэрчлэл шууд бөгөөд чин сэтгэлийн угаас гарч ирэх үедээ

### СУРАЛЦАГЧДЫГ ҮЙЛДЭХЭД УРЬ

Бид жинхэнээсээ хөрвөгдөхийн тулд зөвхөн Сүнсний бидний бодгальд баталж байгаа үнэнийг мэдрэхээс гадна тэдгээр үнэний дагуу үйлдэх ёстой байдаг. Суралцагчдад Сүнснийг мэдэрч, танихад туслахаас гадна

хүлээн авсан мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тусал. Суралцагчдыг үйлдэхэд хэрхэн урих талаар илүү ихийг олж мэдэхийн тулд энэ эх сурвалж дахь “Суралцагчдыг үйлдэхэд урь” хэсгийг үзнэ үү.



хамгийн хүчтэй байдаг. Гэрчлэл нь уран цэцэн үгтэй, сунжирсан, “Би өөрийн гэрчлэлийг хуваалцах гэсэн юм” гэж эхлэх шаардлагагүй. Та зааж байгаа тодорхой зарчмынхаа талаарх гэрчлэлээ ойр ойрхон хуваалцаж бай. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит: “ийм гэрчлэл нь үнэнч байдлыг баталдаг тамгатай адил”<sup>1</sup> хэмээн заасан байдаг.

**Тунгаан бодох асуултууд.** Надад ангидаа болон гэр орондоо зааж байхдаа гэрчлэлээ хуваалцах ямар боломжууд байдаг вэ? Би эдгээр боломжийг хэрхэн илүү үр дүнтэй ашиглаж болох вэ?

**Судрын жишээ.** Би Алма 5:45–48; 36:3–4-т цэдэглэгдсэн Алмагийн гэрчлэлээ хуваалцаж байгаа байдлаас юу сурч болох вэ?

▶ Мөн “A Man without Eloquence” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### **БУСДЫГ ГЭРЧЛЭЛЭЭ ХУВААЛЦАХАД УРЬ**

Та зааж байхдаа Сүнснийг урихын тулд ярилцаж байгаа үнэнийг хэзээ талаарх хувийн гэрчлэлийг

хуваалцахад бусдыг урамшуулан дэмж. Ангийн гишүүдээс сайн мэдээний зарчмын талаарх сэтгэгдлээ эсвэл туршлагаасаа хуваалцахыг хүсэж болно. Жишээлбэл, та “Та нар Мормоны талаар юу гэж боддог вэ? эсвэл “Бошиглогчдыг дагах нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?” гэж асууж болно. Ийм арга замаар өдөөгдсөн үед бяцхан хүүхэд ч гэсэн гэрчлэлээ хуваалцаж чадна.

**Тунгаан бодох асуулт.** Заадаг хүмүүсийнхээ талаар бодох үед тэдний дундаас хэнийг гэрчлэлээ хуваалцахад урих нь зүйтэй гэсэн мэдрэмж надад төрж байна вэ?

**Судрын жишээ.** Матай 16:15–17 болон Иохан 11:20–27 дээр цэдэглэгдсэнээр, Аврагч хэрхэн Петр, Марта хоёрыг гэрчлэлээ хуваалцахад урьсан бэ?

▶ Мөн “Thou Art the Christ” болон “Invite Us to Testify” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### **БУСДАД СҮНСНИЙ НӨЛӨӨГ ТАНЬЖ МЭДЭХЭД ТУСАЛ**

Багшийн хувьд таны хийж чадах хамгийн чухал зүйлийн нэг бол зааж байгаа хүмүүстээ Ариун Сүнсний нөлөөг хэрхэн таньж мэдэхийг зааж өгөх юм. Хүүхдүүд, өсвөр үеийнхэн, шинэ гишүүдэд зааж байхдаа ийнхүү зааж байх нь юу юунаас илүү чухал бөгөөд та тэднийг хувийн илчлэлт хүлээн авч, хууран мэхлэлтээс зайлсхийн, сүнслэг байдлаараа бие даахад бэлдэж байгаа хэрэг. Ариун Сүнсээр өдөөгдсөн үедээ суралцагчдаас юу мэдэрч, юу хийхээр нөлөөлөгдөж байгааг асуу. Тэдэнд сүнслэг мэдрэмжээ Ариун Сүнсний нөлөөтэй холбоход тусал.

**Тунгаан бодох асуулт.** Би зааж байхдаа Сүнс тэнд байгааг хэрхэн мэдэж болох вэ?

**Судрын жишээ.** Би ангийнхаа гишүүдэд Ариун Сүнсний нөлөөг таньж мэдэхэд нь туслахын тулд Галат 5:22–23; Моронай 7:13; Сургаал ба Гэрээ 8:2–3-ыг хэрхэн ашиглаж болох вэ?

1. *Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. (1939), 206.

## **ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД**

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс

олон санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах хэрэггүй.

**Дадлага хий.** Боломжтой бол багш нараас энэ ярилцлагын явцад хүлээн авсан сүнслэг мэдрэмжээсээ хуваалцахыг хүс. Тэд дараачийн удаа зааж

байхдаа Сүнсээр удирдуулахын тулд юу хийж болох вэ? Дараагийн багшийн зөвлөлийн хурлаар тэднийг өөрсдийн туршлагаас хуваалцахад урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Аврагч дэлхий дээрх тохинуулалдаа бэлдэж байхдаа мацаг барьж, залбирахад мөн “Бурхантай хамт байхын тулд” “Сүнсээр удирдагдсан” (Иосеф Смитийн Орчуулга, Матай 4:1 [Матай 4:1, зүүлт тайлбар 6]). Сайн мэдээний хүчирхэг багш байх гэдэг нь зөвхөн хичээлдээ бэлдэхийг төдийгүй бас өөрийгөө бэлдэхийг хэлнэ. Сүнс нь жинхэнэ багш бөгөөд хөрвөлтийн үнэний эх сурвалж учраас сайн мэдээний чадварлаг багш нар хичээлийг өгөгдсөн цагт хэрхэн амжиж заах вэ гэж бодохын оронд тэдний зүрх сэтгэлийг Ариун Сүнсээр дүүргэхэд анхаарлаа төвлөрүүлдэг.

### “АМЬДРАЛЫН ҮГСИЙГ ОЮУНДАА . . . НӨӨЦӨЛ”

Бурханы үгийг залбирч судлах нь биднийг Ариун Сүнс тэй нийцэхүйц болгодог. Үүний дараа бусдад зааж, бусдыг дэмжиж байхад Тэрээр өмнө нь сурч байсан зүйл дээрээ тулгуурлахад биднийг сүнслэгээр өдөөх юм. Иймээс хичээлээ төлөвлөж байхдаа туслах материал руу орохын өмнө судрууд ба бошиглогчдын үгсийг хичээнгүйлэн судлах нь зүйтэй. Их Эзэн бидэнд “амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл, . . . тэрхүү хэсэг нь [бидэнд] яг тэр цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 84:85) хэмээн амласан байдаг.

**Тунгаан бодох асуултууд.** Их Эзний үгийг оюун ухаандаа “нөөцлөх” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Судрууд миний хувьд үнэт зүйлс юм гэсэн бодол хэзээ надад төрж байсан бэ?

**Судрын жишээ.** Хайрум Смит Сэргээлтийн үйл хэрэгт хэрхэн оролцож болох талаар мэдэхийг хүсэхэд, Их Эзэн түүнд Сургаал ба Гэрээ 11 (мөн С ба Г 23:3-ыг үзнэ үү) дээр цэдэглэгдсэн илчлэлтээр хариулсан байна. Би энд цэдэглэгдсэн зөвлөгөөний алийг нь багшийн хувьд надад хамаатай гэж бодож байна вэ?

### ӨДӨР БҮР ИЛЧЛЭЛТ ХҮЛЭЭН АВАХЫГ ЭРЭЛХИЙЛ

Илчлэлт нь бүгд нэг удаа биш, харин ихэнх тохиолдолд “шат шатаар” (2 Нифай 28:30) өгөгддөг. Тиймээс хичээлээ заахдаа хамгийн багадаа долоо хоногийн өмнөөс эхлэн бэлдэх нь зүйтэй. Таны заах гэж байгаа сайн мэдээний зарчим таныг ангийн гишүүдийнхээ амьдралыг хэрхэн адислах талаар тунгаан бодох үед мөн хичээлд хэрэгтэй санаа, мэдрэмж таныг ажилдаа явж, гэрийн ажлаа хийн, гэр бүлийнхэнтэйгээ болон найз нөхөдтэйгөө харилцаж байх үед орж ирэх болно. Сүнслэг бэлтгэлийг цаг гарган хийдэг биш, харин үргэлж хийж байх ёстой зүйл гэж бод.

**Тунгаан бодох асуулт.** Би өдөр бүр сүнслэг удирдамж хүлээн авахын тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч өдөр тутмын үйл ажиллагаанаас сайн мэдээний ямар ямар сургаалыг олж хардаг байсан бэ? (Жишээг Матай 13:1–23; Иохан 4:6–14-өөс үзнэ үү).

Түүнчлэн Дэвид А.Бэднар, “Ажиглахдаа түргэн бай,” *Ensign*, 2006 оны 12-р сар, 30–36-г үзнэ үү.

### ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Хичээлийн талаарх бодол санаа, мэдрэмж төрөх үед, дараа нь

тэдгээрийг мартагчийн тулд бичиж тэмдэглэх арга замыг ол. Та төрсөн сэтгэгдлээ “Сүнсэнд байх зуур” тэр дор нь тэмдэглэж авахын тулд биедээ тэмдэглэлийн дэвтэр, жижигхэн карт эсвэл цахим төхөөрөмж авч явж байх нь зүйтэй (С ба Г 76:80, 113). Та сүнслэг сэтгэгдлээ бичиж тэмдэглэсэнээр, Их Эзний удирдамжийг үнэлдэг гэдгээ Түүнд харуулахаас гадна Тэр танд илчлэлтийг илүү ойр ойрхон өгч адислах болно.

Та заадаг хүмүүсээ төрсөн сэтгэгдэл бүрээ бичиж авахад урамшуулан дэмж. Хүүхдүүдийг бодол санаа, туршлагаа эцэг эхтэйгээ хуваалцахад урамшуулан дэмж. Ахлагч Ричард Г. Скотт “Нягт нямбай хөтөлсөн мэдлэг бол хэрэг болсон үед бэлэн байдаг мэдлэг юм. . . [Сүнслэг удирдамжийг тэмдэглэж авах нь] цаашид улам их гэрэл хүлээн авах магадлалыг нэмэгдүүлдэг”<sup>1</sup> хэмээн амласан.

**Тунгаан бодох асуулт.** Сүнслэг мэдрэмжийг тэмдэглэж авах ямар арга барил надад илүү тохирох вэ?

**Судрын жишээ.** Аврагч нифайчууд дээр ирэхдээ, тэднээс хөтөлсөн цэдгээ авчрахыг хүссэн. Би 3 Нифай 23:7–14 дээр цэдэглэгдсэн Түүний үгээс хүлээн авсан сүнслэг өдөөлтөө тэмдэглэж авах талаар юу олж мэдсэн бэ?

1. Ричард Г. Скотт, “Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 88.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь. Жишээлбэл, та тэднийг судрын

жишээнээс судалж байхдаа хүлээн авсан мэдрэмжээсээ хуваалцахад урьж болно.

**Урь.** Багш нарыг дараагийн хичээлдээ бэлдэж байхдаа, тухайлбал гэр орондоо болон гэр бүлийнхэндээ заах боломж гарч ирэхэд хүлээн авсан сүнслэг мэдрэмжээ тэмдэглэж авахад

урь. Хүсвэл, багш нарын зөвлөлийн дараагийн хуралд бичиж тэмдэглэсэн зүйлээсээ бусадтайгаа хуваалцахад тэднийг урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.



## Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдар

Эзэн Багш Аврагч Эцэгтээ дуулгавартай байж, төгс үлгэр жишээ үзүүлсэн. Христтэй адил багш байхын тулд хийж чадах хамгийн чухал зүйл бол гэр орон, Сүм, хаана ч байсан Аврагчийн дуулгавартай байдлын үлгэр жишээг болон сайн мэдээг бүхий л сэтгэл зүрхээрээ дагаж амьдрах явдал юм. Энэ нь Ариун Сүнсний нөхөрлөлийг хүлээн авах гол арга зам мөн. Та төгс байх шаардлагагүй ч тууштай хичээл зүтгэл гарган, бүдэрч унах бүрдээ Аврагчийн Цагаатгалаар дамжуулан өршөөл хүлээн авахыг эрэлхийлэх ёстой. Ерөнхийлөгч Бонд К.Пакэр: “Зөвхөн нэг хичээлд бэлтгэхэд бус, харин өөрийн амьдралыг тэр чигээр нь Сүнсний нийцүүлэхийн тулд багш хүн чадах бүхнээ хийснээр хүч чадлыг хүлээн авдаг”<sup>1</sup> хэмээн заасан байдаг.

### АВРАГЧИЙН АМЬДРАЛЫГ ҮЛГЭР ДУУРАЙЛАА БОЛГО

Аврагчийн заах арга барилыг буюу Түүний хэрэглэсэн аргачлал, хэлсэн үгийг судлах нь тустай. Гэхдээ Аврагчийн заах, бусдыг өргөн дэмжих хүч нь амьдарч байсан байдал, хэн байснаас нь үүдэлтэй. Та Есүс Христийнхтэй адил амьдралаар амьдрахыг хичээх тусам Түүнтэй адил заах боломжтой болно.

**Тунгаан бодох асуултууд.** Би өөрийн амьдралд ихээхэн нөлөөлсөн багш нарынхаа тухай эргэн бодоход, тэднээс Христийнхтэй адил ямар зан чанарыг олж харсан бэ? Би Христийнхтэй адил ямар зан чанарыг илүү бүрэн дүүрэн хөгжүүлэх шаардлагатай вэ? (Өөрийгөө үнэлж дүгнэх үйл ажиллагааг хийхийн тулд энэ эх сурвалжийн “Христтэй адил багш болж сайжрах нь” хэсгийг үзнэ үү.)

**Судрын жишээ:** Сургаал ба Гэрээ 4:5–6 дээр Их Эзэний ажилд үйлчлэхэд тохирохуйц болгодог зан чанарын жагсаалт өгөгдсөн байдаг. Аврагч эдгээр зан чанарыг ямар арга замаар харуулсан бэ? Би эдгээр зан чанарыг өөртөө хэрхэн хөгжүүлж чадах вэ?

### АМЬД ГЭРЧ БАЙ

“Та хэн болохоо бусдад заадаг.” “Та нарын төрх байдал, үлгэр жишээ . . . тухайн хичээл дээрх бодит үнэнээс илүүтэй дурсагдан үлддэг. Ийм ч байх ёстой. Хэрэв бидний хувьд шавь байх нь чухал юм бол энэ нь

бусдад харагдах болно”<sup>2</sup> хэмээн ахлагч Нийл А.Максвелл заасан байдаг. Та уучлалын талаар заахыг хүсэж байвал, таныг гомдоосон хүмүүсийг уучлахыг онцгойлон хичээж чармай. Та залбирлын талаар заахыг хүсэж байвал өөрөө тогтмол, утга учиртай залбирч



## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

Жишээлбэл, та “Та амьд гэрч байна гэдэг нь юу гэсэн утгатай үг гэж бодож байна вэ?” гэж асууж болно.

**Урь.** Багш нарыг энэ ярилцлагын үеэр хүлээн авсан сүнслэг мэдрэмжүүддээ анхаарал хандуулахыг хүс. Сүнс Есүс Христийн сайн мэдээний дагуу илүү бүрэн дүүрэн амьдрахын тулд юу хийх

ёстой гэж хэлсэн тухай бодож үзэхийг тэднээс хүс. Өөрт төрсөн мэдрэмжээ бичиж, тэдгээрийн дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.



байхыг хичээ. Таны хувийн туршлага зааж буй зарчмынхаа талаар хүчтэй гэрчлэх боломжийг танд олгох болно. Та тэдгээрийн дагуу амьдарч байгаа учир Ариун Сүнс таны зааж буй зүйлсийн үнэнийг гэрчлэх юм. Түүнээс гадна таны зааж байгаа хүмүүс амьдралаас тань сайн мэдээний дагуу амьдарснаар хүлээн авсан адислалуудыг олж харна.

**Тунгаан бодох асуултууд.** Би дараагийн хэдэн долоо хоног сайн мэдээний ямар ямар зарчим заах вэ? Би эдгээр зарчмыг илүү бүрэн дүүрэн дагахын тулд юу хийж чадах вэ?

**Судрын жишээ.** Сүүлчийн зоогийн үеэр шавь нар нь тэдний дунд хэн нь хамгийн агуу болох талаар маргалдсан байдаг (Лук 22:14, 24–27-г үзнэ үү). Аврагч жинхэнэ агуу байдлын талаар тэдэнд юу заасан бэ? (Иохан 13:1–17-г үзнэ үү.)

▶ Түүнчлэн “Living the Gospel Brings Power” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### НАМАНЧИЛ

Аврагчийн адил амьдарч, заахыг хичээх үед хүчин мөхөстөх үе танд тохиолдох нь гарцаагүй. Сэтгэлээр бүү уна. Үүний оронд гаргасан алдаа, сул талуудаа Тэнгэрлэг Эцэгт болон Аврагчид хандах боломж болгон ашигла. Христийн Цагаатгалаас хүч чадал хүлээн ав. Наманчлал зөвхөн ноцтой нүглүүдийг наманчлахад зориулагдаагүй гэдгийг санаарай. Энэ нь Тэнгэрлэг Эцэгтэй болон Аврагчтай илүү адил болохын тулд өдөр бүр шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх үйл явц юм. Эцсийн эцэст энэ нь ангийнхаа гишүүдэд хийе гэсэн сэдлийг төрүүлэх гэж хичээж байгаа тэр зүйл тань юм.

**Тунгаан бодох асуулт.** Амьдралдаа дүгнэлт хийгээд үзвэл, Есүс Христтэй илүү адил болохын тулд Сүнс намайг хэрхэн өөрчлөгдөхөд хүргэсэн бэ?

**Судрын жишээ.** Би Алма 26:21–22 дээр цэдэглэгдсэн Аммоны үгсээс наманчлах, заах хоёрын хоорондын холбооны талаар юу олж мэдсэн бэ?

1. Бойд К.Пакэр, *Teach Ye Diligently* (1975), 306.
2. Нийл А.Максвэлл, “But a Few Days” (СБС-ийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1982 оны 9-р сарын 10), 2, si.lds.org.

## Сүнсийг урьдаг орчинг үүсгэ

Аврагчийн заадаг байсан—Галил тэнгисийн эрэг, Хувиралтын уул, Иерусалим болон Өгөөмөр дэх ариун сүмүүд гэх мэт зарим газрын тухай бодож үз. Юу эдгээр орчинг заахад тохиромжтой болгосон учраас Аврагч тэнд заадаг байсан бэ? Та Ням гаргийн ангийн эсвэл чуулгын цуглааны багшийн хувьд заах орчноо хянах боломжгүй мэт санагдаж байж магадгүй. Гэхдээ Сүнсийг ангидаа урихын тулд, материаллаг ба сүнслэг уур амьсгалын аль алины хувьд таны хийж болох олон зүйл бий.

### МАТЕРИАЛЛАГ ОРЧИНГ БЭЛД.

Бидний хаана байгаагаас үл хамааран Сүнс бидэнд зааж болох ч бидний орчин үнэний талаар сурч, мэдрэхэд ихээхэн нөлөөлдөг. Ангид орж ирэхэд танд ямар мэдрэмж төрж байгаад анхаарал хандуул. Цэвэр, цэмцгэр мэдрэмж төрж байна уу? Суудлын байрлал нь суралцагчдад тангтай болон бие биетэйгээ амар хялбар харьцах боломжийг олгож байна уу? Бүгд таныг болон ангийнхаа бусад гишүүнийг сонсох боломжтой байна уу? Суралцагчдад Сүнсийг мэдрэхэд саад болох анхаарал сарниулах зүйлс өрөөнд байна уу?

Та анхаарал сарниулж болзошгүй зүйлсийг өрөөнөөс гаргахаас гадна, өрөөнд Сүнсийг урих ямар зүйл нэмж болох вэ? Жишээлбэл, оршил хөгжим (Сүмийн дуулал эсвэл өөр бишрэл хүндэтгэлтэй дуунуудын бичлэг) ангийн гишүүдийг орж ирэхэд, бишрэл хүндэтгэлтэй хандахад нь урамшуулан дэмжинэ. Зураг, үзүүлэн нь заахад туслах үр дүнтэй хэрэгсэл байхаас гадна нөхөрсөг, халуун дотно уур амьсгалыг төрүүлдэг.

Та Ням гаргийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн эсвэл өөр туслах бүлгийн удирдагчаас ангидаа

эдгээр зохион байгуулалтыг хийхэд туслахыг хүсэж болно. Энэ нь танд анхаарлаа ангийн гишүүд рүү төвлөрүүлэх боломжийг олгоно.

Та заахад тохиромжтой орчинг бүрдүүлэхийн тулд чадах бүхнээ хийсний дараа, цэвэр сургаалыг заах нь ямар ч орчинг сүнсээр суралцах хүчирхэг газар болгон хувиргадаг гэдгийг сана.

**Тунгаан бодох асуултууд.** Манай ангийн ямар онцлог шинж чанар Сүнс байлгах орчинг үүсгэхэд тусалдаг вэ? Би ангидаа ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?

**Судрын жишээ.** Их Эзэний “суралцахын өргөө” болон “дэг журмын өргөө[г]” (С ба Г 88:119–120-ийг үзнэ үү) бий болго гэсэн удирдамж нь миний багшийн дуудлагатай ямар холбоотой вэ?

### ХАЙРЫН УУР АМЬСГАЛЫГ НЭМЭГДҮҮЛ

Суралцагчдын хандлага, бие биетэйгээ харьцах харьцаа, сайн мэдээний талаарх бодол санаа гэх мэт Сүнсийг урьдаг зарим хүчин зүйлийг гартаа барьж мэдрэх боломжгүй. Дээрх хүчин зүйлс нь анги дахь Сүнсэнд нөлөөлдөг болохыг ойлгоход ангийн

гишүүддээ тусал. Хүн бүрийг туршлага, асуулт, гэрчлэлээ чөлөөтэй хуваалцах боломжтой нээлттэй, хайраар дүүрэн, хүндэтгэлтэй орчинг бий болгохын тулд танд туслахад урамшуулан дэмж.

Хэрэв та өсвөр үеийнхэнд болон хүүхдүүдэд заадаг бол таны үлгэр жишээ суралцагчдын хандлагад хүчтэй нөлөөлнө. Ангийн гишүүдийг ангид орж ирэхэд чин сэтгэлээсээ инээмсэглэн, гар барин угтаж ав. Та үг хэл, үйлдлээрээ сайн мэдээг хайрлах хайраа мөн тэдний сүнслэг өсөлт хөгжилд санаа тавьдаг болохоо харуул.

**Тунгаан бодох асуултууд.** Манай ангийн гишүүд ангийнхаа сурах орчинг бүх хүнд нээлттэй, тав тухтай уур амьсгалтай болгохын тулд юу хийж болох вэ? Би илүү сайн үлгэр жишээ үзүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй байна вэ?

**Судрын жишээ.** Аврагч шавь нартаа “бие биеэ хайрлаж” сурахад нь туслахын тулд юу хийсэн бэ? (Иохан 13:34).

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Багш нарыг цуглах гэж байгаа өрөөндөө халуун дулаан, урин дуудсан уур амьсгалыг үүсгэхийн тулд энэ хэсэгт авч үзсэн санаануудыг ашиглан хэрэгжүүлэхэд урь. Та нэг багшид

дараагийн багшийн зөвлөлийн хурлын өрөөг бэлтгэх үүргийг хариуцуулан өгч болно.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа сонгоод, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Гэнэт гарч ирсэн заах боломжийг ашигла

Аврагч ихэнх сургаалаа синагогт биш харин өдөр тутмын энгийн орчинд буюу шавь нартайгаа хооллон, худгаас ус авч, инжир модны хажуугаар өнгөрч байхдаа заасан байдаг. Та ангийнхантайгаа зөвхөн ням гарагт уулзан, харилцах боломжтой ч тэднээс сурахад бэлэн шинж тэмдгийг буюу таны заана гэж төлөвлөөгүй зүйлийг сурахад бэлэн байна гэсэн шинж тэмдгийг олж хар.

### ҮРГЭЛЖ БЭЛТГЭЛТЭЙ БАЙ

Албан бус байдлаар заах боломж хурдан өнгөрдөг учраас ийм боломж гарч ирсэн тохиолдолд тэр даруй ашиглах нь чухал. Жишээлбэл, ангийн гишүүн муу сургамж өгч байгаа шинэ киноны талаар дурдахаар Сүнсээр хөтлөгдсөн тохиолдолд Их Эзэний жишгийг дэлхийн арга барилтай харьцуулах боломжийг олгож байж болох юм. Ширүүн бороо орох нь сайн мэдээ биднийг амьдралын шуурганаас хэрхэн халхалдаг талаар ярилцах боломж байж болно. Эдгээр боломжийг гарын авлага дээр уг сэдвээр ярилцах боломж гартал хүлээх биш, харин гарч ирэх үед ашиглах нь хамгийн үр дүнтэй байдаг. Эдгээр боломж нь хэзээ гарч ирэхийг мэдэх боломжгүй учраас үүнд хичээлээ заахад бэлддэгийн адил бэлтгэх боломжгүй. Гэхдээ та “ямагт бэлэн байж” (1 Петр 3:15), Сүнсэнд мэдрэмтгий байвал өөрийгөө бэлдэж чадна. Аврагч заах дуудлагыг долоо хоногт нэг удаа хийж гүйцэтгэдэг үүрэгт ажил гэж үздэггүй байсан бөгөөд багш байх нь Түүний салшгүй нэгэн хэсэг байсан юм. Хэрэв та өөрийгөө сайн мэдээний багш хэмээн үргэлж хардаг бол ямар ч агшинг заах боломж болгон ашиглаж чадна.

**Тунгаан бодох асуултууд.** Надад төлөвлөсөн хичээлээс гадна заах ямар ямар боломж байна вэ? Ийм боломж гарч ирэх үед заахад үргэлж бэлэн байхын тулд би юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Багшийн хувьд Алмагийн “ямар ч цагт” мөн “хаана ч гэсэн” (Мозая 18:9) гэрчлэгч болж зогсох тухай хэлсэн үг надад ямар хамаатай вэ? (мөн С ба Г 84:85-ыг үзнэ үү.)

### АЖИГЧ ГЯРХАЙ БАЙ

Та ангийн гишүүдийнхээ амьдралд юу болж байгаад анхаарал хандуулнаар заах онцгой боломжуудыг олж авах болно. Жишээлбэл, хэцүү сонголт хийх болсон өсвөр насны хүүхэд хувийн илчлэлт хэрхэн хүлээн авах талаар эсвэл айдастай нүүр тулж буй хүүхэд Ариун Сүнсний талаар суралцахад бэлэн байж болно. Суралцагчдын хэлсэн үг эсвэл тавьсан асуулт мөн адил заах боломж руу хөтлөх боломжтой.

**Тунгаан бодох асуулт.** Би намайг суралцахад бэлэн байгааг ажигласан гэр бүлийн гишүүнээр эсвэл багшаар хэзээ адислагдаж байсан бэ?

**Судрын жишээ.** Аврагч Лук 15-д цэдэглэгдсэн сургаалт зүйрлэлийг заахад хүргэсэн фарисайчууд,

бичээчдийн талаар юуг олж анзаарсан бэ? (1–2-р шүлгийг үзнэ үү).

### ҮРГЭЛЖ ХОЛБОГДОЖ, ХАРИЛЦАХАД БЭЛЭН БАЙ

Заах хамгийн онцгой боломж нь ангийн гишүүний сэтгэл дотроо тээж явдаг асуултаас эсвэл шаналгаж байдаг асуудлаас эхэлдэг. Гэхдээ та завгүй байж, шүүмжтэй хандаж эсвэл бэлдсэн материалаа заахад хэт ач холбогдол өгдөг бол зааж байгаа хүмүүс тань өөрт байгаа асуулт, сэтгэлийн зовлонг тантай чөлөөтэй хуваалцаж чадахгүй. Сүнсээр өдөөгдсөн үед төлөвлөсөн зүйлээ хойшлуулан, ангийн гишүүдийн санааг зовоосон зүйлсийг сонсоход бэлэн бай. Өөрийг үг хэл, үйлдлээр тэднийг сонсох хүсэлтэй байгаагаа харуул.

**Тунгаан бодох асуултууд.** Миний зааж байгаа хүмүүс асуултыг нь сонирхдог гэдгийг мэддэг үү? Би сонирхдог гэдгээ хэрхэн илүү сайн ойлгуулж болох вэ?

**Судрын жишээ.** Би хүмүүст Аврагчийн тусламж хэрэгтэй байх үед Тэрээр тэдэнд зааж, адислахад бэлэн байсан тухай Марк 5:22–34; 6:30–44; 3 Нифай 17-оос юу сурч болох вэ?

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь. Хамгийн оновчтой заах боломжууд хурлын энэ үед гарч ирэх боломжтой.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Багш нараас өнгөрсөн долоо хоногийн турш хийсэн ердийн үйл ажиллагааныхаа (гэр орны ажлаа хийж дуусгах, гэр бүлийнхээ гишүүдтэй тоглоом тоглох, кино болон спортын

тоглоом үзэх, хүнсний дэлгүүр явах гэх мэт) жагсаалтыг гаргахыг хүс. Тэднийг эдгээр үйл ажиллагааг хэрхэн заах боломж болгон ашиглаж болох талаар ярилцахад урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Төлөвлөгөө гарга

Их Эзэн “Өөрсдийгөө зохион байгуул; хэрэгтэй зүйл болгоныг бэлтгэ” (С ба Г 88:119) хэмээн зарлигласан байдаг. Заахаасаа өмнө хичээлийнхээ төлөвлөгөөг гаргах нь таны суралцагчдын хэрэгцээнд хамгийн сайн тохирно хэмээн мэдэрдсэн сайн мэдээний зарчмыг мөн тэдгээр зарчмыг батлах эх сурвалжуудыг олж тодорхойлоход тусална. Түүнээс гадна энэ нь тайван орчинд Сүнсээр удирдагдах боломжийг танд олгоно. Та энэхүү ажлыг урьдчилан хийснээр, зааж байхдаа дараа нь юу хэлэх вэ гэж бодохын оронд суралцагчдадаа анхаарлаа хандуулах боломжтой болно. Түүнчлэн та шаардлагатай бол төлөвлөгөөгөө сүнслэг өдөөлтийн дагуу зохицуулан өөрчлөхөд илүү сайн бэлтгэгдсэн байна.

### СУРАЛЦАГЧДЫГ ТАНЬ АДИСЛАХ ЗАРЧМУУД ДЭЭР АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛ

Хичээлийн төлөвлөгөөний гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой зүйл бол зааж байгаа хүмүүсийн тань хэрэгцээ ба уг хэрэгцээнд нийцсэн сайн мэдээний зарчмууд байх ёстой. Та заах гэж байгаа судрынхаа хэсгүүдийг болон бошиглолын сургаалуудыг залбиран судалж байхдаа “Манай ангийн гишүүдэд чухал ач холбогдолтой байж болох юуг би эндээс олж болох вэ?” гэж өөрөөсөө асууж бай. Жишээлбэл, хэрэв та Есүс Христийн Цагаатгалын талаар зааж байвал ангийн тань зарим гишүүн нүглээ наманчилсан хэдий ч өөрсдийгөө уучилж чадахгүй байна гэдгийг мэдэрч болно. Та тэдэнтэй Исаиа 1:18 дээрх “Та нарын нүглүүд час улаан мэт боловч час шиг цагаан

болно” гэсэн амлалтыг хуваалц гэсэн мэдрэмжийг хүлээн авч болох юм.

Сүнсэнд таны төлөвлөгөөг удирдах боломжийг олго Сүнс нь гарын авлага дээрх ангийн гишүүдэд ач холбогдолтой байж болох судрын хэсэг, бошиглолын сургаал, санаанууд руу таны бодож байснаас өөр арга замаар хөтөлж болох юм.

**Тунгаан бодох асуултууд.** Би дараагийнхаа хичээлээр ямар ямар зарчим заах вэ? Манай ангийн гишүүдийн хэрэгцээнд эдгээр зарчмын аль нь илүү тохирно гэж би бодож байна вэ?

**Судрын жишээ:** Алма 39–42 Алмагийн хүү Кориантондоо хандан өгсөн зөвлөгөөг агуулдаг. Алма хүүд нь ямар хэрэгцээ байгааг олж харсан бэ? Ямар зарчим заах мэдрэмж түүнд төрсөн бэ? Би Алмагийн үлгэр жишээнээс юу сурч болох вэ?

### ЗАРЧМЫГ БАТЛАХ ЭХ СУРВАЛЖУУДЫГ ОЛ

Та хичээлийнхээ төлөвлөгөөг гаргаж байхдаа ярилцах гэж байгаа сайн мэдээний зарчмуудыг ойлгоход суралцагчдад туслах арга замыг хайж ол. Судрууд ба амьд бошиглогчдын үгс нь таны хамгийн гол эх сурвалжууд бөгөөд нэмэлт материал руу орохоосоо өмнө тэднийг эхэлж унших нь зүйтэй. Ямар судрууд зарчмыг заахад туслах вэ? Хамгийн сүүлийн Ерөнхий чуулган дээр уг зарчмын талаар үг хэлсэн үү? Та суралцагчдад зарчмын тухай тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах ямар асуулт тавьж болох вэ? Уг зарчмыг батлахад туслах түүх, үзүүлэн, зураг, видео бичлэг, Сүмийн дуулал эсвэл хүүхдийн дуу гэх мэт өөр бусад эх сурвалж байна уу? Иймэрхүү олон эх сурвалжийг Сүмийн сургалтын





материал, сэтгүүл эсвэл LDS.org дээр санал болгосон байдаг. Зааж байгаа зарчим бүрд ашиглаж болох асуулт, батлах эх сурвалжуудыг жагсаа. Магадгүй энэ нь шаардлагагүй эсвэл бүгдийг нь ашиглах боломжгүй байж болох ч ямар ч тохиолдолд бэлтгэлтэй байх нь сайн хэрэг.

**Тунгаан бодох асуултууд.** Би бусад багш нар сайн мэдээний зарчмыг заахдаа ямар эх сурвалжуудыг үр дүнтэй ашиглаж байхыг харж байсан бэ? Би ямар ямар эх сурвалж ашиглаж болох вэ?

**Судрын жишээ.** Лук 10:25–37 дээрх зарчмыг тодотгож өгсөн Аврагчийн арга замын юу нь надад гүн сэтгэгдэл төрүүлсэн бэ?

Мөн энэ эх сурвалж дээрх “Сургаалыг заахад дуу хөгжим, түүх, зургийг ашигла” хэсгийг үзнэ үү.

### ТОХИРУУЛАН ӨӨРЧЛӨХ ХҮСЭЛТЭЙ БАЙ

Залбирч бэлдсэн, эмх цэгцтэй хичээлийн төлөвлөгөө нь таны суралцагчдыг агуу ихээр адислах ч та Сүнсний удирдамжийг хүлээн авбал, хичээлийнхээ төлөвлөгөөг тохируулан өөрчлөх хүсэлтэй байх болно. Зааж байгаа хүмүүсийнхээ үг, асуултыг анхааралтай сонс. Таны бэлдсэн тодорхой нэгэн зарчим дээр илүү цаг зарцуулах эсвэл хичээлийн төлөвлөгөөнд ороогүй асуудлыг авч хэлэлцэх нь зүйтэй гэсэн мэдрэмжийг Сүнс танд өгч болно.

Таны заадаг хүмүүсийн сүнслэг өсөлт хөгжил нь хичээл дээр заахаар төлөвлөсөн бүх зүйлээ танилцуулахаас илүү чухал гэдгийг бүү март. Уг сүнслэг өсөлт хөгжлийн ихээхэн хувь нь ангиас гадуур болж өнгөрнө. Суралцагчдад хувиараа болон гэр бүлээрээ сурч байгаа зүйлсээ хуваалцахад урамшуулан дэмжих асуултуудыг тавихаар төлөвлө. Та хэчнээн их цаг зав гарган материалаа урьдчилан судална, төдий чинээ хувь хүний хэрэгцээнд тохируулан, дэмжлэг үзүүлэх боломжтой байна.

**Тунгаан бодох асуулт.** Би зааж байхдаа Сүнсний өдөөлтийг анхаарч байгаагаа мэдэхийн тулд юу хийж чадах вэ?

**Судрын жишээ.** Бид Сургаал ба Гэрээ 11:21-ээс заахад Сүнсний гүйцэтгэдэг үүргийн талаар юу сурч болох вэ?

### ЗААХ САНААНУУД

Та төлөвлөгөөгөө гаргаж байхдаа ангийн суралцагчдад судраас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралцахад нь туслахын тулд тэднийг юуг хийхэд урьж болох талаар бодож үз. Бараг бүх сударт эсвэл сэдэвт ашиглаж болох санаануудыг доор жагсаав. Бусад санааг Сүмийн сургалтын материалуудаас олох боломжтой. Гэхдээ хамгийн оновчтой санаа нь таныг заадаг хүмүүсийнхээ хэрэгцээг бодож үзэх үед Сүнсээр өгөгдөх болно.

Ангийн гишүүд дараах зүйлийг хийж болно. Үүнд:

■ Судрын хэсгүүдээс олсон зарчмууд болон үнэнүүдийнхээ жагсаалтыг гарга. Тэдэнд энэ шүлгүүд дээрх ямар үг, хэллэг, жишээнүүд эдгээр зарчмыг ойлгоход тусалсан бэ?

■ Асуултын хариултыг судрын хэсгүүд болон Ерөнхий чуулганы үгсээс хайж ол.

■ Зарчмыг гэр бүл, найз нөхдөдөө хэрхэн заах талаар хуваалц. Тэд зарчмыг хүүхдэд хэрхэн заах вэ? Өөр шашин шүтлэгтэй хүнд хэрхэн заах вэ?

■ Хоёр юм уу түүнээс олон судрын түүх эсвэл хэсгийг хооронд нь харьцуул. Ийнхүү харьцуулснаар тэд юуг ойлгож авсан бэ?

■ Сайн мэдээний зарчмын тухай дуулуудыг олж, дуул.

■ Судрын хэсгийг өөрийн үгээр хураангуйлан тайлбарла.

■ Хэсгүүдийг холбогдох зурагтай нь тааруул. Эдгээр зураг судрын хэсгийг илүү сайн ойлгоход тэдэнд хэрхэн туслах вэ?

■ Сайн мэдээний зарчмуудтай холбоотой үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

■ LDS.org дээрээс уг зарчимтай холбоотой Сүмээс гаргасан DVD эсвэл видео бичлэгийг олж үз.

■ Зураг эсвэл үзүүлэн нь хэрхэн сайн мэдээний зарчимтай холбоотой болохыг тайлбарла.

## ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Хичээлийн төлөвлөгөөг бэлдэх олон арга зам бий. Танд болон зааж байгаа хүмүүст тань хамгийн сайн тохирохыг авч ашигла. Доор ашиглаж болох нэг аргыг өгөв.

**Хуваалцахад урь:** Та эхлээд ангийн гишүүдийг бодол санаа, туршлагаасаа бие биетэйгээ хуваалцахад урамшуулан дэмжиж болно. Тэд судраас уншиж байхдаа өөрсдөдөө төрсөн бодол санааг болон сударт заасан зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж байхдаа олж авсан туршлага, энэ долоо хоногийн сэдвийн талаарх асуултуудаа хуваалцаж болно.

**Сургаалыг заа:** Та сайн мэдээний үнэний талаар өөрсдөө олж мэдэж авахад ангийн гишүүдэд туслах арга замын талаар бод. Энэ нь танд бодол санаа, сургалтын материалаа урьдаас цэгцлэн бэлдэхэд тусална. Жишээлбэл, хичээлийн сэдэв нь санваарын сэргээлт байвал та дараах арга барилыг ашиглаж болно. Тухайлбал:

Зарчмууд	Дэмжсэн судрууд	Асуултууд	Заахад туслах материалууд
Есүс Христ дэлхий дээр Өөрийн Сүмийг байгуулахдаа санваарын эрх мэдлийг төлөөлөгчдөдөө өгсөн.	Матай 10:1; Үйлс 2:37–47; Еврей 5:4	Эдгээр судар танд санваарын эрх мэдэл ямар чухал болох тухай юу заадаг вэ?	Төлөөлөгчдийг томилж буй Христийн зураг
Олон төлөөлөгч алагдаж, ёс бус байдал тархсан учраас Их Эзэн санваарын эрх мэдлийг дэлхийгээс татан авсан юм.	Амос 8:11–12; Матай 24:9–11; Үйлс 20:29–30; 2 Тесалоник 2:1–4; Мормон 1:13–14	Та дэлхий дээр Урвалтын ямар нотолгоонуудыг харж байсан бэ?	Зүйрлэл: Таныг 12 гэрлээр гэрэлтүүлсэн өрөөнд байж байтал гэрлүүд нэг нэгээрээ унтарч байна гэж төсөөлөн бод. Энэ зүйрлэл нь төлөөлөгчид ба санваарын эрх мэдэл алдагдсантай хэрхэн холбогдож байна вэ?
Эрт дээр үед санваарыг атгаж байсан хүмүүс Иосеф Смитэд санваарыг сэргээн өгсөн.	С ба Г 13:1; 27:12–13; 110; Иосеф Смит—Түүх 1:68–72	Таныг санваарын сэргээлтийн талаар суралцаж байхад Сүнс танд юу заасан бэ?	Видео бичлэг: “Restoration of the Priesthood” (LDS.org)
Одоо хүн бүр санваарын адислалуудаас хүртэх боломжтой.	С ба Г 1:20; 84:19–20	Санваар таныг болон таны гэр бүлийг хэрхэн адисалсан бэ?	“Hark, All Ye Nations!” <i>Сүмийн дуулал</i> д. 264

**Амьдралдаа хэрэгжүүлэхэд урамшуулан дэмж:** Хичээлийн үеэр суралцагчдыг өөрсдөдөө төрсөн сүнсэлг мэдрэмж, сурсан зүйлийнхээ үр дүнд ямар зүйлийг хийхэд сүнсээр нөлөөлөгдөж байгаагаа тунгаан бодоход урамшуулан дэмж.

**Илүү ихийг сурч мэдэхэд урамшуулан дэмж:** Ерөнхийдөө ангийн гишүүдэд дараагийн долоо хоногт юуны талаар ярилцах гэж байгаагаа мэдэгдэн, тэднийг гэртээ урьдчилан бэлдэж ирэхэд урих нь зүйтэй.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Багаараа хамтдаа зохих сургалтын гарын авлага ашиглан, дараагийн хичээлийн төлөвлөгөөний загварыг бэлд. Та энэ хэсэгт өгөгдсөн эсвэл өөр төлөвлөгөөний загвар ашиглаж болно. Багш нарыг дараагийн хичээлийн төлөвлөгөөг

гарган, дараагийн багшийн зөвлөлийн хурлаар санал хүсэлт хүлээн авахад бэлдэж ирэхэд урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Сургаалыг заа

(Гарын авлага 2: Сүмийг удирдах нь [2010], 5.5.4)

Их Эзэн: “Миний сургаал минийх биш, харин Намайг Илгээгчийнх” (Иохан 7:16) хэмээн хэлсэн байдаг. Эцэгийн сургаал нь тогтмол амьдралдаа хэрэгжүүлэх юм бол өргөмжлөлд хүргэх мөнхийн үнэнүүдийг агуулсан байдаг. Эдгээр үнэний төвд Аврагчийн Цагаатгал болон үүний авралын төлөвлөгөөнд гүйцэтгэсэн нэн чухал үүрэг байдаг. Аврагч “хаант улсын сургаалыг та нар бие биендээ заах болно” (С ба Г 88:77) хэмээх зарлигийг бидэнд өгсөн юм. Бид ийнхүү хийж чадвал Ариун Сүнс бидэнд сургаалын бүрэн бүтэн байдлын талаар гэрчлэн, хүмүүст тэдгээрийн дагуу амьдрахад сүнслэгээр нөлөөлөх болно. Сургаал нь өөрөө өөрчлөгддөггүй харин биднийг болон биднийг зааж буй хүмүүсийг өөрчилдөг.

### ХРИСТИЙН СУРГААЛ ДЭЭР ХИЧЭЭЛЭЭ ТӨВЛӨРҮҮЛ

Ерөнхийлөгч Бойд К.Пакэр: “Зөв ойлгогдсон сургаал нь хандлага, зан чанарыг өөрчилдөг”<sup>1</sup> хэмээн заасан байдаг. Сайн мэдээний багшийн хувьд та “Бурханы үгийн нөлөөлөх хүч” “хүмүүсийн оюун ухаанд . . . юунаас ч илүү хүчтэйгээр нөлөөлдөг” (Алма 31:5) гэдэгт итгэх ёстой. Та суралцагчдын анхаарлыг цагийг зугаатай сайхан өнгөрүүлэхэд эсвэл завгүй байлгахад төвлөрүүлбэл, тэдэнд утга учир бүхий өөрчлөлтийг амьдралдаа хийхэд туслах мөнхийн үнэнийг заах боломжоо алдах болно.

Та үнэн сургаалыг зааж байна гэдэгтэй итгэлтэй байх нэг арга зам бол хичээл тань хэрхэн 2 Нифай 31 болон 3 Нифай 27:16–21 дээр хураангуйлсан Христийн сургаалтай холбогдож байгаа талаар бодож үзэх явдал юм. Та өөрөөсөө “Миний зааж байгаа зүйлс ангийн гишүүдэд Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчилж, Бурхантай гэрээнд орж, гэрээгээ сахиж мөн Ариун Сүнсийг хүлээн авахад хэрхэн туслах вэ?” хэмээн үргэлж асууж бай.

**Тунгаан бодох асуултууд.** Миний зааж байгаа хүмүүс Христийн сургаалын дагуу амьдарснаар хэрхэн адислагдах вэ? (3 Нифай 27:16–21-ийг үзнэ үү). Тэд Христийн сургаалыг дагахгүй амьдарснаар ямар мөнхийн үр дагавар гарах вэ?

**Судрын жишээ.** Мозая 5:2–5 дээр цэдэглэгдсэнээр, Хаан Бенжаминь хүмүүсийг өөрчлөгдөхөд юу нөлөөлсөн бэ? Хаан Бенжамин тэдэнд юу заасан бэ? (Мозая 2–5-ыг үзнэ үү.) Хаан Бенжаминь заасан зүйлс Христийн сургаалтай хэрхэн холбогдож байна вэ?

### АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМ СЭДВИЙН ХҮРЭЭН ДОТОР ЗАА

Зарим үед суралцагчид, тэр тусмаа өсвөр үеийнхэн сайн мэдээний зарчмууд тэдэнд хэрхэн хамаатай болохыг эсвэл тэд яагаад зарим зарлигийг дагах ёстой юм бол гэж гайхдаг. Гэхдээ тэд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийнхээ аз жаргалын төлөө бий болгосон мөнхийн төлөвлөгөөг ойлгох юм бол сайн мэдээний зарчмуудыг болон зарлигуудыг өгсөн учир шалтгаан нь илүү тодорхой болох бөгөөд тэдгээрийг дагах хүсэл



өсөн нэмэгдэх болно. Жишээлбэл, мөнхийн гэрлэлтийн талаарх болон Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болох бидний чадавхын талаарх сургаалыг ойлгодог хүний хувьд ариун явдлын хуулийг дагах шалтгаан нь хүсээгүй жирэмслэлтээс эсвэл халдварт өвчнөөс сэргийлнэ гэхээс илүү хүчтэй утга учиртай байх юм.

**Тунгаан бодох асуултууд.** Би дараа дараагийн хичээлээр ямар зарчим заах вэ? Би ангийн гишүүдэд зарчмуудыг авралын төлөвлөгөөний хам сэдвийн хүрээнд ойлгоход нь хэрхэн тусалж болох вэ?

## ГЭР ОРОНДОО САЙН МЭДЭЭНЭЭС СУРАЛЦАХЫГ ДЭМЖ

Таны зааж байгаа хүмүүс зөвхөн ангид сайн мэдээний сургаалуудыг судалдаг бол өөрт хэрэгтэй хангалттай сүнслэг тэжээлийг хүлээн авч чадахгүй. Суралцагчдад итгэлээ хөгжүүлэн, Христтэй

илүү адилхан болоход туслахын тулд таны хийж чадах хамгийн чухал зүйл бол судраас бие дааж мөн гэр бүлтэйгээ судлахад тэднийг урамшуулах явдал

юм. Хичээлд ашиглах санааг энэ эх сурвалжийн “Гэр орондоо сайн мэдээнээс суралцахыг дэмж” хэсгээс үзнэ үү.



**Судрын жишээ.** Бурхан өөрийн хүмүүст “гэтэлгэлийн төлөвлөгөөг” (Алма 12:32-ыг үзнэ үү) заасныхаа дараа зарлигуудыг өгсөн хэмээн Алма заасан байдаг. Би зааж байхдаа энэ загварыг хэрхэн ашиглаж болох вэ?

### СУДРУУДЫГ БОЛОН ХОЖМЫН ҮЕИЙН БОШИГЛОГЧДЫН ҮГСИЙГ АШИГЛА

Их Эзэн бидэнд “хаант улсын сургаалыг та нар бие биендээ заа” (С ба Г 88:77) мөн судруудыг ашиглан “[Түүний] сайн мэдээний зарчмуудыг заа” (С ба Г 42:12) хэмээн зарлигласан байдаг. Судрууд болон хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн үгс нь бидний зааж буй үнэнүүдийн эх сурвалж юм. Боломж гарах бүрд удирдамж, асуултынхаа хариулт, тусламж дэмжлэг авахын тулд Бурханы үгс рүү хандаж байхад заадаг хүмүүсээ урамшуул. Хэрэв суралцагчид “Христийн үгэн дээр найрлавал” тэндээс олсон сургаал нь “[тэдэнд] хийвэл зохих бүх зүйлийг хэлэх болно” (2 Нифай 32:3).

**Тунгаан бодох асуултууд.** Би зааж байгаа хүмүүсээ Бурханы үгэн дээр “найрлахад” хэрхэн урамшуулж болох вэ? Би судрыг илүү сайн ойлгоход туслах зүүлт тайлбар, судруудын удирдамж зэрэг туслах материалыг ашиглаж сурахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

**Судрын жишээ.** Аврагч сайн мэдээний үнэнүүдийн талаар зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байсан ямар жишээнүүдийг би олж чадах вэ? (Жишээг Матай 12:1–8 ба Лук 4:16–21-ээс үзнэ үү).

### СУРАЛЦАГЧДАД СУДРУУДЫГ ӨӨРСӨДТЭЙГӨӨ АДИЛТГАХАД ТУСАЛ

Нифай “бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ” (1 Нифай 19:23) хэмээн хэлсэн байдаг. Абрахам, Естер, Лихай, Иосеф Смит нарт сүнслэгээр нөлөөлөн, дэмжин тусалсан сайн мэдээний тэдгээр үнэн нь таны заадаг хүмүүст ч гэсэн өнөө үед тулгарч буй зовлон бэрхшээлээ даван туулахад туслах юм. Суралцагчдад судруудыг өөрсөдтэйгөө адилтгахад туслахын тулд тэднийг шүлгийн хэсэгт өөрийн нэрийг оруулан эсвэл судар дээрх түүх тэдний амьдралд хэрхэн холбоотой болох талаар тунгаан бодоход урь.

**Тунгаан бодох асуулт.** Судрын ямар ямар шүлэг надад тулгарсан зовлон бэрхшээлийн талаар ойлгуулсан бэ?

**Судрын жишээ.** Аврагч зааж буй хүмүүстэйгээ судрыг хэрхэн адилтгадаг байсан бэ? (Жишээг Лук 4:24–32-оос үзнэ үү).

### СУРАЛЦАГЧДАД СҮНСЛЭГ ҮНЭНҮҮДИЙГ ОЛЖ МЭДЭХЭД ТУСАЛ

Суралцагчдыг судрын хэсгээс ангидаа уншихаас өмнө уг хэсэгт заасан тодорхой нэгэн үнэнийг хайж олохыг тэднээс хүсэх талаар бодож үз. Заримдаа эдгээр үнэний талаар тодорхой хэлж, харин зарим үед тэдний талаар дурдах маягаар хэлж өгч болно. Жишээлбэл, та “Сургаал ба Гэрээ 11:12–14-ийг уншиж байхдаа Ариун Сүнсний талаар өгүүлсэн үнэнүүдийг олж мэднэ үү” гэж хэлж болно.

**Тунгаан бодох асуулт.** Би сайн мэдээний үнэнүүдийг судруудаас



хэрхэн олохыг мэдэж авахад ангийнхаа гишүүдэд хэрхэн тусалж чадах вэ?

**Судрын жишээ.** Яагаад Аврагч нифайчуудыг судруудаас эрэлхийлэн, бошиглогчдын үгсээс уншихыг хүссэн бэ? (3 Нифай 23:1–5-ыг үзнэ үү).

▶ Мөн “Searching the Scriptures” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### ҮНЭН СУРГААЛЫГ ГЭРЧИЛ

Аврагч “Тэр хуулийн багш нар шиг нь бус, эрх мэдэлтэй нэгэн шиг” (Матай 7:29) зааж байсан. Аврагчийн хувийн гэрчлэл Өөрийнхөө үгэнд эрх мэдэл өгч, зааж байсан хүмүүстээ мөнхийн үнэнүүдийг хүлээн зөвшөөрөхөд тусалж байсан юм. Таныг үнэн сургаалын талаар гэрчлэх үед Сүнс сургаалын талаарх үнэнийг таны зааж байгаа хүмүүсийн зүрх сэтгэлд батлах болно.

**Тунгаан бодох асуулт.** Миний гэрчлэл өөр хэн нэгний хүчтэй гэрчлэлээр хэрхэн хүчирхэгжиж байсан бэ?

**Судрын жишээ.** Би Алмагийн үнэний талаар гэрчилсэн үлгэр жишээнээс юу сурч болох вэ? (Алма 5:43–48-ыг үзнэ үү).

1. Бойд К.Пакэр, “Do Not Fear,” *Ensign* эсвэл *Liahona*, 2004 оны 5-р сар, 79.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нарыг өөрийн дуртай судраас хуваалцахад урь. Судар

бүрийг суралцагчдын амьдралтай адилтгаж болох янз бүрийн арга замын талаар ярилц.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Сургаалыг заахад дуу хөгжим, түүх, уран зураг ашигла

Бурхан дэлхийг бүтээхдээ, бидний амьдралыг баялаг, гоо сайхнаар цогцлоох төрөл бүрийн ан амьтан, ургамал, байгалийн гоо үзэсгэлэнгээр дэлхийг дүүргэсэн билээ. Сайн мэдээг заах арга барилаа хөгжүүлэх арга замыг хайж ол. Энэ нь суралцагчдын туршлагыг баяжуулан, сайжруулахаас гадна олон янзын хэрэгцээ бүхий суралцагчдад хүрч ажиллахад тань тусална. Дуу хөгжим, түүх, зураг, урлагийн бусад бүтээлийг ашиглах нь хэрхэн Сүнснийг урьж, суралцагчдад сайн мэдээний зарчмуудыг мартагдахааргүй арга замаар ойлгуулан, сайн мэдээг өдөр тутмынхаа амьдралтай холбож үзэхэд туслах талаар бодож үз. Эдгээр эх сурвалж нь хичээлийн анхаарлын төвд байх ёсгүй бөгөөд зөвхөн сайн мэдээний сургаалыг илүү үр дүнтэй заахад туслах хэрэгсэл гэдгийг санаж байх ёстой.

### СҮНСИЙГ УРЬЖ, СУРГААЛ ЗААХАД ДУУ ХӨГЖИМ АШИГЛА

Тэргүүн Зөвлөлийнхөн: “Дуу хөгжим нь [биднийг] илүү агуу сүнслэг байдалд мөн сайн мэдээнд илүү сүсэг бишрэлтэй хандахад хүргэдэг хязгааргүй их хүч чадалтай”<sup>1</sup> хэмээн хэлсэн байдаг. Дууллыг сонсож эсвэл дуулах нь хүндэтгэл бишрэл бүхий мэдрэмж төрүүлж, Сүнснийг урьдаг. Түүнээс гадна дуулал нь сайн мэдээний зарчмуудыг заадаг юм. Жишээлбэл, “I Believe in Christ” (*Hymns*, д. 134) эсвэл Жорж Фрэдэрик Хандэлийн “Халлелуяа” нь Аврагчийн бурханлаг үүрэг, цол хэргэмийн талаарх ярилцлагыг өрнүүлэхэд сүнслэгээр нөлөөлж болох юм. Та дуу хөгжмийг хэрхэн хичээлийнхээ нэг хэсэг болгож болох талаар тунгаан бод. Жишээлбэл, хичээл дээрээ дууллын бичлэг тавих эсвэл нэг гэр бүлийг юм уу Хүүхдийн хэсгийн хүүхдүүдийг дуулж өгөхөд урьж болно.

**Тунгаан бодох асуултууд.** Ариун дуу хөгжим миний гэрчлэлд хэрхэн нөлөөлсөн бэ? Энэ нь заадаг хүмүүсийг минь хэрхэн адисалж болох вэ?

**Судрын жишээ.** Ямар шалтгаанаар Есүс болон Түүний төлөөлөгчид Гетсемани руу явахынхаа өмнө дуулал дуулсан бэ? (Матай 26:30; мөн Колоссай 3:16; С ба Г 25:12-ыг үзнэ үү).

### САЙН МЭДЭЭНИЙ ЗАРЧМУУДЫГ ЗААХДАА ТҮҮХ, ЖИШЭЭГ АШИГЛА

Аврагч сонсогчдооо сайн мэдээний зарчмуудыг өдөр тутмын амьдралдаа хэрхэн ашиглаж болох талаар ойлгоход нь туслахын тулд тэдэнд үргэлж түүх ба сургаалт зүйрлэлээр заадаг байсан. Түүний сургаалууд загас, үр, түлхүүр, аяга зэрэг өдөр тутмын хэрэглээний олон эд зүйлийн талаарх түүхээр баялаг байдаг. Та хичээлдээ бэлдэж байхдаа сайн мэдээний зарчмыг амьдралд ойртуулж өгөх өөрийнхөө болон ангийнхаа гишүүдийн өдөр тутмын амьдралаас авсан жишээ, түүхийн талаар бод. Жишээлбэл, та нар Ариун Сүнс хэрхэн луужин, гарчийдэн эсвэл дулаахан хөнжилтэй адилхан болох талаар ярилцаж болно. Ашиг тустай уран зохиолын номоос авсан сэтгэл сэргээсэн, эш татсан үгс ч хичээлийг баяжуулж чадна. Аль болох олон удаа түүх, туршлагаасаа хуваалцахад суралцагчдыг урь.

**Тунгаан бодох асуултууд.** Миний амьдралын ямар туршлага надад сайн мэдээний зарчмуудыг ойлгоход тусалсан бэ? Би хэрхэн суралцагчдыг туршлагаасаа хуваалцахад урамшуулан дэмжих вэ?

**Судрын жишээ.** Аврагч яагаад Матай 13:44–48 дээрхтэй адил сургаалт зүйрлэлүүдийг ашигладаг байсан бэ?

### СУРАЛЦАГЧДЫН АНХААРЛЫГ ТАТАХЫН ТУЛД УРЛАГИЙН БҮТЭЭЛ АШИГЛА

Урлагийн бүтээлүүд болох зураг, видео бичлэг, жүжиг зэрэг нь суралцагчдыг, тэр тусмаа харж суралцагч хүмүүсийн анхаарлыг татахад мөн судрын түүхүүдийг мартаггүй байхад тусалдаг. Таны ашиглаж буй урлагийн бүтээл гоёл чимэглэл гэхээсээ илүү суралцагчдад сайн мэдээний сургаалыг ойлгоход тусалж байх ёстой. *Сайн мэдээний уран зургийн цуглуулга* болон LDS.org дээрх LDS Media Library нь суралцагчдад утга санаа, үйл явдлыг дүрслэн бодоход туслах зураг, видео бичлэгүүдийг агуулдаг. Жишээлбэл, Харри Андэрсоны “*Хоёр дахь ирэлт*” зураг нь суралцагчдад Аврагчийг ирэх үед тэдэнд ямар санагдах талаар тунгаан бодоход тусалж болно. Үрэлгэн хүүгийн сургаалт зүйрлэлийг жүжигчлэн үзүүлэх нь хэн нэгнийг уучлах гэдэг нь ямар утгатай үг болохыг ойлгоход суралцагчдад тусална.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийнхаа гишүүдийн суралцах туршлагыг сайжруулахын тулд урлагийн бүтээлийг дараа дараагийнхаа хичээлд хэрхэн ашиглаж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч зааж байхдаа бодитой харагддаг зүйлийг хэрхэн ашигладаг байсан бэ? (Жишээг Матай 6:28–30; 22:16–21; Марк 12:41–44-өөс үзнэ үү).

1. “Тэргүүн Зөвлөлийн өмнөх үг,” *Дуулал*, х.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Энэ хэсэгт заасан зарчмыг жүжигчлэн харуулахын тулд ярилцлагадаа дуу хөгжим, түүх, урлагийн бүтээл оролцуулах арга замыг хайж ол. Жишээлбэл, та хурлын өмнө багш нарыг сайн мэдээний зарчмыг заахад хэрэглэсэн эсвэл хэрэглэж болох дуу хөгжим, түүх, урлагийн бүтээлээс хуваалцахад бэлдэж ирэхэд урь. Багш

нарыг хуваалцсаны дараа, уг зүйлс хэрхэн тэдний зааж буй зарчмыг дэмжин, суралцагчдынх нь суралцах туршлагыг сайжруулж болох талаар ярилцахыг тэднээс хүс.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Хэцүү асуултуудад итгэлээр хариул

Сайн багш суралцагчдаа асуулт тавихад урамшуулан дэмждэг ч зарим үед хариулахад хэцүү асуулт гарч ирдэг. Их Эзэн “амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл” мөн “та нар ямар ч зүйлийг тунхаглах ёстой боллоо гэсэн . . . номхон дөлгөөн байдлын сүнсэнд та нар тунхаглагтун” хэмээн зарлигласан байдаг. Та эдгээр зүйлийг хийвэл “яг тэр цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 84:85; 100:6–7) хэмээн Тэр амласан байдаг.

### УРЬДЧИЛАН БЭЛД

Та хичээлдээ бэлдэж байхдаа ангийн гишүүдийн тавьж болох асуултуудыг олж тодорхойлоход тусламж хүсэн залбир. Та судруудаас болон Сүмийн бусад эх сурвалжаас хайж, хэрхэн хариулж болох талаар бодож үз. Их Эзэнээс тусламж эрэлхийлэх нь хамгийн сайн бэлтгэл гэдгийг бүү март.

**Тунгаан бодох асуултууд.** Би дараагийн хичээлийнхээ талаар бодож үзэхэд суралцагчид маань ямар ямар хэцүү асуулт тавих бол? Би бэлэн байхын тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Багшийн хувьд 2 Нифай 32:3 дээрх амлалт надад хэрхэн хамаатай вэ?

### СҮМИЙН АЛБАН ЁСНЫ ЭХ СУРВАЛЖУУДААС ЭШ ТАТ

Сайн мэдээний хэцүү асуултуудад хариулахад туслах хамгийн сайн эх сурвалж нь судар, амьд бошиглогчдын үгс болон Сүмийн бусад албан ёсны хэвлэл байдаг. Жишээлбэл, Сүмийн түүх, маргаантай асуудлуудтай холбоотой асуултад хариулахад туслах зорилгоор Сүм сайн мэдээний сэдвээр нийтлэлүүд хэвлэн нийтэлсэн байдаг ([lds.org/topics](http://lds.org/topics)-ийг үзнэ үү). Сүмийн албан ёсны эх сурвалжуудтай танилцан, асуулт бүхий хүмүүсийг тэдгээрийг мөн адил судлахад урамшуулан дэмж.

**Тунгаан бодох асуултууд.** Манай ангийнхан өмнө нь ямар ямар асуулт тавьж байсан бэ? Тэдэнд Сүмийн ямар ямар эх сурвалж туслах боломжтой вэ?

**Судрын жишээ.** Би Сургаал ба Гэрээ 88:118 дээрх зөвлөгөөг хэрхэн дагаж болох вэ?



## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь. Багш нарт асуултаа тавих тав тухтай, аюулгүй орчин үүсгэхийг хичээ.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Хурал эхлэхээс өмнө багш нарыг зааж байгаа хүмүүсээсээ сонссон сайн мэдээний хэцүү

асуултуудаа авчрахад урь. Эдгээр асуултад хэрхэн зохих байдлаар хариулж болох арга замуудын талаар бүлгээрээ ярилц.

**Бэлд.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.



## СУРАЛЦАГЧДЫГ АСУУЛТУУДАД ХАРИУЛАХАД ТУСЛАХАД УРЬ

Ихэнх тохиолдолд суралцагчдыг бие биеийнхээ асуултын хариултыг олоход урих нь оновчтой арга зам байж болно. Сүнсний өдөөлт хүлээн авсан бол хариултыг мэдэж байсан ч дээрх үйл ажиллагааг хийх шийдвэр гаргаж болно. Хэрэв та суралцагчдаас сайн мэдээний асуултын хариуг судраас болон Сүмийн бусад эх сурвалжаас хайж олохыг хүсвэл, энэ нь та тэдэнд суралцах гайхалтай боломжийг олгож байна гэсэн үг юм.

**Тунгаан бодох асуулт.** Хэцүү асуулт гарч ирэх үед манай ангийн хэн нь тусалж болох санааг гаргаж ирдэг вэ?

**Судрын жишээ.** Би суралцагчдад асуултынхаа хариултыг олж мэдэхэд туслахын тулд Сургаал ба Гэрээ 88:122 дээрх загварыг хэрхэн дагаж болох вэ?

► Мөн “Answering a Class Member’s Question” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

## МЭДЭХГҮЙ ГЭДГЭЭ ХЭЛ

Та хариулах боломжгүй сайн мэдээний асуулт байдаг гэдэгт гайхах хэрэггүй бөгөөд зарим хэцүү асуултын хариулт хэзээ нэгэн цагт илчлэгдэх болно. Бүх асуултын хариултыг олохыг хүсэх нь хүмүүний зан хэдий ч зарим нөхцөлд “Би хариултыг мэдэхгүй. Гэхдээ энэ асуултыг энэ долоо хоногт бүгдээрээ судлаад, дараа долоо хоногт ярилцъя” гэж энгийн байдлаар хэлэх нь зүйтэй. Ийм нөхцөлд суралцагчдын анхаарлыг бидний сайн мэдэх, Аврагчийн Цагаатгал, авралын төлөвлөгөө, санваарын хүч гэх мэт сайн мэдээний илүү чухал үнэнүүд руу хандуул. Сайн мэдээний үндсэн зарчмуудын

талаар гэрчлэлээ хуваалц. Суралцагчдад ахлагч Жэффри Р.Холландын “Энэ Сүмд бидний мэддэг зүйл нь мэдэхгүй зүйлээс маань илүү чухал юм”<sup>1</sup> гэсэн тунхгийг ойлгоход тусал.

**Тунгаан бодох асуулт.** Би сайн мэдээний хариулах боломжгүй асуулттай хүмүүсийн итгэлийг хөгжүүлэхийн тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Би доорх шүлгүүдээс сайн мэдээний хариулах боломжгүй асуултын талаар юу мэдэж авсан бэ? Исаиа 55:8–9; Иохан 16:12; 2 Коринт 5:7; 1 Нифай 11:16–17; Сургаал ба Гэрээ 101:32–33; Мосе 5:6; Итгэлийн тунхаг 1:9.

1. Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *Ensign*, 2013 оны 5-р сар, 94 эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 109.

## ХҮҮХДҮҮДЭД ЗАА

Амилсан Аврагч нифайчууд дээр айлчлахдаа “хүүхдүүдэд тэрбээр зааж мөн тохинуулж, мөн тэрбээр тэдний хэлийг хурц болгон, мөн тэд агуу хийгээд гайхамшигт зүйлийг, бүр түүний хүмүүст илчилснээс ч илүү агуу эцгүүддээ ярьсан ажгуу” (3 Нифай 26:14). Аврагчийн үйлдэл нь хүүхдүүдэд зааж байхдаа хэрхэн тэдний итгэл ба хөрвөлтөд анхаарч, нөлөөлөх жишээг танд харуулж (3 Нифай 17:23-ыг үзнэ үү) байгаа болно.

### ЭЦЭГ ЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛ

Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сайн мэдээний хамгийн чухал багш нар бөгөөд тэд хоёул хүүхдүүддээ нөлөөлөх гол үүрэг хариуцлагыг хүлээж, хамгийн агуу хүчийг агуулдаг билээ (Дэд хууль 6:6–7-г үзнэ үү). Та Сүмд хүүхдүүдэд зааж байхдаа, тэдний эцэг эхийг өөрсдийн нэн чухал үүргийг биелүүлэхэд хэрхэн дэмжиж болох арга замуудыг залбирч, эрэлхийл. Жишээлбэл, та эцэг эхчүүдтэй хүүхдүүдийнх нь хэрэгцээ, сонирхлын талаар ярилцаж, хүүхдүүд нь ангидаа юу сурч байгааг тэдэнтэй хуваалцаж мөн зааж байхдаа эцэг эхчүүдийн гаргаж буй хүчин чармайлтыг хэрхэн дэмжиж болох талаар олж мэдэж болно.

**Тунгаан бодох асуулт.** Би Сүмд хүүхдүүдэд зааж байхдаа тэдний гэр орондоо олж авч байгаа туршлага дээр хэрхэн тулгуурлах вэ?

**Судрын жишээ.** Намайг Мормоны Номон дээрх итгэлтэй эцэг эхчүүдийн үлгэр дуурайлын талаар бодох үед Сүнс надад юу зааж өгч байна вэ? (Жишээг 1 Нифай 1:1; Инос 1:1–3; Алма 56:45–48-аас үзнэ үү).

### ОЛОН ТӨРЛИЙН ЗААХ АРГА БАРИЛ АШИГЛА

Бүх хүүхэд өөр хоорондоо адил биш бөгөөд хүүхэд бүр хурдан өсөж

хөгжиж байдаг. Та дараах олон төрлийн арга барилыг ашиглавал хүүхдүүдэд заах хичээл зүтгэл тань хамгийн үр ашигтай байна. Үүнд:

■ **Түүхүүд.** Хүүхдүүдэд сайн мэдээний зарчмыг түүх ашиглан заавал тэд зарчмуудыг хялбархан ойлгоно. Түүхүүд нь сайн мэдээ бидний өдөр тутмын амьдралд хэрхэн хамаатай болохыг ойлгоход хүүхдүүдэд тусалдаг. Ялангуяа судрууд дээрх түүхүүд нь сургаалыг хүчтэй заадаг. Жишээ нь, та залбирах, илчлэлт авах, сөргөлдөөнийг даван гарах, Бурхан Тэргүүтэний үнэн мөн чанарын талаар заахдаа Иосеф Смитийн Анхны үзэгдлийн тухай түүхийг ашиглаж болно. Та өөрийн амьдралын болон Сүмийн сэтгүүл дээрх түүхийг ашиглаж болно. Бага насны хүүхдүүдэд зааж байхдаа, тэднийг өгүүлж буй түүхэндээ үргэлж оролцуулж бай. Жишээ нь, тэд зургийг барьж, шүлгийг давтан хэлж, хэсгүүдээс жүжигчлэн үзүүлж болно.

■ **Үзүүлэн таниулах материал.** Зураг, видео бичлэг, эд зүйлс зэрэг үзүүлэн таниулах материал нь хүүхдүүдэд судрын түүхүүдийг болон тэдгээрийн заах гэж буй зарчмуудыг илүү сайн ойлгон, санаж байхад тусалдаг. Олон төрлийн зураг, видео бичлэгийг LDS.org вэбсайт дээрх LDS Media Library дээрээс олж болно.

■ **Дуу хөгжим.** Сүмийн дуулал, дуунууд нь хүүхдүүдэд Бурханы хайрыг болон Сүнсний мэдэрч, сайн мэдээний үнэнүүдийн талаар суралцахад тусалдаг. Ая, хэмнэл, энгийн шүлэг нь хүүхдүүдэд сайн мэдээний үнэнийг олон жилийн туршид марталгүй санаж байхад тусалдаг. Хүүхдүүдтэй хамт дуулж байхдаа, тэдэнд дуунд заасан зарчмуудыг олж мэдэн, ойлгоход тусал. *Хүүхдийн дууны номын* болон Сүмийн дууллын ихэнх дуунд

сударт заагдсан сургаалтай холбох судрын эшлэлүүд орсон байдаг.

**Тунгаан бодох асуулт.** Би сайн мэдээг хүүхдүүдэд илүү амархан ойлгуулахын тулд ямар түүх, үзүүлэн, дуу ашиглаж болох вэ?

**Судрын жишээ.** Би Матай 18:1–5 дээр цэдэглэгдсэн Аврагчийн заах арга барилаас юу сурч болох вэ?

■ Мөн “Primary Music Leader” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### ХҮҮХДҮҮДЭД БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ БОЛОМЖ ОЛГО

Хүүхдүүд нь Бурханы охид хөвгүүд учраас аливаа зүйлийг бий болгон бүтээхээр төрсөн юм. Та хүүхдүүдийг сайн мэдээний зарчимтай холбоотой ямар нэгэн зүйлийг бүтээхэд урихдаа тэдэнд уг зарчмыг илүү сайн ойлгоход тусалж, сурсан зүйлийнх нь талаар сануулах гарт баригдах биет зүйлийг өгч байгаа хэрэг юм. Тэд ч гэсэн сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахдаа бүтээсэн зүйлээ ашиглах боломжтой. Хүүхдүүдэд зааж байхдаа тэдэнд барьж босгох, зурах, өнгөөр будах, бичих, бүтээх боломж олго. Эдгээр зүйл нь зөвхөн зугаатай үйл ажиллагаа байгаад зогсохгүй, суралцах явцад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. *Лиакхона* эсвэл *Friend* сэтгүүлийн дугаар бүрд хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх үйл ажиллагаа орсон байдаг.

**Тунгаан бодох асуулт.** Би хичээлдээ бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрхэн оролцуулж болох вэ?

### ХҮҮХДҮҮДИЙГ АСУУЛТ ТАВИХАД УРАМШУУЛАН ДЭМЖ

Хүүхдүүд төрөлхийн сониуч зантай бөгөөд тэдэнд олон асуулт байдаг. Тэдний асуултыг хичээл дээр анхаарал сарниулах, саад болох

### БҮХ МЭДРЭХҮЙГЭЭ АШИГЛАХ НЬ

Ихэнх хүүхэд (насанд хүрэгчид ч мөн адил) олон мэдрэхүй оролцож байвал илүү сайн суралцдаг. Суралцаж байхдаа харах, сонсох, хүрэлцэх мэдрэхүйгээ ашиглахад нь хүүхдүүдэд туслах арга замыг ол. Зарим нөхцөлд тэдний үнэртэх, амтлах мэдрэхүйг хүртэл оролцуулах арга замыг олж болно.



зүйл гэдгээр нь биш, харин боломж болгон хар. Хүүхдүүд асууж байгаа нь тэдний суралцахад бэлэн байгааг харуулж байдаг. Тэдгээр асуулт нь тухайн хүүхэд юу бодож, түүнд ямар асуудал байгаа, суралцаж байгаа зүйлээ хэрхэн хүлээн авч байгаа талаар үнэлж баршгүй ойлголтыг танд өгөх болно. Тэд асуултынхаа хариултыг судруудаас болон амьд бошиглогчдын үгсээс олох боломжтой гэдгийг олж харахад тэдэнд тусал.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийнхаа хүүхдүүдийн асуулт, сониуч занг үнэлдэг гэдгээ тэдэнд хэрхэн харуулах вэ?

**Судрын жишээ.** Залуу Иосеф Смит асуу гэсэн урилгын ачаар хэрхэн адислагдсан бэ? (Иосеф Смит–Түүх 1:10-20-ийг үзнэ үү).

### **ХҮҮХДҮҮДЭЭС МЭДДЭГ ЗҮЙЛЭЭ ХУВААЛЦАХЫГ ХҮС.**

Хүүхдүүд ямар нэгэн шинэ зүйл сурсан л бол угаасаа түүнийгээ бусадтай хуваалцахыг хүсдэг. Хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг бие биедээ болон гэр бүлийнхээ гишүүдэд мөн

найз нөхдөдөө заах боломжийг олгох замаар тэдний энэ хүслийг урамшуулан дэмж. Түүнээс гадна таны зааж байгаа зарчимтай холбоотой бодол санаа, мэдрэмж, туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүсэж болно. Та тэдний бодол санаа энгийн, цэвэр ариун, хүчтэй болохыг мэдэж авна.

**Тунгаан бодох асуулт.** Би хүүхдээс ямар ямар сайн мэдээний үнэнийг мэдэж авсан бэ?

**Судрын жишээ.** Би 3 Нифай 26:14 дээр цэдэглэгдсэн Аврагчийн жишээнээс юу сурч болох вэ?

### **ЗӨРЧЛИЙГ ХАЙРААР ШИЙДВЭРЛЭ**

Заримдаа хүүхэд үймүүлэн ангийн бусад хүүхдийн сурах орчинд сөргөөр нөлөөлдөг. Ийм байдал үүсэхэд хүүхдийн асуудалд тэвчээр гарган, хайрлаж, хүлээцтэй хандах хэрэгтэй. Тухайн хүүхдэд зураг барих, самбар дээр ямар нэгэн зүйл зурах, судраас унших гээд хичээлд илүү идэвхтэй оролцох боломж олгох хэрэгтэй байж болно.

Хүүхэд үймүүлсээр байвал, түүнтэй ганцаарчлан уулзах хэрэг гарч болно. Та хайр, тэвчээрийн сүнсээр түүнээс юу хүсэж байгаагаа мөн тэр үүнийг биелүүлж чадна гэдэгт итгэж байгаагаа түүнд тайлбарла. Та ийнхүү ярилцахдаа хүүхдийн эцэг эхийг эсвэл Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнийг хамт байлцахад урьж болно.

Хэрэв онцгой анхаарал халамж хэрэгтэй хүүхэд үймүүлж байвал тойрог, гадасны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хариуцсан мэргэжилтэнтэй ярилцан эсвэл [disabilities.lds.org](http://disabilities.lds.org) вэбсайт руу орж, тэдэнтэй хэрхэн илүү сайн ажиллаж болох талаар олж мэд.

**Тунгаан бодох асуулт.** Би үймүүлдэг хүүхдэд хайр мэдрэхэд нь туслахын тулд өөрийн заах арга барилд ямар нэгэн өөрчлөлт хийх шаардлагатай юу?

**Судрын жишээ.** Сургаалт үгс 15:1; Сургаал ба Гэрээ 18:10 ба 121:41–44 нь зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар надад юу зааж байна вэ?

## **ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД**

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуулууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн санаануудаа ашиглан сайн мэдээний зарчмыг хүүхдэд зааж буй талаар жүжигчлэн үзүүлэхэд урь. Та

Хүүхдийн хэсгийн хүүхдүүдэд заалгахаар тэднийг хуралдаа урьж авчирч болно. Дараа нь багш нарт санал бодлоо хуваалцах цаг гаргаж өг.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Өсвөр үеийнхэнд заа

Судар дээр цэдэглэгдсэн олон туршлага Бурхан залуучуудын сүнслэг хүчин чадалд итгэдэг болохыг тодотгосон байдаг. Самуел ариун сүмд Их Эзэний дуу хоолойг сонсохдоо жирийн нэгэн хөвгүүн байсан. Мормон ариун үйл хэрэгт тохирохуйц болгосон сүнслэг бэлгийг харуулах үедээ дөнгөж 10 настай байсан юм. Иосеф Смит Сэргээлтийг эхлүүлсэн илчлэлт хүлээн авахдаа 14 настай байлаа. Аврагч ариун сүмд зааж, Эцэгийнхээ ажлыг хийж байхдаа 12-той байсан. Та өсвөр үеийнхэнд заадаг багш бол Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд зориулан бэлдсэн агуу ажлыг хийж гүйцэлдүүлэхэд туслах боломжтой.

### ЭЦЭГ ЭХЭД ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛ

Их Эзэн эцэг эхчүүдэд хүүхдүүддээ зааж сургах үндсэн үүргийг өгсөн. Тиймээс та өсвөр үеийнхэнд Аврагчийн арга барилаар заахыг хичээхдээ эцэг эхчүүдийнх нь хичээл зүтгэлийг дэмждэг байх ёстой. Өсвөр үеийнхний эцэг эхтэй юу зааж байгаагаа хуваалцаж бай. Тэдэнтэй зөвлөлдөж, анги дахь залуучуудын хэрэгцээ, уг хэрэгцээнд тохируулж болох хамгийн оновчтой арга замын талаар олж мэд. Та эцэг эхчүүдтэй тогтмол э-мэйл юм уу мессежээр харилцаж эсвэл тэдэнтэй байнга уулзаж байх нь зүйтэй.

Та өсвөр үеийнхэн болон тэдний эцэг эхчүүдийн хоорондын харилцааг бэхжүүлэхийн тулд юу хийж болох вэ? Заримдаа залуучуудад зөвлөгөө авах хэрэгтэй үедээ танд хандах нь хялбар байж болох ч боломжтой бол тэднийг амьдралынхаа хамгийн чухал багш болох эцэг эхээсээ зөвлөгөө авахад урамшуулан дэмжих нь зүйтэй.

**Тунгаан бодох асуулт.** Зааж байгаа өсвөр үеийнхнийхээ эцэг эхчүүдтэй хамтран ажиллахад надад ямар тохиромжтой арга замууд байж болох вэ?

**Судрын жишээ.** Намайг Хиламаны 2000 залуу цэргийн талаар унших



үед надад өсвөр үеийнхний талаар ямар сэтгэгдэл төрдөг вэ? (Алма 53:17–21; 56:47; 57:21-ийг үзнэ үү).

► Мөн “Strengthen Our Families” (LDS.org) видео бичлэг дээрээс заах үзүүлэнг олж үзнэ үү.

### ӨНДӨР ЗОРИЛГО ТАВИХАД МӨН ЗОРИЛГОДОО ХҮРЭХЭД ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХҮЛЭЭЦТЭЙ ХАНДАЖ ТУСАЛ

Өсвөр үеийнхэнд заах нь насанд хүрэгчдэд заахаас зарим талаараа ялгаатай. Өсвөр үеийнхэн сайн мэдээний тал дээр туршлага нимгэн, ангид санал бодлоо илэрхийлэх нь бага байдаг. Тэдний анхаарлаа төвлөрүүлэх чадвар бага бөгөөд тэдэнд заахын тулд үзүүлэн, амьдрал дээр тохиолдсон түүх, үзүүлэх материал зэрэг олон төрлийн заах

арга барилыг ашиглах шаардлага гардаг. Зарим өсвөр үеийнхэн ангид юуг хүлээн зөвшөөрдөг болохыг дөнгөж сурч эхэлж байгаа тул тэд таны тэвчээрийн хязгаарыг үзэх гэж оролдож байж магадгүй. Заримдаа тэд юуг шүтэн биширч байгаагаа мөн өөрийгөө хэн болохыг сайн мэдэхгүй байдаг.

Үүний зэрэгцээ өсвөр үеийнхэнд Их Эзэний үйлчлэлд гайхамшигт зүйлсийг хийх чадвар бий. Ахлагч Дэвид А.Бэднар: “Энэ цаг үеийн өсвөр үеийнхнийг өмнөх үеийнхэнтэй нь харьцуулахад сударт илүү гүн орсон, бошиглогчдын үгстэй илүү гүнзгий танилцсан, илчлэлтийг хүлээн авахад илүү бэлтгэгдсэн гэдэгт би итгэдэг”<sup>1</sup> хэмээн хэлсэн. Түүнчлэн, ерөнхийлөгч Бага Ж.Рүбэн Кларк: “Сүмийн өсвөр үеийнхэн сүнслэг зүйлсээр

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД ЗОРИУЛАВ

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуулууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нарыг залуучуудад үнэнийг судраас өөрсдөө олж мэдэхэд нь хэрхэн туслахыг жүжигчлэн үзүүлэхэд урь. Өсвөр үеийнхэнд хариултыг

нь өгөлгүйгээр үнэний талаар олж мэдэхэд хэрхэн сүнслэгээр нөлөөлж болох вэ? Багш нар бие биедээ ямар санал, зөвлөгөө өгч болох вэ?

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

өлсөж, сайн мэдээг шулуухан, ямар ч нэмэлт хачиргүйгээр сурах хүсэл эрмэлзлээр дүүрэн байна”<sup>2</sup> хэмээн тэдэнд итгэж байгаагаа илэрхийлсэн байдаг.

Хэрэв таныг тэдэнд итгэдгийг өсвөр үеийнхэн мэдэрвэл, бурханлаг чадавхдаа итгэх итгэл нь өсөн нэмэгдэж, тэдний хийж чадах зүйлс таныг гайхшируулах болно. Өөрсдөө суралцаж, Их Эзэний жишгүүдийг үнэнчээр дагах үүрэг хариуцлагатай гэдгийг тэдэнд хайраар хэлж өг. Тэдний хэн болж чадах тухай Тэнгэрлэг Эцэгийн мэдэх зүйлийг олж харахад тэдэнд тусал.

Мэдээж зөвхөн өсвөр үеийнхэнд биш бидэнд ч мөн адил сурч мэдэх зүйл их бий. Тэднийг үргэлжлүүлэн хайрлаж, урамшуулан дэмжиж, тэдэнтэй тэвчээр гарган ажиллаж, хэзээ ч бууж өгөхгүй байснаар Аврагчийн үлгэр жишээг дага.

**Тунгаан бодох асуултууд.** Би зааж байгаа өсвөр үеийнхнээсээ юуг хүсэн хүлээдэг вэ? Би тэдэнд итгэдэг гэдгээ хэрхэн илэрхийлэх вэ?

**Судрын жишээ.** Судрууд Аврагчийн шавь нараасаа хүссэн зүйлийн талаар юу заасан бэ? (Жишээг Матай 5:48; Иохан 13:34–35; 14:12-оос үзнэ үү).

Мөн энэ эх сурвалж дээрх “Зааж байгаа хүмүүсээ хайрла” хэсгийг үзнэ үү.

### **ӨСВӨР ҮЕИЙНХЭНД БИЕ БИЕДЭЭ ЗААХ БОЛОМЖ ОЛГО**

Өсвөр үеийнхэн бие биедээ үргэлж зааж байдаг. Тэд туршлагаасаа хуваалцан, найздаа сайн мэдээний зарчмыг ойлгоход тусалж, өөрсдийн үйлдлээр үлгэр жишээ үзүүлдэг. Тэд ихэнхдээ нэг нэгнээсээ мөн бусдад зааснаараа илүү сайн сурдаг тул

тэдэнд бие биедээ заах олон боломжийг ангид нь гаргаж өг. Та тэднийг заахад урихдаа тэдэнд цаг гарган, зохих байдлаар бэлдэхэд тусал. Та тэдэнтэй энэ эх сурвалж дээрх зарим зарчмаас хуваалцан, хичээлдээ бэлдэхдээ юу хийдэг болохоо тайлбарла. Дараах загваруудыг бодож үзнэ үү. Үүнд: тэднийг ойлгоосой гэж хүссэн зарчмаа *тайлбарлах*, тэдгээрийг хэрхэн амьдралд хэрэгжүүлж болохыг үзүүлэх, тэдэнд *дадлага хийх* боломж олгох, гаргасан хичээл зүтгэлийг нь *үнэлэх*, *дахин дадлага хийх* боломж гаргаж өгөх гэх мэт.

Энэ арга замаар та өсвөр үеийнхэнд зөвхөн ганц хичээлийг ойлгоход нь туслаад зогсохгүй, амьдралынхаа туршид сайн мэдээг Аврагчийн арга барилаар заахад туслах юм.

**Тунгаан бодох асуулт.** Заах боломж нь манай ангийнхны хэнд ашиг тустай байж болох вэ? Би түүнд эерэг туршлага олж авахад туслахын тулд юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** Лук 2:40–52-ыг уншиж байхад, Сүнс манай ангийн өсвөр үеийнхний талаар ямар зүйлийг надад зааж байна вэ?

▶ Мөн “Let Us Teach” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### **ӨСВӨР ҮЕИЙНХЭНД СҮНСЛЭГ БАЙДЛЫН ХУВД БИЕ ДААХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД НЬ ТУСАЛ**

Өнөөгийн ороо бусгаа цагт таны зааж байгаа өсвөр үеийнхэн сүнслэг байдлаа хадгалж үлдэн, тэдэнд хариуцуулсан Их Эзэний үйл хэргийг гүйцэлдүүлэхийн тулд өөрийн гэсэн итгэл, гэрчлэлийн нөөцтэй байх хэрэгтэй. Тэд хүнд бэрх үед хэрхэн хүч чадлыг мөн асуултынхаа



хариултыг олж болох талаар мэддэг байх хэрэгтэй. Тэд танд эсвэл эцэг эхдээ найдах ёсгүй.

Та зааж байхдаа зүгээр нэг мэдээлэл өгөхийн оронд өсвөр үеийнхэнд сайн мэдээний үнэнүүдийг судраас болон бошиглогчдын үгсээс өөрсдөө олж мэдэхэд тусал. Тэдэнд асуулт байвал заримдаа шууд хариулахын оронд хариултаа хэрхэн өөрөө олж болохыг зааж өгөх нь зүйтэй. Жишээ нь, та судар дээрх сургалтын материалыг эсвэл LDS.org дээрх Gospel Topics хэсгийг хэрхэн ашиглахыг үзүүлж болно. Түүнээс гадна та хувийн илчлэлт авахын тулд хэрхэн эрэлхийлж бас хүлээн авч байснаа хуваалцаж болно. Тэднийг өдөр бүр залбирч, утга учир бүхий судраас суралцах дадал хэвшлийг хөгжүүлэхэд урамшуулан дэмж. Өөрийн үг хэл, үлгэр жишээгээр тэдэнд сайн мэдээний талаар суралцаж, үүний дагуу амьдарснаар ирэх цэвэр ариун баяр баясгалангийн талаар заа.

**Тунгаан бодох асуултууд.** Миний зааж байгаа өсвөр үеийнхэн сайн мэдээний тухай асуулт эсвэл асуудал байвал юу хийх ёстойгоо мэддэг үү? Би тэдэнд сүнслэг байдлын хувьд илүү бие даахад нь хэрхэн тусалж болох вэ?

**Судрын жишээ.** Есүс Христ дээр “сууриа тавих” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Хиламан 5:12). Би өсвөр үеийнхэнд үүнийг хийхэд нь хэрхэн тусалж болох вэ?

1. Дэвид А.Бэднар, “A Reservoir of Living Water” (Залуу насанд хүрэгчдэд зориулсан Сүмийн Боловсролын Системийн галын дэргэдэх ярилцлага, 2007 оны 2-р сарын 4) 2, LDS.org.
2. Бага Ж.Рүбэн Кларк, *The Charted Course of the Church in Education*, сайжруулсан хэвлэл (1994), 3, мөн [lds.org/bc/content/ldsorg/manual/seminary/32709\\_000.pdf](https://www.lds.org/bc/content/ldsorg/manual/seminary/32709_000.pdf), 3-р хуудсыг үзнэ үү.

## **ТЕХНИК ТЕХНОЛОГИЙГ БҮРЭН ДҮҮРЭН АШИГЛА**

Таны зааж байгаа өсвөр үеийнхэнд өөрийн гэсэн цахим хэрэгсэл байдаг бол эдгээр хэрэгсэл нь анхаарал сарниулах зүйл гэхээсээ илүүтэй хичээлийг үр дүнтэй болгох хэрэгсэл байж болох юм гэдгийг санах нь зүйтэй. Өсвөр үеийнхнийг асуултад хариулахын тулд эдгээр хэрэгслийг ашиглан судар, Сүмийн бусад эх сурвалжийг олоход урамшуулан дэмж. Түүнээс гадна та тэдэнд долоо хоногийн дундуур дараагийн хичээлдээ бэлдэхэд нь туслахын тулд зурвас болон холбоосууд илгээж болно.



## Хичээнгүйлэн суралцахад урь

(Гарын авлага 2: Сүмийг удирдах нь [2010], 5.5.4)

Сайн мэдээний жинхэнэ багш бол суралцагчид нь түүний хэлсэн үгийг зөвхөн сонсож байгаад сэтгэл ханадаггүй. Сайн мэдээг судлах нь идэвхгүй үйлдэл байх ёсгүй. Энэ бол итгэл хийгээд тууштай хүчин зүтгэл гаргах үйлдэл юм. Та хичээлдээ бэлдэж байхдаа “Би хичээлээ заахын тулд юу хийх вэ?” гэж бодохын оронд “Ангийн гишүүд маань суралцахын тулд юу хийх вэ?” гэж өөрөөсөө асуу. Би тэдэнд сайн мэдээний талаар бие даан сурч мэдэхэд хэрхэн тусалж болох вэ? Би тэднийг үйлдэхэд хэрхэн урамшуулж болох вэ? Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Хүнд загас өгвөл тэр ганц удаа л хоол хийж иднэ. Хүнд загас яаж барихыг зааж өгвөл тэр насан туршдаа идэх хоолтой болно” хэмээх олны мэдэх энэхүү хэллэгийг хуваалцсан байдаг. Дараа нь тэрээр “эцэг эхчүүд болон сайн мэдээний багш нар бид загас тарааж өгөх ёстой хүмүүс биш, харин бидний хийх ажил бол хүүхдүүддээ ‘загас барьж’ сургахад мөн сүнслэг байдлын хувьд гуйвшгүй болоход туслах явдал юм”<sup>1</sup> гэж заасан.

### АНГИАС ГАДУУР СУРАЛЦАХЫГ УРАМШУУЛАН ДЭМЖ

Долоо хоногт ганцхан удаа сайн мэдээнээс суралцах нь ангийн гишүүдийг дайсны уруу таталт, худал хуурмагаас хамгаалахад хангалтгүй юм. Өдөр бүр гэр орондоо бие дааж мөн гэр бүлээрээ сайн мэдээнээс суралцахад анхаарлаа төвлөрүүлсэн байх ёстой. Багшийн хувьд хэлж, хийж байгаа зүйл тань энэ зарчмыг бататгаж байх ёстой. Суралцагчдыг сайн мэдээг ангиас гадуур судлахад урьж, тэднээс сурч мэдсэн зүйлээ хуваалцахыг үргэлж хүсэж бай. Жишээлбэл, та ангийнхаа бүх гишүүнийг оноосон унших материалаас өөрсдийнх нь хувьд утга учир бүхий хэсгээсээ хуваалцахад бэлдэж ирэхэд урьж болно. Эсвэл ангийн нэг гишүүнийг хичээлийн нэг хэсгийг заахаар бэлдэж ирэхэд урьж болно. Бага насны хүүхдийг ч гэсэн эцэг эхийнх нь тусламжтайгаар ангиас гадуур суралцахад урих боломжтой.

Гэртээ суралцахыг урамшуулан дэмжих нь зөвхөн унших даалгавраа хийхийг сануулахаас гадна тэдэнд урам зориг төрүүлж, сүнслэгээр өдөөж байх ёстой. Жишээ нь, та “Хэрэв та нар Сүнсний өдөөлтийг таньж мэдэх

чадвараа сайжруулъя гэж бодож байвал, энэ талаар тус болох санааг Сургаал ба Гэрээ 8–9-өөс олж болно. Би та нараас энэ шүлгүүдийг дараагийн хичээлээс өмнө уншиж ирэхийг хүсэж байна” гэж хэлж болно.

**Тунгаан бодох асуулт.** Би гэр орныг сайн мэдээнээс суралцах төв гэж үздэг учраас ангийн цагийг хэрхэн өөр зүйлд ашиглаж болох вэ?

**Судрын жишээ.** Яагаад Есүс амилсныхаа дараа нифайчуудад заахдаа гэр гэртээ хариад, Түүний хэлсэн зүйлсийг эргэцүүлэн бодож, тэдний талаар залбир хэмээн зааварчилсан бэ? (3 Нифай 17:2–3-ыг үзнэ үү).

Мөн энэ эх сурвалж дээрх “Гэр орондоо сайн мэдээнээс суралцахыг дэмж” хэсгийг үзнэ үү.

### ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ СУРАЛЦАГЧДАД ХҮЛЭЭЛГЭН ӨГ

Хэдийгээр багшийн үүрэг хариуцлага чухал ч суралцагчид өөрсдөө суралцах үүрэгтэй. Та суралцагчдад энэ үүргээ хүлээн авч, гүйцэлдүүлэхэд нь хэрхэн тусалж болох талаар бодож үз. Жишээлбэл, ангид судраас уншиж байхдаа, санал бодлоо хуваалцахын өмнө ангийнхаа гишүүдээс уг шүлгээс юу сурсан талаар асууж болно. Та тэднээс тодорхой хариулт өгөхийг шаардалгүй, харин тэдний

олж мэдсэн зүйлийг чин сэтгэлээсээ мэдэхийг хүсэж байгаагаа тэдэнд хэл. Та Сүнсийг урьдаг асуулт, санаанууд нь зөвхөн багшаас биш бас хичээнгүй суралцагчаас гарч ирдэг болохыг олж мэднэ.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийнхаа гишүүдэд суралцах үүрэг хариуцлагаа өөр дээрээ хүлээн авахад нь хэрхэн тусалж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч шавь нараа сурах хариуцлагаа өөр дээрээ хүлээн авахад хэрхэн урамшуулан дэмжсэн бэ? (Жишээг Лук 10:25–28; Ифер 2:22–25-аас үзнэ үү).

### ТЭДЭНД ӨНДӨР БОСГО ТАВЬЖ, ИТГЭЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛ

Зарим суралцагч бие дааж сайн мэдээнээс суралцаж чадна гэдэгтэй итгэдэггүй. Ахлагч Брүс Р.Макконки: “Хүн бүр судраас унших, Ариун Сүнснээс удирдамж хүлээн авах адил эрхтэй билээ”<sup>2</sup> хэмээн заасан байдаг. Та ангийнхаа гишүүдэд итгэж байгаагаа илэрхийлж, Ариун Сүнс тэдэнд заах болно гэдгийг гэрчилбэл, Их Эзэний сайн мэдэний суралцагчдадаа тавьсан өндөр босгонд хүрэхэд туслах юм. Тэдний ихэнх нь танаас өөрсдийгөө дайчлах урилга, урмын үгийг сонсохоос нааш юунд хүрч чадахаа хэзээ ч олж мэдэхгүй. Тэдэнтэй ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Би сайн мэдээний . . . сургаалаас суралцаж, дадлага туршлагатай болоход уриалж байна” хэмээх урилгыг хуваалц.<sup>3</sup>

**Тунгаан бодох асуулт.** Бусад хүн надад сайн мэдээнээс суралцах чадвартаа итгэлтэй болоход юу хийж тусалсан бэ?

### СУДАР СУДЛАХ ТУСЛАМЖ

Судрын зүйлт тайлбар, Сэдэвчилсэн удирдамж ба Библийн толь бичиг нь бидэнд судруудыг ойлгоход туслах үнэтэй эх сурвалжууд юм. Библийн толь бичигт сургаалын хувьд: “Залбирал бол Эцэгийн хүсэл, хүүхдийн хүсэл хоёр хоорондоо нэгдэн нийлдэг үйлдэл буюу үйл явц мөн. Залбирлын зорилго нь Бурханы хүслийг өөрчлөхөд биш, харин Бурхан та нарт өгөхийг хүсдэг адислалуудыг олж авахад өөртөө болоод өрөөл бусдад туслах явдал бөгөөд Түүнээс чухам юу хүсэж байгаагаас хамааралтай байдаг” хэмээн бичигдсэн санааг бодож үз (Библийн толь бичиг, “Prayer”).

**Судрын жишээ.** Аврагч шавь нартаа хэцүү боловч хийх боломжтой урилгыг өгснөөр тэдэнд итгэлтэй байгаагаа илэрхийлсэн (Жишээг Лук 5:1-11-ээс үзнэ үү). Би Түүний үлгэр жишээг дагахын тулд юу хийж болох вэ?

### ХУВААЛЦАХЫГ УРАМШУУЛАН ДЭМЖ

Суралцагчид сурсан зүйлээ хуваалцаж байхдаа зөвхөн Сүнснийг мэдэрч, гэрчлэлээ хүчирхэгжүүлээд зогсохгүй, ангийнхаа бусад гишүүнийг үнэнийг өөрсдөө олж мэдэхэд урамшуулан дэмждэг. Та сурч мэдсэн зүйлээ хуваалцахаас гадна суралцагчдыг хуваалцахад нь урамшуулан дэмж. Та “Энэ шүлгүүдээс ямар үнэнийг олж болох вэ?” эсвэл “Та нар ерөнхийлөгч Монсоны түүхийг уншиж байхдаа алдагдсан хүмүүсийг аврах талаар юу мэдэж авсан бэ?” гэх мэт асуултыг тавьж болно. Бага насны хүүхдүүд зураг зурах, түүх ярих маягаар хуваалцаж болно. Хичээл болгонд суралцагчдад хуваалцах цаг гаргаж өг. Та эдгээр хэлэлцүүлэг нь хичээл болохыг олж мэднэ.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийнхаа гишүүдийг сурсан зүйлээ хуваалцахад хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

**Судрын жишээ:** Лук 10:1-9 дээр Аврагч Өөрийн шавь нарыг Түүнээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахаар илгээсэн болохыг цэдэглэсэн байдаг. Энэ туршлага нь тэднийг хэрхэн адисалсан бэ? (17-24-р шүлгүүдийг үзнэ үү).

### СУРАЛЦАГЧДАД СУДРААС ХАРИУЛТАА ХЭРХЭН ОЛОХЫГ ЗАА

Судрын утга агуулгыг гаргаж чаддаг, судраас өдөр бүр уншдаг хүн ямар



ч саад бэрхшээлийг давж гарахдаа тэнгэрлэг удирдамж хүлээн авах боломжтой. Ийм хүн сүнслэг хүчийн хувьд багшаас хамаарахгүй юм. Зааж байхдаа суралцагчдыг судраас хариулт олохыг шаарддаг асуултуудыг тавьж бай. Тэдэнд өөрсдийн асуултыг хэрхэн тавихыг зааж өгвөл бүр ч сайн. Хэдийгээр судрууд нь олон жилийн өмнө бичигдсэн ч бидэнд байгаа асуулт, тулгардаг асуудлын талаарх Их Эзний хариулт дотор нь агуулагддаг гэдгийг ойлгоход тэдэнд тусал.

**Тунгаан бодох асуулт.** Та ангийн гишүүдэд судраас хариултаа олох илүү сайн туршлагыг олж авахад туслахын тулд ямар зөвлөгөө өгч болох вэ?

**Судрын жишээ.** Би 1 Нифай 19:22-24 болон 2 Нифай 25:1-4 дээр цэдэглэгдсэн Нифайн үлгэр жишээнээс юу сурсан бэ?

### СУРАЛЦАГЧДЫГ ТӨРСӨН МЭДРЭМЖЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭХЭД УРЬ

Суралцагчдыг суралцаж байхдаа Ариун Сүнснээс хүлээн авсан мэдрэмжээ бичиж тэмдэглэхэд урамшуулан дэмж. Бага насны хүүхдүүдийн хувьд зураг зурж эсвэл бодол санаагаа

эцэг эхтэйгээ хуваалцаж болох юм. Заримдаа ангийн ярилцлагын үеэр чанга хэлээгүй зүйлийг хүртэл Сүнс заадаг болохыг суралцагчдад заа. Ахлагч Ричард Г. Скотт: “Сүнснээс сурсан зүйлсээ нандигнан, дэвтэртээ бичиж бай. Та үнэ цэнтэй сэтгэгдлүүдээ бичиж авах тусам тэдгээр нь илүү олноороо ирэхийг харах болно. Түүнчлэн та олж авсан мэдлэгээ амьдралынхаа туршид ашиглах болно”<sup>4</sup> хэмээн заасан байдаг.

**Тунгаан бодох асуулт.** Би хэзээ сүнслэг мэдрэмжээ бичиж авснаараа адислагдаж байсан бэ?

**Судрын жишээ.** Аврагч нифайчуудаас заалгасан зүйлээ бичихийг хүссэн (3 Нифай 16:4; 23:4, 11; 27:23-ыг үзнэ үү). Тэр зарлигаас ямар ямар адислал ирсэн бэ?

1. Дэвид А.Бэднар, “Цөхрөлтгүй сэргэг бай,” *Ensign*, 2010 оны 5-р сар, 42-43 эсвэл 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 59.
2. Брүс Р.Макконки, “Finding Answers to Gospel Questions,” in *Charge to Religious Educators*, 3 дахь хэвлэл (1994), 80; мөн [lds.org/manual/teaching-seminary-preservice-readings-religion-370-471-and-475-ийг](http://lds.org/manual/teaching-seminary-preservice-readings-religion-370-471-and-475-ийг) үзнэ үү.
3. Дийтр Ф.Угдорф, “Та нарын чадавх ба онцгой боломж,” *Ensign*, 2011 оны 5-р сар, 59 эсвэл 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 100.
4. Ричард Г. Скотт, “To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Ensign*, 2002 оны 6-р сар, 32.

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БАЙГАА ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад уриад, асуу. Энэ нь хичээнгүйлэн суралцахад урих хамгийн оновчтой арга байж болох юм.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Дадлага хий.** Хурлын өмнө багш бүрд сайн мэдээний нэг зарчмын талаар судлан, бусад багшид уг зарчмын талаар суралцахад сүнсээр нөлөөлөхөд

бэлдэж ирэх даалгавар өг. Энэ хандлага нь бусдад уг зарчмын талаар зүгээр заахаас юугаараа ялгаатай вэ? Энэ нь суралцагчдыг хэрхэн адислах вэ?

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Сүнслэгээр өдөөгдсөн асуулт тавь

Аврагч Өөрийнх нь заасан үнэний талаар тунгаан бодож, гүнзгий мэдрэмж төрүүлэх асуултуудыг суралцагчдаа тавьдаг байсан. Бидний асуулт бас суралцагчдыг сайн мэдээний үнэний талаар тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэх арга замыг олоход сүнслэгээр өдөөх боломжтой. Сүнслэгээр өдөөгдсөн асуулт нь суралцагчдыг сайн мэдээний үнэнийг өөрөө олж мэдэн, тэдгээрийг дагах, тэдгээрийн талаарх өөрсдийн ойлголтод дүн шинжилгээ хийх урилга болно. Сүнслэгээр өдөөгдсөн асуулт нь сайн мэдээнээс суралцах үйл явцыг илүү сонирхолтой, хувь хүний хувьд илүү утга учир бүхий туршлага болгодог.

### СУРАЛЦАГЧДАД МӨНХИЙН ҮНЭНҮҮДИЙН ТАЛААР ҮНДСЭН МЭДЛЭГ ОЛЖ АВАХАД ТУСЛАХ АСУУЛТУУД ТАВЬ.

Ангийн гишүүд судрын түүхийг эсвэл сайн мэдээний зарчмыг авч хэлэлцэхээс өмнө түүнийг ойлгосон байх ёстой. Таны зарим асуулт суралцагчдыг түүх, зарчмын талаарх үндсэн мэдлэгийг судраас олж авахад урамшуулан дэмжих ёстой. Ийм асуултуудад ихэвчлэн тодорхой хариулт өгөгдсөн байдаг боловч хариултыг өөрсдөө олох нь хамгийн тохиромжтой арга юм. Жишээ нь, хэрэв та Матай 26:36–46-г судалбал, “Эдгээр шүлгээс Гетсеманий цэцэрлэгт Аврагчид тохиолдсон зүйлийг дүрсэлсэн ямар нарийн мэдээлэл олж болох вэ? Тэр бидний төлөө тэнд юу хийсэн бэ?” гэж асууж болно. Эсвэл та бага насны хүүхдүүдэд зааж байвал Гетсеманид Аврагчид тохиолдсон зүйлийг өөрийн үгээр дүрслэн, дараа нь хүүхдүүдээс Есүс тэнд юу хийсэн болохыг ярьж өгөхийг хүсэж болно.

Хэдийгээр уг түүхэнд орсон нарийн мэдээлэл чухал ч гэсэн эдгээр ярилцлагаар үүнээс илүү зүйлсийг авч хэлэлцэх ёстой. Ангийн гишүүдэд сайн мэдээний зарчмуудыг олж мэдэхэд туслах буюу амьдралыг өөрчлөх, мөнхийн үнэнүүдийг олж мэдэхэд туслах асуултуудыг судруудаас тавь.

**Тунгаан бодох асуултууд.** Ангийнхан маань дараагийн хичээлд судрын ямар түүхийг эсвэл зарчмыг ойлгосон байх хэрэгтэй вэ? Би судраас үндсэн ойлголт олж авахад нь тэдэнд туслах ямар асуултыг тавьж болох вэ?

**Судрын жишээ.** Би Лук 10:25–28 дээр Аврагчийн тавьсан асуултуудаас юу сурсан бэ??

### СЭТГЭЛ ЗҮРХ, ОЮУН УХААНД НӨЛӨӨЛӨХ АСУУЛТ ТАВЬ

Суралцагчдыг түүх, зарчмын талаар үндсэн мэдлэгтэй болсны дараа та түүх эсвэл зарчмыг сэтгэл зүрх, оюун ухаанд нь хүргэхийн тулд тэдэнд утга агуулгын талаар тунгаан бодоход туслах асуултууд тавь. Та суралцагчдаас судрын хэсгийн талаар юу бодож байгаа, судар дээрх хүмүүст ямар сэтгэгдэл төрсөн байж болох эсвэл хэсгүүд дээрх үнэн бидний амьдралд ямар хамаатай болох тухай хуваалцахыг хүсэж болно. Эдгээр асуултын хариулт нь ихэвчлэн суралцагчдад төрсөн мэдрэмж, туршлага дээр тулгуурласан байдаг тул асуултын хариу нэгээс илүү зөв хариулттай байдаг. Эдгээр асуултад ихэвчлэн “таны бодлоор” эсвэл “танд ямар мэдрэмж төрж байна” гэсэн үг хэллэг ордог. Жишээлбэл, та “Аврагчтай хамт Гетсемани руу алхаж байхад төлөөлөгчдөд ямар мэдрэмж төрж байсан гэж бодож байна вэ?” Та Есүсийн тэнд хийсэн зүйлийн талаар юу гэж боддог вэ? Аврагчийн цэцэрлэг

дэх зовлон шаналлын улмаас бидний амьдрал хэрхэн адислагдсан бэ?

**Тунгаан бодох асуулт.** Дээрхтэй адил асуултууд нь суралцагчдыг амьдралдаа өөрчлөлт хийхэд хэрхэн сүнсээр өдөөдөг вэ?

**Судрын жишээ.** Аврагч эсвэл судар дээрх хүмүүс зүрх сэтгэлдээ тунгаан бодоход хүргэдэг сүнслэг асуултуудыг хэзээ тавьдаг байсан бэ? (Жишээг Матай 16:13–15; Иохан 1:37–38-аас үзнэ үү).

■ Мөн “Ask Us Questions” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### СУРАЛЦАГЧДЫГ ҮЙЛДЭХЭД УРИХ АСУУЛТ ТАВЬ

Зарим асуулт суралцагчдыг сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэн, сайн мэдээг илүү бүрэн дүүрэн дагах амлалтыг өөртөө өгөхийг сануулдаг. Ихэнхдээ эдгээр асуулт юу хийх ёстой талаар Сүнснээс ирсэн мэдрэмжээ дагахад тэднийг урьдаг байх ёстой. Жишээлбэл, та “Бид Аврагчийн Гетсемани дахь зовлон шаналлын талаар ярилцахад танд ямар сүнслэг мэдрэмж төрсөн бэ?” эсвэл “Та өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан ямар зүйлийг өөрөөр хийх вэ?” гэж асууж болно. Эдгээр нь ярилцлагыг өрнүүлэхэд биш, харин дотроо тунгаан бодоход зориулагдсан асуулт юм. Суралцагчид хүсэж байвал өөрсдийн хариултыг хуваалцаж болно.

**Тунгаан бодох асуулт.** Сүнсээр өдөөгдсөн багш нарын асуулт Есүс Христийг дагах хүслийг маань гүнзгийрүүлж байсан уу?

**Судрын жишээ.** Бид Алмагийн өөрийн хүмүүсийг баптисм хүртэхэд урьсан арга барилаас юу сурч болох вэ? (Мозая 18:7–12-ыг үзнэ үү).

### АНГИ НАМ ГҮМ БОЛОХОД САНДРАХ ХЭРЭГГҮЙ

Сайн асуултад хариулахад цаг хугацаа шаардагдана. Тэд хариулахын тулд тунгаан бодож, эрэлхийлэн хайж, сүнсээр өдөөгдөх хэрэгтэй. Хариулт хүлээхэд зарцуулсан цаг нь тунгаан бодох ариун нандин цаг байж болох юм. Өөрийнхөө асуултад өөрөө хариулах эсвэл өөр сэдэв рүү шилжих гэх мэт энэ хугацааг хурдан дуусгах гэсэн уруу таталтаас зайлсхий. Та хариулт авахын өмнө тэдэнд бодох хугацаа гаргаж өгнө гэдгийг суралцагчдад хэл.

Мөн энэ эх сурвалж дээрх “Суралцагчдыг үйлдэхэд урь” хэсгийг үзнэ үү.

### СУРАЛЦАГЧДЫГ ГЭРЧЛЭЛЭЭ ХУВААЛЦАХАД УРИХ АСУУЛТ ТАВЬ

Суралцагчдад зааж буй зарчмуудын талаарх гэрчлэлээ хуваалцахад урих асуултуудыг тавих нь Сүнснийг урих хүчтэй арга зам байж болно. Суралцагчид эдгээр асуултын талаар тунгаан бодох үедээ Их Эзэний мутар тэдний амьдралд оролцож байсан үеүдийг олж харах болно. Сүнс үнэний талаар гэрчлэх тусам тэдний болон анги дахь бусад хүний гэрчлэл өсөн нэмэгдэх болно. Та тэднийг гэрчлэлээ хуваалцахад урихын тулд “Есүс Христ таны нүглийг гэтэлгэсэн гэдгийг та хэрхэн олж мэдсэн бэ?” эсвэл “Та Аврагчийн Гетсеманид бидний төлөө хийсэн зүйлийн үнэ цэнийг хэрхэн ойлгох болсон бэ?” эсвэл “Танд Есүс Христийн талаар ямар мэдрэмж төрж байна вэ? гэх мэт асуулт тавьж болно.

**Тунгаан бодох асуултууд.** Манай ангийн гишүүдийг гэрчлэлээ хуваалцахад юу нөлөөлсөн бэ? Би тэднийг гэрчлэлээ хуваалцахад хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

**Судрын жишээ.** Мозая 5:1 дээрх Хаан Бенжамин асуулт хүмүүст хэрхэн нөлөөлсөн бэ? (Мөн 2–5-р шүлгүүдийг үзнэ үү). Би зааж байхдаа энэхүү жишээг хэрхэн ашиглаж болох вэ?

### ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЖ ДҮГНЭХ АСУУЛТ ТАВЬ

Алма Зарахемлагийн хүмүүст номлож байхдаа өөрийнхөө үйлдлийг



эргэцүүлэн бодох “Та нар сүнслэг байдлаараа Бурханаас төрсөн үү?” . . . Та нар энэ хүчит өөрчлөлтийг зүрх сэтгэлээрээ эдэлсэн үү?” зэрэг асуултыг тавьсан байдаг (Алма 5:14). Та суралцагчдад биеэ авч явах байдлаа болон сайн мэдээг хэрхэн дагадаг болохоо үнэлж дүгнэх асуултуудыг тавьж болно. Жишээлбэл, танд аравны нэг төлөх итгэл бий юу?” эсвэл “Та гэр бүлдээ хайртай гэдгээ хэлдэг үү? гэх мэт.” Эдгээр асуултад чанга хариулах шаардлагагүй гэдгийг суралцагчдад хэл. Эдгээр асуултын зорилго бол биеэ авч явах байдал, сайн мэдээнд хэр үнэнч болохоо дотроо үнэлж дүгнэхэд суралцагчдад туслах болно.

**Тунгаан бодох асуулт.** Хэзээ сүнсээр өдөөгдсөн асуулт сүнслэг өсөлт хөгжил, үнэнч байдлаа үнэлж дүгнэхэд надад тусалж байсан бэ? Би зааж байгаа хүмүүсээ үнэлж дүгнэх асуултыг өөрөө өөртөө тавихад нь урамшуулан дэмжихийн тулд тэдэнд ямар асуултуудыг тавьж болох вэ?

**Судрын жишээ.** Намайг Иохан 21:15–17-г уншиж байхад Петрт тавьсан Есүс Христийн ямар ямар асуулт миний анхаарлыг татсан бэ?

### ОЙЛГОСОН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТ ТАВЬ

Ангийн гишүүд зарчмыг ойлгосон эсэхийг олж тогтоохын тулд “Та Есүс Христийн Цагаатгалын талаар юу олж мэдсэн бэ?” гэх мэт асуултыг тавь. Суралцагчдыг сайн мэдээний зарчмыг өөрийн үгээр илэрхийлэхэд урьдаг асуултуудыг ялангуяа хичээлийн эхэнд асуух нь уг зарчмыг ангид авч үзэхэд хэр их цаг хугацаа зарцуулагдахыг тодорхойлоход танд тусална.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийн гишүүд юуг ойлгосон гэдгийг өөр ямар арга замаар тодорхойлж болох вэ?

**Судрын жишээ.** Аммон Хаан Лемонийн ойлголтыг хэрхэн тодорхойлсон бэ? (Алма 18:24–36-г үзнэ үү).

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нараас (бие даан эсвэл жижиг бүлгүүд болон) энэ хэсгийн удирдамжийг дагаж, дараагийн хичээлийн үеэр ангийн гишүүдэд тустай байж болох хэд хэдэн асуултыг бичиж тэмдэглэхийг хүс. (Багш нарт бэлдэж ирэхэд нь туслахын тулд тэдэнд энэ урилгыг хурал болохоос хэдэн хоногийн өмнө өгөх нь ашиг тустай

байж болно.) Багш нарыг өөрсдийн асуултыг бие биетэйгээ хуваалцаж, санал бодлоо солилцоход урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Сүнслэгээр өдөөгдсөн ярилцлагыг хөтлөн явуул

Аврагч зааж байхдаа зүгээр л мэдээлэл хуваалцаж байсангүй. Тэр шавь нартаа асуулт тавих, гэрчлэлээ хуваалцах боломж олгодог байсан. Түүний заах, суралцах загвар нь биднийг “бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд” “хаант улсын сургаалыг та нар бие биендээ заах[ад]” (С ба Г 88:77, 122) уриалдаг. Та багшийн хувьд суралцагчдын туршлага, гэрчлэлээр баялаг, урам зориг хайрласан ярилцлагыг урамшуулан дэмжиж болно. Бага насны хүүхдүүд ч гэсэн ихээхэн хувь нэмэр оруулах нь олонтоо. Багшийн хувьд идэвхтэй яриа өрнөсөн ярилцлага хийх нь таны гол зорилго биш боловч энэ нь суралцагчдад Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэн, Түүнтэй илүү адилхан болох гэсэн тэрхүү зорилгыг дэмжиж чадна.

### ЯРИЛЦЛАГА ХИЙХИЙГ УРАМШУУЛАН ДЭМЖДЭГ ОРЧИН ҮҮСГЭ

Сүмийн анги болон цуглаанууд хожмын үеийн гэгээнтнүүдэд бодол санаа, туршлага, гэрчлэлээ хуваалцах замаар бие биеэ хүчирхэгжүүлэх боломжийг олгодог юм. Таны ангидаа бий болгож буй орчин эдгээр харилцаа холбоог урамшуулан дэмжихэд тусалдаг. Таны үг хэл, үйлдэл, тэр ч байтугай гэрэлтүүлэг, сандлын байрлал гээд өрөөний зохион байгуулалт нь харилцан хүндлэл ба идэвхтэй суралцах сүнсийг бий болгоход туслах боломжтой.

**Тунгаан бодох асуулт.** Би сэнхрүүлэх ярилцлагыг илүү их урамшуулан дэмжихийн тулд ангийнхаа орчны юуг өөрчилж болох вэ?

**Судрын жишээ.** Иохан 21:8–12-т цэдэглэгдсэнээр, Есүс шавь нартаа үр дүнтэй заах орчинг бэлтгэхийн тулд юу хийсэн бэ? Би Түүний жишээг хэрхэн дагаж чадах вэ?

■ Мөн “We Share” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### ТУНГААН БОДОХЫГ УРАМШУУЛАН ДЭМЖДЭГ АСУУЛТ ТАВЬ

Сайн ярилцлага нь оновчтой бөгөөд хүмүүсийг сайн мэдээний талаар гүн гүнзгий бодоход урьдаг асуултаас эхэлдэг. Жишээлбэл, та “Иосеф Смитийн Анхны үзэгдлийн түүхэнд

сургаалын ямар үнэнүүдийг заасан байдаг вэ?” эсвэл “Иосеф Смитийн Анхны үзэгдэл миний амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ?” гэх мэт асууж болно.

Ийм төрлийн асуултыг тавихдаа суралцагчдад асуултынхаа талаар тунгаан бодох хангалттай цаг гаргаж өг. Зарим үед асуултыг самбар дээр урьдчилан бичих нь тунгаан бодох боломж олгодог. Түүнээс гадна та асуултад хариулахынхаа өмнө цаг гарган тунгаан бодохыг суралцагчдаас хүсэж байгаагаа тэдэнд хэлж болно. Тэднийг асуултынхаа талаар тунгаан бодож байхдаа Тэнгэрлэг Эцэгээс сүнслэгээр өдөөж өгөхийг дотроо чимээгүй гуйхад урьж болно. Эдгээр нам гүм, тунгаан бодох хоромд Сүнс зүрх сэтгэлд хүрч нөлөөлдөг юм.

**Тунгаан бодох асуулт.** Би дараагийн хичээлд тунгаан бодохыг мөн ярилцлагыг өдөөх ямар асуулт тавьж болох вэ?

**Судрын жишээ.** Би Аврагчийн асуултаас юу сурч болох вэ? (Жишээг Матай 16:13–17; Лук 10:25–26-аас үзнэ үү).

### БҮХ ХҮНД ОРОЛЦОХ БОЛОМЖ ОЛГО

Хүн бүр өөрийн гэсэн хувь нэмэр оруулах боломжтой ч хүн бүрд ийнхүү оролцох боломж олддоггүй. Христтэй адил багш нар зөвхөн

өөрийгөө илэрхийлдэг суралцагчдыг төдийгүй, хүн бүрийн талаар нэг бүрчлэн олж мэдэхийг эрэлхийлдэг. Гэрчлэлээ хуваалцдаг ангийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх арга замыг хайж ол. Жишээлбэл:

■ Та суралцагчдыг хоёр хоёроор нь эсвэл жижигхэн ярилцлага өрнүүлэх бүлгүүдэд эсвэл бишопын зөвлөлөөс зөвшөөрвөл жижигхэн ангиудад хуваарилж болно.

■ Та ангийн гишүүдийг бодол санаа эсвэл мэдрэмжээ бичихэд уриад, тэдний дундах хэд хэдэн хүнээс бичсэн зүйлээ хуваалцахыг хүсэж болно.

■ Та “Одоо хуваалцаагүй байгаа хэн нэгнийг сонсье” эсвэл “Ямар сонирхолтой тайлбар вэ! Бусад нь энэ талаар юу гэж бодож байна вэ?” гэж хэлж болно.

■ Хэрэв та хүүхдүүдэд заадаг бол бүх хүүхдийг оролцуулах энгийн тоглоом тоглуулах талаар бодож үз.

Та тодорхой нэгэн хүнийг хуваалцахаар урихад сүнслэгээр өдөөгдөж болох ба магадгүй тэр хүнд бусад хүнд тус нэмэр болж болох, өөр бодол санаа байж болох юм. “Эх хүний хувьд таны туршлага Христийнхтэй адил хайрын талаар юу зааж өгсөн бэ?” гэх мэт хувь хүний туршлага, хүчтэй талуудыг гаргаж ирэх асуултыг тавих талаар бодож үз.

Суралцагчдын оруулсан хувь нэмэрт талархахаа мартаж, хичээлдээ хэт татагдан орохоос зайлсхийх нь зүйтэй. Тэд таныг санал бодол, гэрчлэлээ хуваалцах хүсэлтэй байгаад нь талархаж байгааг мэдэж байх хэрэгтэй.

**Тунгаан бодох асуулт.** Ангийн гишүүд санал бодлоо илэрхийлэх эсвэл туршлагаасаа хуваалцахаас

## СҮНСЛЭГЭЭР ӨДӨӨГДСӨН АСУУЛТ ТАВЬ

Оновчтой асуулт нь итгэл, гэрчлэлийг хөгжүүлдэг сүнслэгээр өдөөгдсөн ярилцлага мөн зүгээр л сонирхол татсан эсвэл үр ашиггүй ярилцлага хоёрыг өдөр шөнө шиг ялгаатай болгодог. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл, энэ эх сурвалж дээрх “Сүнслэгээр өдөөгдсөн асуулт тавь” хэсгийг үзнэ үү.



гадна өөр ямар арга замаар оролцож болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч орхигдсон хүмүүсийг хэрхэн оролцуулсан бэ? (Марк 10:13–16; Иохан 4:3–42-ыг үзнэ үү).

### СҮНСЭНД ӨӨРИЙГӨӨ ХӨТЛҮҮЛЭХ БОЛОМЖ ОЛГО

Ярилцлагыг удирдан явуулж байхдаа Ариун Сүнсэнд өөрийгөө хөтлүүлэх боломжийг олго. Ярилцлага тань үргэлж эерэг байж, урам зориг өгч байхад анхаарлаа хандуул. Хичээлийн бүх материалыг амжиж заахын тулд сүнслэгээр өдөөгдсөн ярилцлагыг, ялангуяа уг ярилцлагыг зааж байгаа хүмүүст тань чухал гэж үзэж байвал урьтаж бүү тасал.

**Тунгаан бодох асуулт.** Ярилцлага Сүнсээр хөтлөгдөж байгааг би хэрхэн мэдэж болох вэ? Би ярилцлагыг хэзээ дуусгаж, хичээлийг цааш үргэлжлүүлэхээ хэрхэн мэдэж болох вэ?

**Судрын жишээ.** Би Сургаал ба Гэрээ 50:21–22-оос зааж байхдаа Сүнсийг дагах талаар юу сурсан бэ?

### НЭМЖ ТОДРУУЛАХ АСУУЛТ ТАВЬ

Та хэн нэгэн хүнийг сургаалтай холбоотой санаа бодол эсвэл сүнслэг туршлагаа хуваалцаж байхад уг хүнд эсвэл анги дахь өөр хэн нэгэнд хуваалцах өөр зүйл байгааг мэдэрч болно. Нэмж тодруулах асуулт нь нэмж санаа гаргаж ирэхэд өдөөн, илүү гүн ойлголт руу хөтөлдөг. Жишээлбэл, та “Яагаад энэ зарчим танд чухал вэ?” эсвэл “Судрын өөр ямар ямар хэсэг энэ үнэний тухай заадаг вэ?” гэж асууж болно.

**Тунгаан бодох асуулт.** Би заадаг хүмүүсээ ярилцаж байгаа зарчмынхаа талаар илүү гүн гүнзгий бодоход нь хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

**Судрын жишээ.** Аврагч шавь нараа Өөрийн сургаалын талаар илүү гүн гүнзгий бодоход хэрхэн сүнслэгээр өдөөсөн бэ? (жишээг, Лук 24:13–32; Иохан 21:15–18-аас үзнэ үү).

▶ Мөн “Asking Follow-Up Questions” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

### СОНСОХ

Сонсох нь хайрын илэрхийлэл юм. Бид хөтөлбөрт эсвэл тоймд дараа нь юу байгаа вэ гэхээсээ бусад хүний зүрх сэтгэлд юу байгаа вэ гэдэгт анхаарлаа илүү их хандуулж байх хэрэгтэй. Та ангийн гишүүдийн юу хэлж байгааг ойлгоход туслахыг Тэнгэрлэг Эцэгээс хүс. Та тэдний хэлсэн, хэлээгүй зүйлсэд анхаарлаа хандуулбал тэдний хэрэгцээ, сэтгэлийн зовлон шаналал, хүсэл тэмүүлийг илүү сайн ойлгодог болно. Сүнс нь тэдэнд хэрхэн заах, тэдэнд нэмж тодруулах ямар асуулт тавих, хэрэгцээнд нь хэрхэн тохируулахыг олж мэдэхэд танд туслах болно.

**Тунгаан бодох асуулт.** Би хэн нэгэн хүн намайг сонсож байгаа эсэхийг хэрхэн мэдэж болох вэ? Би ангийнхаа гишүүдийг чин сэтгэлээсээ сонсож байгаагаа тэдэнд хэрхэн үзүүлж болох вэ?

**Судрын жишээ.** Алма ядуу зорамчуудыг сонссоноороо юу олж мэдсэн бэ? (Алма 32:4-8-ыг үзнэ үү). Түүний олж мэдсэн зүйл зааж сургахад нь хэрхэн нөлөөлсөн бэ?

Мөн “Миний сайн мэдээг номло,” [2004], 185–186-г үзнэ үү.)

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. Нэг хуралд бүх зүйлийг амжиж заах гэж бүү хичээ.

**Дадлага хий.** Багш нарыг удахгүй заах гэж байгаа сайн мэдээний зарчмын тухай богино ярилцлагыг бүлгийн дотор хөтлөн явуулж дадлага хийхэд урь. Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн

санаануудыг ашиглахад урамшуулан дэмж (санал болгосон видео бичлэг тус болж болно). Дараа нь, багш нар юу нь сайн болсон, юун дээрээ ажиллах хэрэгтэй болохыг ярилцаж болно.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Суралцагчдыг үйлдэхэд урь

Аврагч хүмүүсийн амьдралыг өөрчлөхийн тулд заадаг байсан. Тэрээр төлөөлөгчдөө зөвхөн Өөрийнх нь үгийг сонсоод зогсохгүй тэднийг Өөрийн сургаалын дагуу итгэлтэйгээр үйлдэхэд урьдаг байсан. Заасан сургаалынх нь дагуу амьдарсан дагалдагчид энэ нь Бурханаас ирсэн гэж мэдэх болно гэдгийг Тэрээр мэдэж байсан (Иохан 7:17-г үзнэ үү). Түүний сургаалууд үймээн самуун, төөрөгдөл, тэмцлийн үед тэднийг хамгаалах юм (Матай 7:24–27-г үзнэ үү). Нэг хичээлээр итгэлийг хөгжүүлэн, Христтэй адилхан болгох боломжгүй гэдгийг бүү март. Зааж байгаа хүмүүсээ үнэн сургаалын дагуу үйлдэхэд урихдаа тэдэнд сурсан зүйлээ гэр орондоо болон өдөр тутмын амьдралдаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд тусал (С ба Г 43:8–10-ыг үзнэ үү).

### СОНГОХ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН УРИХ

Хүмүүс өөрчлөлтийг сонгох эрхийнхээ дагуу хийвэл амьдралдаа утга учир бүхий өөрчлөлтүүдийг хийх магадлал өндөр байдаг. Та үйлдэх урилгыг өгөхдөө зааж байгаа хүмүүсийнхээ сонгох эрхийг хүндлэх хэрэгтэй. Жишээлбэл, үргэлж тодорхой нэгэн зүйлийг хийхэд урихын оронд суралцагчдыг сурсан зүйлээ ямар арга замаар амьдралдаа хэрэгжүүлж болох тухай бодоход урих талаар бодож үз. “Та нар ах, эгч, дүү нартайгаа харилцаагаа хэрхэн сайжруулж болох вэ?” эсвэл “Та хүлээн авсан нэг сүнслэг мэдрэмжээ мөн уг мэдрэмжийнхээ дагуу хэрхэн үйлдэж болох талаар бичнэ үү” гэж хэлж болно.

**Тунгаан бодох асуулт.** Хэзээ багшийн өгсөн үйлдэх урилга сонгох эрхээ хөгжүүлэхэд минь тусалж байсан бэ?

**Судрын жишээ.** Аврагч сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлийг ярьсныхаа дараа, “Явж, үүний адил үйлдэгтүн” (Лук 10:37) хэмээн хэлсэн байдаг. Би Аврагчийн өгсөн энэ болон өөр бусад урилгаас юу сурч болох вэ?

### АМЛАГДСАН АДИСЛАЛУУДЫГ ГЭРЧИЛ

Их Эзэн зарлиг өгөхдөө, уг зарлигийг сахиснаар ирэх адислалуудыг үргэлж амласан байдаг. Та суралцагчдад ямарваа нэгэн зарлигийн дагуу амьдрах урилгыг өгөхдөө, уг зарчмын дагуу амьдарснаар ирэх Бурханы адислалуудыг олж нээхэд тусал. Түүнээс гадна та уг зарчмын дагуу амьдарснаар хүлээн авсан адислалуудынхаа тухай гэрчлэлээ хуваалцаж болно.

**Тунгаан бодох асуулт.** Би хэзээ амлагдсан адислалуудын тухай гэрчлэлийг сонссон учраас сайн мэдээний зарчмын дагуу амьдрахад сүнслэгээр өдөөгдөж байсан бэ?

**Судрын жишээ.** Аврагч шавь нараа сүнслэгээр өдөөхийн тулд амлалтуудыг хэрхэн ашигладаг байсан бэ? (Лук 12:22–31-ийг үзнэ үү).

### ҮЙЛДЭХ УРИЛГЫН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВЬ

Та үйлдэх урилгын гүйцэтгэлд хяналт тавьснаар суралцагчдадаа санаа тавьдаг гэдгээ мөн сайн мэдээ тэдний амьдралыг хэрхэн адисалж байгааг харуулж байгаа юм. Түүнээс гадна та тэдэнд туршлагаасаа хуваалцах боломж олгохоос гадна эргээд үүргээ биелүүлэхэд нь тэднийг

хүчирхэгжүүлж, сайн мэдээний дагуу амьдрахад нэг нэгэндээ дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжийг олгодог. Урилгын гүйцэтгэлд хяналт тавих хэд хэдэн арга зам байдаг. Жишээлбэл, та хичээлийн эхэнд суралцагчдад урилгын дагуу ямар үйлдэл хийснээ хуваалцах цаг гаргаж өгч болно. Эсвэл та ангийн гишүүдэд мессеж, э-мэйл илгээн гүйцэтгэлийг нь хянаж болно.

Хэрэв та хичээлийг өөр багштай хувааж, нэг нэг долоо хоногоор солигдож заадаг бол гүйцэтгэлийг нь хянахын тулд зохицуулалт хийх шаардлага гарч болох юм. Жишээлбэл, та хичээлийн эхэнд өмнөх долоо хоногт нөгөө багшийн өгсөн урилгын гүйцэтгэлийг хянаж, нөгөө багшаас мөн адил хийхийг хүсэж болно. Эсвэл туслах бүлэг, чуулгын эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдэд урилгын гүйцэтгэлийг хянах үүргийг хүлээлгэн өгч болно.

**Тунгаан бодох асуулт.** Үйлдэх урилгын гүйцэтгэлийг хянах нь яагаад чухал байдаг вэ?

**Судрын жишээ.** Аврагч хийсэн, заасан бүхнээ Түүнд айлтгах боломжийг олгохын тулд төлөөлөгчидтэйгөө цугларч уулздаг байсан (Марк 6:30-ийг үзнэ үү). Би үйлдэх урилгынхаа гүйцэтгэлийг хэрхэн хянаж болох вэ?

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БУЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуултууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон

санааны талаар ярилцахад урь. “Invite Us to Act” (LDS.org) видео бичлэгийг үзэн, ярилцах талаар бодож үз. ▶

**Дадлага хий.** Багш нарыг дараагийн заах хичээлийнхээ талаар бодоод, суралцагчдынхаа насанд тохирсон

боломжит урилгыг бичиж тэмдэглэхэд урь. Тэднийг бусадтайгаа бичсэн зүйлээ хуваалцаад, санал бодлоо хэлэхэд урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.

## Гэр орондоо сайн мэдээнээс суралцахыг дэмж

Багшийн хувьд таны зорилгуудын нэг нь зааж байгаа хүмүүсээ судар дээрх зүйлийн талаар хувиараа болон гэр бүлийнхээ хамт өөрийн гэсэн туршлагатай болоход нь урамшуулан дэмжих явдал юм. Та ангид цагаа хэчнээн үр дүнтэй ашигласан ч энэ нь хувиараа болон гэр бүлээрээ судраас судлах буюу Сүнсний хүмүүст ганцаарчлан заах тэр цаг хугацааг орлож чадахгүй юм. Багш хүний хувьд таны амжилт ололт олон талаараа ангийнхаа гишүүдийг хэрхэн бие даан суралцахад тусалж, урамшуулан дэмжсэнээр хэмжигдэнэ.

### ХУВИАРАА БОЛОН ГЭР БҮЛЭЭРЭЭ САЙН МЭДЭЭНЭЭС СУРАЛЦАХЫГ УРАМШУУЛАН ДЭМЖ

Таны Ням гаргийн ангийн хичээл ангийн гишүүдийн сайн мэдээнээс суралцдаг гол орчин байх ёсгүй боловч энэ нь сайн мэдээг бие даан болон гэр бүлтэйгээ суралцах урам зориг, сүнслэг удирдамжийг хүлээн авах газар нь байх ёстой.

Танд гэр орондоо бие дааж мөн гэр бүлээрээ суралцахад урамшуулан дэмжих олон арга зам бий. Сайн мэдээний нэг багш хичээл бүрийнхээ эхний хэдэн минутыг ангийн гишүүдэд бие даан болон гэр бүлээрээ судраас суралцаж байхад нь сүнс-лэгээр өдөөсөн ямар нэгэн зүйлийг хуваалцахад зориулдаг байсан. Эхлээд цөөхөн хүн хуваалцдаг байв. Харин багш нь энэ загвараа үргэлж-лүүлсээр байсан тул ангийн улам олон гишүүн хуваалцдаг болжээ. Ангийн нэг гишүүн: “Манай багш хичээлээ сайжруулах зорилгоор биш, харин уншсан зүйл маань бидний амьдралыг адисална гэдгийг мэддэг байсан учраас биднийг уншихад урьдаг байсан. Дараа нь бид Бурханы судраар дамжуулан бидэнд заасан зүйлс түүний хувьд чухал болохыг ойлгосон бөгөөд энэ нь бидний хандлагыг ихээхэн өөрчилсөн юм.

Би одоо судрыг илүү учир утгатай уншдаг болсон гэдгийг багтай хэлж чадна” хэмээн хэлсэн байна.

Хувиараа болон гэр бүлээрээ судраас суралцахад бусдыг урамшуу-лан дэмжих өөр нэгэн арга зам бол ангийн гишүүдийг ангид сурсан ямар нэгэн зүйлээ гэр бүлийн-хэнтэйгээ эсвэл найз нөхөдтэйгөө хуваалцахад урих явдал юм.

**Тунгаан бодох асуулт.** Би сурал-цагчдыг бие даан сайн мэдээнээс суралцахад урамшуулан дэмжихийн тулд юу хийж болох вэ? Би хүүхдэд заадаг бол юу хийж болох вэ?

**Судрын жишээ.** 1 Нифай 15:23–25 дээр цэдэглэсэн Нифайн үг надад ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ? Бид түүний үлгэр жишээг зааж байхдаа хэрхэн дагаж чадах вэ?

### СУРАЛЦАГЧДАД БИЕ БИЕЭ ДЭМЖИХЭД НЬ ТУСАЛ

Зарим хүн судрыг судлах нь хэцүү гэж боддог учраас гэртээ судраас суралцдаггүй. Зарим нь сайн мэдээг гэр орондоо суралцсанаар ирдэг адислалуудыг сайн ойлгодоггүй. Та суралцагчдад нэг нэгнээ урамшуу-лан дэмжиж, хэрэг болохуйц санаа болон туршлагаа нээлттэй хуваал-цаж болох орчинг ангидаа бүрдүүлж өгснөөр тэдэнд дээрх хоёр саад

бэрхшээлийг хоёуланг даван гарахад тусалж чадна.

Хуучин Гэрээнээс суралцаж байсан сайн мэдээний нэг ангид ахимаг насны нэгэн ах Исаиагийн номыг ойлгохгүй байгаадаа бухимдаж бай-гаагаа илэрхийлжээ. Багш өөрийнхөө бодлыг илэрхийлсэнд түүнд талархал илэрхийлээд, ангийн бусад гишүүд дунд энэ талаар зөвлөгөө өгөх хүн байгаа эсэхийг асуув. Ангийн хэдэн гишүүн судраас суралцах арга бари-лаасаа мөн Исаиагийн үгсийг судалж байхдаа олж авсан сүнс-лэг туршла-гаасаа хуваалцсан байна. Ангийн нэг гишүүн: “Бид тэр ахыг тойрон хүрээлсэн байлаа. Ангид гайхалтай нэгдмэл уур амьсгал бий болсон байв. Бид үнэхээр энэ зүйлд хамтдаа байгаа шүү гэсэн мэдрэмж төрж байсан” хэмээн дурсан хэлсэн байна.

**Тунгаан бодох асуулт.** Би ангийн-хаа гишүүдийг судраас суралцаж байхдаа утга учир бүхий туршлага олж авахад хэрхэн сүнс-лэгээр өдөөж болох вэ?

**Судрын жишээ.** “Бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд” гэдэг нь юу гэсэн утгатай үг вэ? (С ба Г 88:122). Би хичээлийн ярилцлагын явцад суралцагчдын нэг нэгнийгээ сэнхрүүлэх хүслийг нь хэрхэн урам-шуулан дэмжиж болох вэ?

## ЯРИЛЦЛАГЫГ УДИРДАЖ БҮЙ ХҮНД

**Хамтдаа хуваалцан, зөвлөлд.** Эхлээд багш нарыг хамгийн сүүлд заасан туршлагаасаа хуваалцахад урин, тэдэнд заахтай холбоотой асуулууд тавь.

**Хамтдаа суралц.** Багш нарыг энэ хэсэгт авч үзсэн нэг эсвэл түүнээс олон санааны талаар ярилцахад урь.

**Урь.** Дараагийн хэдэн хичээлийн явцад ангийн гишүүдэд гэртээ сурсан зүйлээ хуваалцах цаг гаргаж өгөхөд багш нарыг урь. Дараагийн багшийн зөв-лөлийн хурлаар өөрсдийн туршлагаас хуваалцахыг тэднээс хүс. Гэр орон-доо сайн мэдээг сурах гэсэн хичээл

зүтгэлийг нь хэрхэн дэмжих талаар өөр зөвлөгөө байвал хуваалцахад тэднийг урь.

**Бэлтгэ.** Дараагийн хурлынхаа сэдвийг хамтдаа ярилцаад, багш нарыг бэлдэж ирэхэд урь.



## Христтэй адил багш болон сайжрах нь: Хувийн үнэлгээ

Төлөөлөгч Паул гэгээнтнүүдийг “итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал” (2 Коринт 13:5) хэмээн уриалсан байдаг. Багшийн хувьд бид ч гэсэн Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, Түүнтэй илүү адил болоход нь суралцагчдаа туслахын тулд өөрсдийн ур чадварыг үргэлж сайжруулж, хүчтэй болон сул талуудаа олж тодорхойлох шаардлагатай. Та сайжрахыг эрэлхийлж байхдаа Их Эзэний: “Мөн чи өөрийн сул доройг харсны учир чи . . . хүчирхэг болгогдох болно” гэсэн амлалтыг бүү март (Ифер 12:37). Аврагчийн таныг болоосой хэмээн хүсэж байгаа тэрхүү багш нь болохын тулд та тэвчээртэй байж, Аврагчийн хүчирхэгжүүлэх хүчийг эрэлхийл.

Дараах үйл ажиллагаа нь Христтэй адил заах зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслах болно. Дараах тодорхойлолтуудыг нэг бүрчлэн уншаад, багшийн хувьд таныг хэр сайн тодорхойлж байгааг авч үзнэ үү. Асуулт бүрд хамгийн зохимжтой гэж үзсэн хариултыг сонго:

1 = хэзээ ч үгүй 2 = заримдаа 3 = ихэвчлэн 4 = бараг үргэлж

Дараа нь Сүнсээр удирдуулан, сайжруулахыг хүсэж байгаа хэдэн зүйлээ залбирч сонго. Хэдэн зорилго тавьж, энэ эх сурвалж дээрх хэсгүүдийг өөрийгөө сайжруулахад ашигла. Өсөлт хөгжлөө дүгнэхийн тулд энэ үйл ажиллагааг ойр ойрхон хийж бай.

### ЗААЖ БАЙГАА ХҮМҮҮСЭЭ ХАЙРЛА

- \_\_\_ Би зааж байгаа хүмүүсийнхээ төлөө залбирдаг.
- \_\_\_ Би зааж байгаа хүмүүстээ хайртай гэдгээ илэрхийлдэг.
- \_\_\_ Би зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээ, туршлагыг ойлгодог.
- \_\_\_ Би хичээлдээ бэлдэхдээ хичээлээ хэрхэн заахад биш, харин зааж байгаа хүмүүстээ анхаарлаа төвлөрүүлдэг.
- \_\_\_ Би бэлдсэн бүх зүйлээ заахыг хичээхийн оронд Сүнсээр өдөөгдсөн үед суралцагчдын асуулт,

хэрэгцээнд тохируулахаар төлөвлөгөөгөө өөрчилдөг.

- \_\_\_ Би хичээлдээ ирэхгүй байгаа хүмүүст хүрч ажилладаг.

### СҮНСЭЭР ЗАА

- \_\_\_ Би амьдралдаа болон багшийн хувьд хичээл зүтгэл гаргахдаа Сүнсний удирдамжийг хүлээн авахын тулд залбирдаг.
- \_\_\_ Би Ариун Сүнсний нөхөрлөлийг хүлээн авахуйц зохистой амьдрахыг хичээдэг.
- \_\_\_ Би хичээлдээ бэлдэж, зааж байхдаа сүнслэг өдөөлт сонсдог бөгөөд тэдгээрийн дагуу төлөвлөгөөгөө тохируулан өөрчлөх итгэл надад бий.
- \_\_\_ Би зааж байгаа хүмүүстэйгээ гэрчлэлээ хуваалцдаг.
- \_\_\_ Би зааж байгаа хүмүүстээ Сүнсний нөлөөг таньж мэдэхэд тусалдаг.
- \_\_\_ Би хичээлдээ долоо хоногийн өмнөөс бэлдэж эхэлдэг бөгөөд хүлээн авсан сүнслэг мэдрэмжүүдээ бичиж тэмдэглэдэг.
- \_\_\_ Ангийн маань орчин Сүнсийг урин авчирдаг.

### СУРГААЛЫГ ЗАА


- \_\_\_ Миний хичээл судрууд болон хожмын үеийн бошиглогчдын үгс дээр төвлөрдөг.

- \_\_\_ Боломжтой бол би зааж байгаа хүмүүстээ сургаалыг ойлгоход нь туслах зорилгоор түүх, дуу хөгжим, урлагийн бүтээл, бусад зохих эх сурвалжийг ашигладаг.

- \_\_\_ Хэцүү асуулт гарч ирвэл, би итгэлийг хөгжүүлэх арга замаар хариулдаг.

### ХИЧЭЭНГҮЙЛЭН СУРАЛЦАХАД УРЬ

- \_\_\_ Би зааж байгаа хүмүүстээ бие даан сурах үүрэг хариуцлагыг өөрсдөдөө авахад тусалдаг.
- \_\_\_ Би тунгаан бодоход урамшуулан дэмждэг асуулт тавьдаг.
- \_\_\_ Би суралцагчдыг бодол санаа, гэрчлэлээ хуваалцан, бие биеэ хүчирхэгжүүлэхэд урьдаг.
- \_\_\_ Би суралцагчдад сайн мэдээний зарчмуудын талаар илүү гүн гүнзгий тунгаан бодоход урамшуулан дэмжих, тодотгох асуултууд тавьдаг.
- \_\_\_ Би суралцагчдынхаа бүх асуултад өөрөө хариулахын оронд тэднийг өөрсдөө хариултаа олоход нь тусалдаг.
- \_\_\_ Би бүх суралцагчид ярилцлагад оролцох боломж олгодог.
- \_\_\_ Би суралцагчдыг сурсан зүйлийнхээ дагуу Сүнсний удирдамжаар үйлдэхэд урьдаг.
- \_\_\_ Би үйлдэх урилгынхаа гүйцэтгэлийг хянадаг бөгөөд суралцагчдаас туршлагаасаа хуваалцахыг хүсдэг.
- \_\_\_ Би суралцагчдыг судруудыг бие даан мөн гэр бүлээрээ суралцахад урамшуулан дэмждэг.



“Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө” (Ифер 12:27).

## Шинэ багш нарыг чиглүүлэх нь: Санваарын болон туслах бүлгийн удирдагчдын үүрэг хариуцлага

Хэрэв та санваарын болон туслах бүлгийн удирдагч бол “[өөрсдийн] бүлгийн шинээр дуудагдсан багш бүртэй боломжтой бол анхны хичээлээс нь өмнө биечлэн уулзах” үүрэгтэй (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* [2010], 5.5.3). Эдгээр уулзалт нь шинэ багшийг ариун дуудлагатай нь танилцуулан, тэднийг Аврагчийн арга барилаар заах гэдэг нь юу болох талаарх алсын хараагаар урамшуулах боломж юм. Та удирдагчийн хувьд дараах зүйлсийг хийж, шинэ багш нарыг үйлчлэхэд бэлтгэхэд нь тусалж чадна.

### АВРАГЧИЙН АРГА БАРИЛААР ЗААХ ГЭДЭГ НЬ ЯМАР УТГАТАЙ ҮГ БОЛОХЫГ ЯРИЛЦ

Шинэ багшид Аврагч хэрхэн зааж байсныг, багш байх гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход туслахын тулд тэдэнтэй дараах зарчмыг ярилц. Үүнд:

■ *Зааж байгаа хүмүүсээ хайрла.* Шинэ багшид зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээнд анхаарлаа хандуулахад тусал. Шинэ багшийг тэдний давуу тал, онцгой хэрэгцээг олж мэдэхэд урь. Шаардлага гарвал ангийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг өг. Шинэ багшид ангидаа тогтмол суудаггүй суралцагчдад туслах үүрэг хариуцлагатай гэдгийг сануул. Багшийг эдгээр хүнд хүрч туслах арга замыг залбирч эрэлхийлэхэд урь.

■ *Сүнсээр заа.* Сүнслэг байдлаар заахад бэлтгэхийн ач холбогдлын тухай ярилц. Ариун Сүнсний өдөөлт бага багаар ирдэг учраас шинэ багшийг хамгийн багадаа долоо хоногийн өмнөөс заахад бэлдэж, сүнслэг өдөөлтийг эрэлхийлж байхад урамшуулан дэмж.

■ *Сургаалыг заа.* Бурханы үгийн зүрх сэтгэлийг өөрчилдөг хүчний тухай гэрчлэлээ хуваалц. Шинэ багшийг товлосон заах сэдвээр аливаа нэмэлт

материалыг судлахын өмнө судруудыг болон амьд бошиглогчдын үгсийг судлахад урь. Багшийг судалж байхдаа хүлээн авсан сүнслэг мэдэрэмжээ бичиж тэмдэглэн, итгэлийг хөгжүүлж, Христийнхтэй адил амьдралаар амьдрахад урамшуулан дэмждэг зарчмууд дээр анхаарлаа хандуулахад урамшуул.

■ *Хичээнгүйлэн суралцахад урь.* Заах нь хичээлийг зүгээр нэг танилцуулах биш, хүмүүсийг сайн мэдээнээс бие даан суралцах үүрэг хариуцлагаа өөрсөд дээрээ авч, сайн мэдээний суралцагчийн хувьд нэг нэгнийгээ сэнхрүүлэхэд урамшуулан дэмжих явдал юм гэдгийг ойлгоход шинэ багшид тусал (С ба Г 88:122-ыг үзнэ үү).

### ӨӨРИЙН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР ЯРИЛЦ

Та шинэ багштай Христтэй адил заах ерөнхий зарчмыг ярилцахаас гадна, байгууллагынхаа талаар түүнд тус болох бүх зүйлийг цаг гарган хуваалц. Танд ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд авч хэлэлцэх мөн багшийг мэдээсэй хэмээн хүсэж буй аливаа шаардлага байгаа юу? Жишээлбэл, ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл чуулгын эв нэгдлийг онцлох нь зүйтэй хэмээн


сүнслэгээр өдөөгдсөн бол чуулгын багш нар тэрхүү зорилгыг нь хэрхэн дэмжиж болох вэ? Бишоп тойргийн зөвлөлөөс тойрог дахь бишрэл хүндэтгэлтэй байдлыг сайжруулахыг хүссэн бол Хүүхдийн хэсгийн багш нар үүнд хэрхэн тусалж болох вэ?

Шаардлага гарвал, шинэ багшид аль өрөөнд заах, аль хичээлээс эхлэхийг хэлж өгөхөөс гадна анги, ангийн гишүүдийн талаар мэдэх хэрэгтэй бүх мэдээллийг өгөх нь зүйтэй.

### ҮРГЭЛЖ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БАЙ

Та шинэ багшид дуудлагаа хийхэд нь бүхий л арга замаар тусалж, шаардлагатай бол ангид дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжтой гэдгийг тайлбарла. Тэр ч байтугай үе үе шинэ багшийн ангид ажиглалт явуулж, санал бодлоо хуваалцана гэдгээ хэл. Багшид энэ эх сурвалжийн нэг хувийг өгөөд, сар бүрийн багшийн зөвлөлийн хурал хэзээ болохыг тайлбарла. Энэ хурлын зорилгыг мөн шинэ багшийг уг хуралд оролцоно гэдэгт найдаж байгаагаа тайлбарлаж хэл.

Шинэ багшийг багшийн хувьд хэрхэн өсөж хөгжих талаар илүү ихийг мэдэхийн тулд LDS.org-ийн My calling буюу Миний дуудлага хэсэг руу орж үзэхэд урь.



“Сүмийн шинэ гишүүн ч гэсэн үйлчлэх дуудлагад зүрх сэтгэл хамгийн чухал гэдгийг мэдэрдэг. Бид бүх зүрх сэтгэлээ Эзэнд өгч, Түүний зарлигуудыг дагаснаараа Түүнийг хэн болохыг таньж мэддэг. . . . Тэдэнд [үйлчлэхээр дуудагдсан хүмүүст] Есүс Христийн сэргээгдсэн Сүмд үйлчлэхээр дуудагдана гэдэг нь юу гэсэн утгатай үг болохыг сүнслэг нүдээр харах нь үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлэхэд бэлтгэгдэхээс

илүү чухал зүйл билээ” (Хэнри Б.Айринг, “Rise to Your Call,” *Ensign* эсвэл *Liahona*, 2002 оны 11-р сар, 75).



ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

